

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-20
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	21-92
1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	23-24
2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/	24-35
3.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	36-43
4.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	43-45
5.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нарын 89 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/	45-47
6.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	47-68
7.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	78-92

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
07 дугаар сарын 02-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Амгаланбаатар, Х.Баттулга, Б.Дэлгэрсайхан, Д.Цогтбаатар, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, П.Батчимэг, Х.Болормаа, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Лүндэг, П.Мөнхтулга, З.Мэндсайхан;

Тасалсан: Ж.Батсуурь, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Ж.Батжаргал -1 цаг 07 минут, Д.Батлут -1 цаг 27 минут, О.Батнайрамдал -32 минут, Ж.Бат-Эрдэнэ -13 минут, Б.Бейсен -32 минут, Ж.Галбадрах -31 минут, С.Ганбаатар -1 цаг 18 минут, Д.Ганбат -05 минут, Х.Ганхуяг -2 цаг 57 минут, Ц.Даваасүрэн -1 цаг 09 минут, Г.Дамдинням -2 цаг 35 минут, Б.Жавхлан -1 цаг 05 минут, Д.Жаргалсайхан -1 цаг 22 минут, Б.Заяабал -05 минут, Т.Мөнхсайхан -22 минут, Ц.Мөнхтуяа -13 минут, П.Наранбаяр -3 цаг 09 минут, С.Одонтуяа -22 минут, Б.Пунсалмаа -04 минут, Б.Пүрэвдаваа -1 цаг 06 минут, Ц.Сандаг-Очир -20 минут, О.Саранчулуун -12 минут, Ц.Туваан -25 минут, Б.Тулга -04 минут, Г.Тэмүүлэн -2 цаг 50 минут, А.Ундраа -09 минут, Ч.Ундрэм -09 минут, Н.Учрал -1 цаг 18 минут, Д.Үүрийнтуяа -02 минут, Ж.Чинбүрэн -2 цаг 50 минут, Б.Чойжилсүрэн -02 минут, Ж.Энхбаяр -16 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг 2025.07.02-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүнээс 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нарын 89 гишүүнээс 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа нарын 40 гишүүнээс 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./14:13/

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу цаг товлон явуулахаар хойшлуулав./14:17/

Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Амармөрөн, Ц.Баянмөнх, Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Эрдэнэболд, О.Номинчимэг, Б.Жаргалан, Ж.Алдаржавхлан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, хуулийн төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор явуулах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу цаг товлон явуулахаар хойшлуулав./14:57/

Гурав.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ч.Батбямба, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, Г.Хосбаяр, Д.Энхтүвшин нарын тавьсан асуултад хуулийн төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу цаг товлон явуулахаар хойшлуулав./15:20/

Дөрөв.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу цаг товлон явуулахаар хойшлуулав./15:28/

Тав.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нарын 89 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн

албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу цаг товлон явуулахаар хойшлуулав./15:36/

Зургаа.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх И.Баттөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, О.Номинчимэг, Да.Цогтбаатар, С.Зулпхар, Ж.Алдаржавхлан, Ц.Баатархүү, С.Эрдэнэбат, Д.Пүрэвдаваа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэв.

Мөн Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанаас 2 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 2 цагийн завсарлага өгөв./16:57/

Хуралдаан 18 цаг 09 минутаас үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ чуулганы нэгдсэн хуралдаанаас Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./18:09/

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан завсарлага авах хүсэлтээ цуцалснаа мэдэгдэв./18:10/

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур нар байлцав.

Д.Амарбаясгалан: Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	46
Бүгд:	106

56.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн

байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Н.Алтаншагай, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Ө.Шижир /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.26 дахь хэсгийн “Хүний эрхийн Үндэсний Комисс,” гэсний дараа “Үндэсний статистикийн хороо,” гэж, мөн заалтын 21.25, 21.30 дахь хэсгийн “мэдээллийг” гэсний дараа “санаатайгаар” гэж, мөн зүйлийн 5 дахь заалт буюу 23.8.1 дэх заалтын “судлах,” гэсний дараа “холбогдох Байнгын хорооны саналыг үндэслэн тухайн асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах, сонсох,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 31
Бүгд: 106
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 21.26 дахь хэсгийн “21.25-д” гэснийг “21.24-д” гэж, мөн заалтын 21.28 дахь хэсгийн “Улсын Их Хуралд” гэснийг, мөн 21.30 дахь хэсгийн “Нэгдсэн хуралдаанд” гэснийг “Улсын Их Хурлын асуулгын цаг, Тусгай хяналтын дэд хорооны сонсгол, Хяналт шалгалтын түр хорооны сонсгол болон Хяналтын сонсголд, эсхүл нэгдсэн хуралдаанаар гишүүний асуулгын хариу, улсын төсөв, төсвийн төсөл, гүйцэтгэлийн хэлэлцэхэд” гэж тус тус, мөн 21.28 дахь хэсгийн “тухайн нам, эвслийн бүлэг, эсхүл 10-аас” гэснийг “нам, эвслийн бүлэг, эсхүл 20-оос” гэж, 21.30 дахь хэсгийн “32.7-д” гэснийг “32.8-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 24
Бүгд: 106
77.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 21.24 дэх хэсгийн “Тусгай хяналтын дэд хороо,” гэсний дараа “Хяналтын сонсгол болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 24
Бүгд: 106
77.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 22.6.7 дахь заалтын, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 23.7 дахь хэсгийн, мөн зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.3 дахь заалтын “Нийгмийн бодлого, боловсрол,

соёл, шинжлэх ухааны” гэснийг “Хүний хөгжил, нийгмийн бодлогын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 28
Бүгд: 107
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Ч.Номингийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.3 дахь заалтын, мөн зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.14 дэх заалтын “Шинжлэх ухааны” гэснийг “Боловсрол, шинжлэх ухааны” гэж, 27.5.1 дэх заалтын “асуудлаарх” гэснийг “талаарх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 25
Бүгд: 107
76.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.7 дахь заалтын “Эдийн засгийн байнгын хороонд” гэсний дараа “Аялал жуулчлалын хөгжлийн,” гэж нэмж, мөн зүйлийн 7 дахь заалтад доор дурдсан агуулгатай 27.5.2 дахь заалт нэмэх:

“27.5.2.Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо нь аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын асуудлыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83
Татгалзсан: 24
Бүгд: 107
77.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.9 дэх заалтын “тагнуулын гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 27.5.11 дэх заалтын “явуулж байгаа” гэсний дараа “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагад харьяалуулснаас бусад” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 25
Бүгд: 107
76.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 25

Бүгд: 107
76.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 23.11.21, 23.11.22, 23.11.23 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.7 дахь заалтын “Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн,” гэснийг, мөн зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.4 дэх заалтыг, төслийн 6 дугаар зүйлээс “22.6.1,”, “23.1” гэснийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 28
Бүгд: 107
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, С.Зулпхар, Ц.Мөнхтуяа, Л.Энхнасан нарын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 23.7.1, 23.7.3, 23.7.4, 23.7.6, 23.7.7, 23.7.8, 23.7.11 дэх заалтыг, мөн зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.3 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.6, 27.5.14 дэх заалтыг хасаж, 6 дугаар зүйлийн “22.6.4-22.6.6” гэснийг “22.6.5, 22.6.6” гэж, “23.4-23.6” гэснийг “23.5, 23.6” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 60
Бүгд: 107
43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, С.Зулпхар, Ц.Мөнхтуяа, Л.Энхнасан нарын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 23.7.1, 23.7.3, 23.7.4, 23.7.6, 23.7.7, 23.7.8, 23.7.11 дэх заалтыг, мөн зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.3 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.6, 27.5.14 дэх заалтыг хасаж, 6 дугаар зүйлийн “22.6.4-22.6.6” гэснийг “22.6.5, 22.6.6” гэж, “23.4-23.6” гэснийг “23.5, 23.6” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 33
Бүгд: 107
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын 27.3.6 дахь заалтын “Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулах дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.9 дэх заалтын “тагнуулын гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон гүйцэтгэх” гэж өөрчлөх гэсэн саналаар санал хураалт явуулах дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.11 дэх заалтыг хасах гэсэн саналыг хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 69^{1.3} дахь хэсгийн “Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт төсвийн төслийн талаарх илтгэлийг Ерөнхий сайд танилцуулна.” гэснийг хасаж, мөн хэсгийн “илтгэлд” гэснийг “танилцуулгад” гэж, мөн зүйлийн 69^{1.5} дахь хэсгийн “69^{1.3}-т” гэснийг “69^{1.4}-д” гэж, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 73^{1.1} дэх хэсгийн “хууль болон хамт баталсан хууль, тогтоолд” гэснийг “хуульд” гэж, “хууль, тогтоол” гэснийг “хуулийг” гэж, “хоригийн шинж байдлыг харгалзан” гэснийг “Төсвийн байнгын хорооны саналаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 84
Татгалзсан: 24
Бүгд: 108
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 64.1.1 дахь заалтын “, үг хэлэх” гэснийг “үг хэлж болно. Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод,

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлнэ;” гэж, 64.1.3 дахь заалтын “үг хэлэх” гэснийг “үг хэлж болно. Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 64.1.2-т заасан санал тус бүрээр ил санал хураалт явуулна;” гэж өөрчилж, 64.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“64.1.2.хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно. Байнгын хороод зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо хамтарсан хуралдаанаар Байнгын хороодын санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	87
Татгалзсан:	21
Бүгд:	108

80.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 64.1.4 дэх заалтын “төсвийн” гэснийг хасаж, 64.1.5 дахь заалтын “танилцуулгын талаар гишүүд тайлбар хийж, түүнтэй холбогдуулан асууж” гэснийг “танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	85
Татгалзсан:	23
Бүгд:	108

78.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 69.1.4 дэх заалтын “хоёр дахь” гэснийг “3 дахь” гэж, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 70.3 дахь хэсгийн “төслийн талаар” гэснийг “төслийн хэлэлцүүлэг хийсэн талаар” гэж өөрчилж, мөн зүйлийн 70.1, 70.3 дахь хэсгийн “, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, нам, эвслийн бүлэг” гэснийг, 70.2 дахь хэсгийн “болон дэд” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	83
Татгалзсан:	25
Бүгд:	108

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг” гэснийг “зөвлөмжийг” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн “42.2.2 дахь заалтын” гэснийг дараах “дүгнэлтийг” гэснийг “энэ хуулийн 34.1-д заасан хууль зүйн дүгнэлтийг” гэж, мөн зүйлийн “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг “Хүний

хөгжил, нийгмийн бодлогын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 28
Бүгд: 108
74.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийн “70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 26
Бүгд: 108
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 69¹ дүгээр зүйлийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 28
Бүгд: 108
74.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйл буюу 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.8.Түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулах бөгөөд уг гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроосоо түр хорооны даргаа олонхын саналаар сонгоно. Түр хороо байгуулах санал тавьсан гишүүд даргаа дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108

63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Тогтвортой” гэснийг “Төсвийн тогтвортой” гэж өөрчилж, “24 дүгээр зүйлийн” гэсний дараа “24.2, 24.3 дахь хэсгийн “Хоёр” гэснийг “Гурав” гэж, мөн зүйлийн 24.2 дахь хэсгийн “хоёр” гэснийг “гурав” гэж,” гэж нэмж, “ , 24.4 дэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 84

Татгалзсан: 24

Бүгд: 108

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан товлосон асуудлыг хэлэлцэж дуусах хүртэл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хуралдааны цагийг сунгав./18:40/

Гурав.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “чуулганы нэгдсэн хуралдаанд” гэснийг “тухай хуулийн 21.28, 21.30-д заасан асуудлаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82

Татгалзсан: 25

Бүгд: 107

76.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалтын “гүйцэтгэх ажлын” гэснийг “гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны” гэж, мөн заалтын “тусгай хяналтын” гэснийг “хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын” гэж” гэснийг хасах гэсэн саналаар санал хураалт явуулах дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Тав.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “гүйцэтгэх ажлын тухай” гэснийг “гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны” гэж, мөн хэсгийн

“Тусгай хяналтын” гэснийг “Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын” гэж” гэснийг хасах гэсэн саналыг хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ч.Батбямба, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 37
Бүгд: 107
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 32
Бүгд: 107
70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 33
Бүгд: 107
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 40
Бүгд: 107
62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 51
Бүгд: 107
52.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 48
Бүгд: 107
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 40
Бүгд: 107
62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 43
Бүгд: 107
59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 26
Бүгд: 107
75.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 37
Бүгд: 107
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 34
Бүгд: 107
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 41
Бүгд: 107
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Байнгын хорооны саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 37
Бүгд: 107
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 40
Бүгд: 107
62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Төсвийн, Хууль зүйн, Эдийн засгийн болон Төрийн байгуулалтын байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Д.Амарбаясгалан: “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	78
Татгалзсан:	29
Бүгд:	107
72.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.	

Уг асуудлыг 18 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Р.Ринчинбазар, Н.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, мөн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалт, удирдлага, арга зүйн газрын дарга

Р.Мягмаржав, Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга С.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Батбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Г.Лувсанжамц, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Ринчинбазар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу маргаашийн нэгдсэн хуралдаанаар явуулахаар хойшлуулав./19:47/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцөөж, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 30 минут үргэлжилж, 126 гишүүнээс 109 гишүүн хүрэлцэн ирж, 86.5 хувийн ирцтэйгээр 19 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 07 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдэд энэ өдрийн амгаланг айлтгая. 73 гишүүн бүртгэгдэж, 57,9 хувиар ирц хүрсэн байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 7 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 7 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт, Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. 2 дугаарт, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин, Цогтгэрэл, Ариунзаяа, Бат-Эрдэнэ, Булгантуяа нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг, асуулт, хариулт 90 минутын хугацаанд явагдана. 3.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна, Болдын Уянга нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. 4 дүгээрт, Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна, Сайнзориг нарын 9 гишүүний өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байна. 5 дугаарт, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. 6 дугаарт, Хянан шалгах түр хороо байгуулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал нарын 89 гишүүн өргөн мэдүүлсэн. 7 дугаарт, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль шатад санаачилсан хуулийн төслөө татан авч болно гэж, 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж тус тус заасны дагуу Засгийн газраас 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр хуулийн төсөл татан авах тухай Засгийн газрын 1/89 дугаартай албан бичгийг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол Хуулийн төсөл татан авах тухай. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт

Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав гэсэн Засгийн газраас албан бичиг ирсэн байна. Засгийн газраас 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын 25 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг татан авсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга нарын 2 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд,

Нийтийн өмчийн хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороо,

3.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 6 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд,

4.Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд,

Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд,

Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд,

Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 6 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд,

8.Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал нарын 89 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд,

9.Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Цэндсүрэнгийн Мөнхтуяа нарын 40 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлснийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд тус тус хуваарилсан. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр 2025 оны 7 сарын 2-ны өдөр Засгийн газар 1/90 дугаартай албан бичиг ирүүлсэн.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахаар байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Ирц бүртгээдэхье.

Австралийн Үндэсний их сургуулийн Монгол судлалын тэнхимийн багш нар, Үндэсний их сургуулийн оюутнуудтай өнөөдөр Монгол Улсын Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцаж явж байгаа юм байна. Монгол Улсад тавтай морилохыг хүсье.

Энэ Төсвийн байнгын хорооны хурал санал хураалт явагдаж байгаа учраас гишүүд тэнд төвлөрөөд байгаа учраас энэ санал хураалтыг хойшлуулаад дараагийн асуудлыг хэлэлцэж байя.

14.17 цаг

Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудал. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 3 гишүүнээс 2025 оны 3 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 11 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар, Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа нарын 20 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ.

ТББХ 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 288 дугаар захирамжаар дээрх хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх

бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Ө.Шижир нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор Өргөдлийн байнгын хороо тухайн асуудлыг эрхлэх Байнгын хорооны саналыг үндэслэн холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах, сонсох талаар, Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудал Аялал жуулчлал дэд хороо байгуулах, нэгдсэн хуралдаанд албан тушаалтан худал мэдээлэл өгсөн бол мэдээллийг үнэн зөв эсэх асуудлаар дүгнэлт гаргуулах байгууллага Үндэсний статистикийн хороог нэмэхээр, Шинжлэх ухааны дэд хороо байгуулах хуулийн төслийг зохицуулалтыг Боловсрол шинжлэх ухааны дэд хороо болгон өөрчлөх, Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хороо байгуулах, хуулийн төслийн зохицуулалтад тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагад харьяалуулснаас бусад хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, ял эдлүүлэх ажиллагаа болон энэ зорилгоор явуулж байгаа гүйцэтгэх ажлын талаар хууль тогтоомжийг гэж ялган тодорхой зохицуулахаар,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор тухайн жилийн төсөвтэй холбогдуулан Ерөнхийлөгч хэсэгчилсэн байдлаар хориг тавьсан бол хоригийн шинж байдлыг харгалзан Улсын Их Хурал тогтоосон хугацаанд төслийг оруулж ирэх, хуулийн төслийн зохицуулалтын хоригийг шинж байдлыг нь харгалзах биш, Төсвийн байнгын хорооны саналаар хугацаа тогтоож болохоор өөрчлөх, Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх дэгтэй холбоотой хэсэгт хоёр дахь хэлэлцүүлэгт нь зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулах зэрэг зарчмын зарим процессыг тодруулах, хууль зүйн дүгнэлтийн зөвлөмж болгон өөрчилж байгаатай холбоотойгоор өөрчлөлт оруулахаар,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор түр хорооны даргыг түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүн даргалах, тухайн гишүүн татгалзсан бол түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроос томилох, эсхүл ийм шаардлагагүй гэж үзсэн бол түр хорооны гишүүд дотроосоо сонгох зэрэг нийт 17 зарчмын зөрүүтэй санал бэлтгэсэн.

Түүнчлэн нэгтгэсэн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Л.Энхнасан, М.Бадамсүрэн, Ц.Мөнхтуяа, Ч.Номин, Д.Рэгдэл, Б.Энхбаяр нараас ирүүлсэн болон ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр бүлэглэн бэлтгэлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.26-д нэг асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатад нь нэгтгэн, нэг төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлнэ гэж заасныг үндэслэн нэгтгэсэн нэг төсөл олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс ирүүлсэн, урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ нэлээн хэдэн хуулиудыг нэгтгэж хэлэлцэж байгаа. Энэ дээр гол энэ парламентын сөрөг хүчний гол хяналтыг тавих энэ зүйл түр хороо байгуулах тухай асуудал. Энэ түр хорооны даргаар тухайн эрх баригчид олонх байгаа учраас даргын зөвлөл ч юм уу, хаана ч байдаг юм тэн дээр хүн томилох тохиолдолд ихэнхдээ сүүлийн манайх 7 удаа түр хороо ажиллуулсан байна. Тэн дээр дандаа Монгол Ардын намын гишүүдээр ахлуулж энэ ажлуудыг хийсэн. Мэдээж сайн ажилласан түр хороонууд бий нь бий. Тэгэхдээ ихэнх нь гурилдсан. Ногоон автобус улаан цагаан хуучин юм оруулж ирээд, тэгээд бүгдийг нь илрүүлээд, ингээд гаргаад явж байхад тэр ногоон автобусны шүүх хурал юу болгож хувиргав. Тэгэхээр энэ Их Хурлын энэ хяналтын түр хороог энэ мөлийлгөж ийм асуудлыг ямар ч авах ч биш, хаях ч биш ийм байдлаар шийдвэрлэсэнд нь хамгийн гол асуудал байгаад байгаа юм.

Тийм учраас энэ түр хороог жишээ нь 32 гишүүн санаачлаад тэрнийгээ санаачилсан гишүүн нь толгойлоод явах ийм боломжийг ерөнхийдөө дэлхийн парламентуудын жишиг хандлагаар энэ асуудлаар орж байгаа. Мэдээж юу байдаг юм заавал сөрөг хүчин толгойлно гэхээр тодорхой хэмжээгээр өрөөсгөл байдаг. Ер нь дэлхийн практикт парламентын практикт яг дандаа сөрөг хүчнээр ахлуулна гэсэн юм байхгүй гэдгийг хэлье.

2 дахь асуудал нь гадаа манай ахмадууд жагсаад байгаа. Тэтгэврийн зээлийн асуудлаар. Энэ тэтгэврийн зээлийн асуудлаар би Монголбанкны Ерөнхийлөгчид албан бичиг явуулсан. Өөрөөр хэлбэл Төв банкны тухай хуулийн 273.4.7-гоор энэ Мөнгөний бодлогын хороог Монголбанкны Ерөнхийлөгч юм уу аль эсвэл 4 гишүүн санал гаргаснаар хуралдуулах, ээлжит бусаар хуралдуулах ийм боломжтой байдаг. Тийм учраас энэ ахмадууд гадаа наранд наршиж, олон өдөр зогсож байна. Тийм учраас энэ асуудлыг шийдвэрлээч гэдэг ийм хүсэлт тавьсан байгаа. Энэний дагуу өнөөдөр, маргааш ерөнхийдөө нөгөөдөр ч юм уу энэ 5 дахь өдөр дотроо багтаагаад Мөнгөний бодлогын хороо хуралдана гэж найдаж байна. Зарим нэгэн Их Хурлын гишүүд тэр Мөнгөний бодлогын хороонд байгаа миний зөвлөхийн нэрийг яриад байх шиг байгаа юм. Тэгэхээр манай Даваадорж зөвлөх энэ ахмадуудын зээлийн асуудлаар ингэж нааш, цааш болгох нь буруу гэж байр сууриа илэрхийлсэн. Тэр нь протоколд нь Монголбанкны тэр Мөнгөний бодлогын хорооны протоколд нь байж байгаа, эсэргүүцсэн байгаа. Тэгэхээр энэ дээр зөв ойлгоорой гэж та бүхнээс хүсье. Ингээд ахмадуудын тэтгэврийн асуудал ямар ч байсан 70, 30 болох байх. Дээрээс нь 24 сар түүнээс дээшхийг тухайн банк нь асуудлаа шийдээд явах ийм боломжийг нээж өгнө гэж найдаж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: Сайн байцгаана уу. Өнөөдөр 7 дугаар сарын 2-ны өдөр 126-тай парламент бүрдээд 365 хоног, нэг жилийн ойн өдөр болж байна. Тэгэхээр энэ чухал юу хийсэн бэ, цаашдаа юу хийх вэ гэдэг дээр бид бодож тунгааж цэгнэх ёстой өдөр гэж харж байгаа юм.

Ажлын хэсгээс асуулт байна. Энэ нэршлийн хувьд зөрөө байна гэж харж байгаа юм. Хуулийн төсөлд Агаар орчны бохирдлын дэд хороо гэж заасан, санаачлагчдын тайлбарт Агаар, орчны бохирдлын дэд хороо гэж таслалтай бичсэн байгаа. Тэгэхээр энэ нөгөө таслалтай, таслалгүйгээрээ утга зүйн хувьд 2 өөр тийшээ явчхаж байгаа. Тэгэхээр энийг нэг мөр болгохгүй бол энэ логикийн зөрчил үүснэ гэж харж байгаа. Энэ дээр тайлбар авъя.

2 дугаарт чиг үүргийн хувьд зөрөө байна. Хуулийн төсөлд тус дэд хорооны чиг үүргийг бодлого, зохицуулалтын болон хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг гэж өргөн хүрээтэй заасан. Санаачлагчдын тайлбарт зөвхөн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих гэж хязгаарлагдмал шинжтэй тусгасан байгаа юм. Тэгэхээр энэ нь дэд хорооны чиг үүргийн хүрээг нь тодорхойгүй болгож болзошгүй юм гэж харж байгаа. Энэ дээр тайлбар авъя.

3 дугаарт хуулийн төсөл дэх зарим зохицуулалт хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын холбогдох байгууллагын чиг үүрэгтэй давхцалтай байна гэж харж байгаа. Тухайлбал төслийн 27.5.1-д Агаар, орчны бохирдлын дэд хороо нь улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх бодлого, зохицуулалтын гэсэн заалт дахь улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд бодлого, зохицуулалтын гэсэн нь Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, мөн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгтэй давхцах шинжтэй байна гэж харагдаж байгаа. Тэгээд энэ дээр тайлбар авъя.

Агуулгыг дэмжиж байгаа. 2 сарын 3, 4-ний өдөр бид утааны сонсголыг 3 тусдаа бие даасан дэд сонсгол, нэг томоохон сонсгол, хяналтын сонсгол хийсэн. Энэ нь өөрөөр хэлбэл энэ агаар, орчны бохирдлын асуудлыг Улсын Их Хурал дээр энэ дэд хороо байгуулж нэг мөр авч үзэхгүй бол сагсны бөмбөг шиг нааш, цаашаагаа явсаар байгаад эзэн бие байхгүй, хариуцлага байхгүй, ингээд улс амьтан үхэж үрэгдээд, улс оронд хохирол учруулаад байгаа. Тэр утгаараа агуулгыг бүрэн дэмжиж байгаа. Саяын 3 зүйл дээр тодруулга авъя. 1 дүгээр асуулт.

2 дугаарт ХЗБХ-ны дэргэд дэд хороо байгуулна гэсэн саналыг Тэмүүжин гишүүн гаргасан. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр тусгай байгууллагуудын төсвийг л авч үздэг. Хүний эрхийн зүгээс, хүний эрхийг хамгаалах талтай холбогдуулаад ХЗБХ-ны дэргэд энэ тодорхой чиг үүрэг бүхий дэд хороог байгуулъя гэсэн. Энэний яг үндэслэл, ач холбогдол, зайлшгүй шаардлагынх нь талаар Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн тайлбарлаж мэдээлэл өгөөч гэж хүсье. Энэ 2 асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн хариулт өгье.

Б.Баярмагнай: Аюушийн Ариунзаяа гишүүн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн 2-ын өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дээр яг энэ таны асуусан чиг үүрэг давхцаад ороод ирсэн юм. Тэгээд ажлын хэсэг энэ дээр ажиллаад яг саяын таны уншдагийг арай өөрчилж засаад, Агаар, орчны бохирдлын дэд хороо, агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах талаарх бодлогын асуудлыг гэж томьёолж оруулж ирж байгаа нэгд нь.

2-т нөгөө БОХХАА-н байнгын хороонд Агаар, орчны бохирдлын, хүнс, хөдөө аж ахуйн гэж дэд хороо байгуулж байгаа юм. Дэд хороо. Энэ дээр манай Улсын Их Хурлын зарим гишүүд саналаа илэрхийлж байсан. Тэгээд ажлын хэсэг дээр хөдөөгийн хөгжил гэж, хүнс, хөдөө аж ахуйн гэдэг нь яг үндсэн байнгын хорооныхоо нэр устай, чиг үүрэгтэй давхцаад байгаа учраас хөдөөгийн хөгжлийн гэж томьёолох саналыг оруулаад, ажлын хэсэг дээрээ дэмжигдээгүй уначихсан юм. Тэгээд энүүгээрээ явсан. Яг эрхлэх асуудлын хүрээндээ хөдөөгийн хөгжил, хоршооны чиглэлээр. Тэгэхээр энэ дээр нөгөө хүнс, хөдөө аж ахуйн гэдэг чиглэл энэ үгээрээ ажлын хэсэг дээр ингээд зарчмын зөрүүтэй санал гараад унаад, тэгээд өчигдөр ТББХ анхны хэлэлцүүлэг дээрээ яг саяын миний уншсан томьёоллоор дэмжигдээд гараад ирчихсэн байгаа юм Эрдэнэболд гишүүнээ. Дараагийн асуултад Тэмүүжин гишүүн.

Д.Амарбаясгалан: Тэмүүжин гишүүн хариулт өгье.

Х.Тэмүүжин: Өнөөдөр 2025 оны 7 сарын 2-ны өдөр. Яг өнөөдрөөс өмнө 17 жилийн өмнө 2008 оны 7 сарын 1-нээс 7 сарын 2-ны шилжих шөнө 5 иргэн, 4 иргэн буудуулж амь насаа алдсан, 1 иргэн угаартаж амь насаа алдсан эмгэнэлт үйл явдал болсон юм. Энэ үйл явдлын дараа Улсын Их Хурал ажлын хэсэг байгуулаад, Улсын Их Хурал дээрх анхны нээлттэй сонсголыг зохион байгуулсан юм. Тэр нээлттэй сонсголоос зөвлөмж гарсан. Тэгээд тэр зөвлөмжийн хүрэн дотор ямар, ямар асуудлууд байсан бэ гэхээр тухайлбал ингэж бичсэн байгаа юм. Эрүүгийн болон тагнуулын гүйцэтгэх албаны чиг үүргийг нарийн зааглаж, мөрдөх албаны бүтэц, зохион байгуулалт, хяналт хариуцлагын тогтолцоог хуульчлах гэж ЗГ-т зөвлөмж өгсөн байгаа юм. Гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох, хохирол барагдуулах сан байгуулах гэж ЗГ-т зөвлөмж өгсөн байгаа юм. Энэ 7 сарын 1-ний үйл явдлын дараа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Х.Тэмүүжин: Энэ 7 сарын 1-ний үйл явдлын дараа дахиад юу болсон бэ гэхээр Монгол Улсын нэг иргэн гэр бүлийн хүчирхийлэлд өртөөд, шүүхэд гэр бүлээ цуцлуулахаар гомдол гаргасан чинь шүүх эвлэрүүлэх хугацаа өгөөд, тухайн шүүх хуралдаан болох өдрийн өглөө шүүхийн байрнаас 150 метрийн гадна тэр гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан хүнийхээ гарт хутгалуулж амь насаа алдсан. Ингээд зөвлөмжийн дараа тахарын албыг байгуулсан. Харамсалтай нь гэрч, хохирогчийг хамгаалдаг энэ байгууллагыг татан буулгасан. Өнөөдөр дөнгөж саяхан яг энэ үйл явдал боллоо. Хэдий болтол хүний амиар бид бодлогын буруу, улс төрийн буруу шийдлийнхээ золиосонд Монголчуудыг ингээд үхүүлээд алуулаад дуусах вэ.

Яг энэнтэй адилхан ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд Тусгай хяналтын дэд хороо байгуулах гэж байгаа юм. ХЗБХ-ны эрхлэх асуудал гээд 17 зүйл байна. Хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, эрх зүйн үндэс ялын бодлого. Эрүү, иргэн, захиргааны хэрэг маргаан, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа, эрх зүйн

туслалцаа, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа гэх мэтчилэн. ХЗБХ-ны эрхлэх асуудлаар бид хяналт хийж чадахгүй байна. Иргэний үндсэн эрх, хууль дээдлэх зарчим, парламентат ёсныхоо хувьд бид оновчлогдоогүй байна. Тусгай хяналтын дэд хороо аюулгүй байдалтай холбоотой асуудлаар яваад байдаг. Гэтэл ХЗБХ-нд энэ асуудал байхгүй. Цагдаагийн байгууллагын алба хаагчдаар гэрчийг хамгаалуулах гэсэн чинь гэрчтэй, хохирогчтой яг гэмт хэрэгтэнтэй юм шиг харьцаж эхэлсэн. Аюулгүй байдлын байнгын хороон дээр байгаа Тусгай хяналтын дэд хороо яг ийм. Иргэний эрх, хуулийн засаглалтай холбоотой асуудал бидэнд хамаагүй, гадаад бодлогын аюулгүй байдал гээд гадуур яваад байгаа юм. Энийг засахын тулд ХЗБХ-н дээр энэ тусгай хяналтын дэд хороо байгуулах гэж байгаа юм. Энэ бол иргэний.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Тэмүүжин гишүүнээ Үндсэн хуулийн 33 жилийн ой болж байна. Энэ олон жил өнгөрчихжээ. Яг ийм туршлага олон улсын жишгээр жишээлбэл ямар, ямар орнуудад байгаа юм бэ? Өөрөөр хэлбэл бид дэлхий дээр байдаг парламентад төлөвшсөн орнуудын кейсийг, туршлагыг Монголд оруулж ирэх гээд байна уу, эсвэл шинээр дугуй зохион бүтээх гээд байна уу гэдэг аягүй их чухал. Энэ тал дээр та нэг мэдээлэл өгөөч?

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя.

Х.Тэмүүжин: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Үнэхээр бид өөрсдөө хэтэрхий олон шинэ дугуй зохиочхож. Дэлхийд байхгүй шинэ дугуйныхаа золиосонд бид хүний эрхийг, иргэдийнхээ эрх чөлөөг, амь насыг ингээд золиод сууж байгаа. Тухайлбал Гүйцэтгэх ажлын тухай хууль. Гүйцэтгэх ажлын тухай хууль гэдэг ийм нэртэй тусгайлсан бүх салбарыг хамардаг хуультай улс орон дэлхийд алга. Хэрвээ мөрдөн шалгах чиг үүрэг гэж сэтгэж гүйцэтгэж байгаа, гэмт хэрэгтэй тэмцэж байгаа, шүүхэд бүтээгдэхүүн бэлдэж өгч байгаа бол тэр бүх зүйл зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиараа зохицуулж байна. Шүүхийн зөвшөөрөлтэй, юу нууц мөрдөн шалгах ажиллагаа гэдэг нэр доор энэ ажиллагаа явж байна. Энэ ажиллагааны хүрээнд хүний эрх зөрчигдөж байгаа, хууль биелэхгүй байгаа бол парламент ХЗБХ-нд хянаж байна. Гэтэл бид Гүйцэтгэх ажлын тухай хууль гэж нэрлээд тагнуулынхаа хуультай хольсноосоо болоод энд ямар ч хяналтгүй явж байна. Парламент хяналт байхгүй.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг асуулт асууя.

О.Номинчимэг: Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе. Энэ хамт хэлэлцэж байгаа хуулиудын нэг болох Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй холбоотойгоор дахиад үгээ хэлье гэж бодож байна. Өчигдөр ТББХ-н дээр энэ талаар ярьсан. Яах вэ мэдээж энэ хууль санаачилж орж ирж байгааг ойлгож байгаа. Гэхдээ бид 2, 3 юман дээр анхаарах хэрэгтэй байгаа юм. Өмнөх 76 гишүүнтэй парламентын үед үнэмлэхүй олон саналыг авсан нам байсан. Ингээд анх удаа Хянан шалгах түр хорооны бүтцийг бид бий болгосон хуулиараа. Тэгээд ингээд практик дээр энэ маань өөрөө парламентад сууж байгаа суудлынхаа тоогоор харьцангуй ийм тоотой байсан учраас гардаг байсан проблемыг одоо тогтолцоо өөрчилсний дараа 126 гишүүнтэй, 5 намын төлөөлөлтэй хүчтэй сөрөг хүчинтэй энэ парламентын зовлонтой адилхан бодоод өөрчилье гэсэн

санал орж ирж байх шиг байна. Тэгэхээр өөрөө тогтолцоо маань өөрчилчихсэн, өөр болчихсон шүү гэдгийг 1 дүгээрт хэлмээр байгаа юм.

2 дугаарт энэ санаачлагч нь түр хороогоо даргалдаг гэдэг нь олон улсын жишиг гээд Пүрэвдорж гишүүн яриад байх юм. Ерөөсөө энэ олон улсын жишиг биш байхгүй юу. Олон улсад ерөөсөө 3 модель л байгаа. Энэ түр хороо, Хянан шалгах түр хороо буюу энэ шүдтэй арслан хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлдэг энэ түр хорооныхоо даргыг сонгодог 3 л модель байна. 1 дүгээрт ерөөсөө олонх авсан нам нь даргыг нь сонгочихдог юм байна. Америк конгресс. Энэ бол Ерөнхийлөгчийн засаглалтай, Ерөнхийлөгч нь болон Конгрессын олонхыг бүрдүүлж байгаа нам ерөөсөө юу яадаггүй, заавал давхардах албагүй, тэгээд энэ зарчмаараа явчихдаг.

2 дугаарт нь Австри гэх мэт улсууд ерөөсөө Улсын Их Хурлын дарга нь спикер нь томилчихдог юм байна. Өөрөө ч бараг спикер нь өөрөө удирдаж явдаг ийм системтэй байна. Энэ бидэнд тохирохгүй гээд яг энэ хуулийг хийж байсан үзэл санаа 3 дахь модель буюу зөвшилцлийн модель дотроосоо сонгодог моделийг сонгоё гээд. Энэ бол Англи, Германы модель байгаа юм. Ингээд Англид яах вэ гэхээр бүр энэ даргаа нууц санал хураалтаар нэгдсэн чуулганаараа энийгээ сонгож байгаа. Германд ихэвчлэн ингээд мэдээж асуудлаасаа хамаараад олонх байдаг. Гэхдээ гүйцэтгэх засаглалтай холбоотой, тусгайлсан ийм сэдвүүдээр олонх бол болно гэдэг зөвшилцлөө хэлэлцээрээ хийдэг. Энийгээ манай Монгол Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл гэж байдаг бүх намын төлөөлөл орсон. Энэ дээрээ энэ Түр хорооны бүтэц, бүрэлдэхүүн хэдэн гишүүнтэй байх юм, хэд нь аль намаас байх юм гэдэг бүх тоогоо, бүрэлдэхүүнээ тэн дээрээ зөвшилцдөг. Тэгээд ихэвчлэн даргыг нь хэн байх вэ гэдэг ийм зөвшилцдөг механизмтай юм.

Тэгээд энийг л уг нь бид энэ хуульдаа тусгасан юм. Тэгээд энийг жоохон тодруулах хэрэгтэй бол уг нь тодруулаад орчихмоор байгаа юм. Тэгэхгүй болохоор одоо ингээд санаачлагч нь энийг даргална гэхээр ерөнхий нэг ийм зарчмын гажуудлууд гарч ирэх гээд байгаа юм. Ер нь энэ нөгөө түр хороог ахлах хүн бол маш туршлагатай, ур чадвартай, зарим газар энэ нь, энэ чинь шүүх эрх мэдэл шиг ийм гэрч дуудаж асуудаг ийм чиг үүрэгтэй шүү дээ. Тэгэхээр яг энэ чиглэлээр илүү 5 жилийн туршлагатай ч гэдэг юм уу ийм шалгуур тавьдаг юм байна лээ. Хамгийн гол нь хараат бусаар ажиллах боломжтой хүн, хуульд заасан ашиг сонирхлоос илүү хараат бусаар ажиллаж чадах ёстой хүн гэж энийг заадаг. Тэгэхгүй бол яг энд одоо ажлын хэсгээс орж ирсэн саналыг харвал санаачлагч нь, анх санаачлагч нь буюу бланк дээрээ гишүүдийнхээ 32 гишүүдийн гарын үсэг цуглуулсан хүн нь ингээд хийнэ гэхээр ер нь 3, 4-үүлээ нийлж байгаад чи дарга нь бол, ингээд цөмөөрөө санаачилъя гэдэг юм руу явах гээд байгаа байхгүй юу.

Зүй нь энэ чинь нөгөө логигоороо болохоор Байнгын хороо, дэд хороог шинээр бий болгоё гэдэг Улсын Их Хурал гишүүн санаачилдаг. Тэгэхээр энэ Байнгын хороо, дэд хороог санаачилж орж байгаа гишүүн нь өөрөө Байнгын хороо, дэд хорооныхоо дарга нь болно гэсэн логиктой яг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүнд 1 минут нэмж өгье.

О.Номинчимэг: Түр хорооны гишүүдийнхээ намынхаа зөвшилцлөөр энэ даргыгаа сонгодог, тэгээд энэ дээрээ уян хатан байдалд байдаг, ингээд туршлагатай, дээр нь тэр хараат бусаар ажиллах хүнээ ингээд хоорондоо ярьдаг байх ёстой. Тэгэхгүй бол энэ логигоор дараагийн удаа би ямар хууль орж ирэх гэж

бодохоор Байнгын хороо, дэд хороо шинээр байгуулъя. Ялангуяа дэд хороо шинээр байгуулъя, санаачилж байгаа дэд, тэр хуулийг санаачилж байгаа хүн нь дэд хорооныхоо дарга болъё гэдэг энэ логиктой яг адилхан санагдаад байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ гишүүд маань, ажлын хэсэг маань дахиж нэг харж үзээд, мэдээж олон талын санал байгаа, энийгээ дахиад нэг энэ заалт дээрээ чиглэл авч байгаад сайжруулах боломж бололцоо байдаггүй юм уу. Нэг нухацтай хийхгүй бол одоогийн зовлонгоо шийдэх гэж байгаад хуулийн гажуудал бид гаргачих вий дээ л гэдэг ийм болгоомжлол байгаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн хариулт өгье.

О.Цогтгэрэл: Гишүүний асуултад хариулъя. Тэгээд бусад гишүүд мэдээлэл дутмаг байж магадгүй. Ерөөсөө энэ ингээд тоймлоод хэлбэл Хяналт шалгалтын түр хороог хэн ахлах вэ гэдэг дээр хуулийн нэмэлт зохицуулалт хэрэгтэй байна гэж. Ер нь яагаад энэ хуулийг өргөн барих үндэслэл гэдгийг тайлбарлах хэрэгтэй. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд 7 хяналт шалгалтын түр хороо байгуулагдаад, сонсгол хийж байсан. Би хамгийн төгсгөлөөс нь та бүхэнд хэлье л дээ. 24 онд гэхэд ашигт малтмалын лицензээр, хайгуул, ашиглалтаар сонсгол хийсэн. Яг ямар сонсгол болоод өнгөрснийг хэн ч мэдэхгүй. Тэрний урд талд ногоон автобусаар сонсгол хийсэн. Дахиад хэн, ямар сонсгол болсныг хэн ч мэдэхгүй буюу ерөөсөө ингээд л өнгөрсөн 7 удаагийн сонсголд тухайн үеийн эрх баригчид олонхоосоо ингээд тавиад л явчихсан. Тэгэхлээр энэ дээр үнэхээр хуулийн зохицуулалт, үнэхээр хяналт шалгалтын чиг үүрэг, үүргийн тухайд ингээд учир дутагдал байна гэж хуулийн төсөл өргөн барьж байгаа.

Тэгэхдээ хуулийн төслийг одоо санал хураах гэж байгаа зарчмын зөрүүтэй санал дээр томъёолсноор, зарчмын зөрүүтэй санал дээр томъёолсноор сая Номинчимэг гишүүний ярьж байгаагаар зөвхөн санаачилсан гишүүн биш, санаачилсан гишүүн нь болж болно. Тэгэхдээ санаачилсан гишүүн гэдгийг чинь гишүүд дэмжихдээ 32-оос дээш гишүүн энэ хүн даргалах нь гэдгийг ойлгож, тэр чинь 1 гишүүн нь санаачлаад сонсголын дарга болох боломжгүй. 32-оос дээш гишүүний санал авна гэдэг бол би тийм хэлбэр зүйл биш байх гэж бодож байна 1 дүгээрт нь.

2 дугаарт нь санаачилсан гишүүн татгалзсан тохиолдолд татгалзсан юм уу, магадгүй ашиг сонирхлын зөрчилтэй байж болно. Энэ Ашиг сонирхлын зөрчлийн хуулиараа энэ хүнийг даргалуулах бол хуулиараа боломжгүй. Энэ тохиолдолд түр хороо байгуулах саналыг гаргасан гишүүд 32-оос дээш гишүүн дотроосоо нэгнийгээ тавьж болно. Ингээд энэ тохиолдолд дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны Их Хурлаас томилогдсон, сонгогдсон гишүүд хуралдаад одоогийн байгаа журмаараа тавьж болно гэдэг ийм л дараалал. Энд тухайлсан цөөнх гэж байхгүй. Тэгэхдээ үнэхээр чухал асуудлыг бие даагч гишүүн ч гэсэн гарч ирээд, тэгэхдээ тэр бие даагч гишүүн хэдийгээр ганцаараа ч гэсэн үнэхээр нийгмийн чухал асуудлыг, тэр тусмаа бусад гишүүдээс 32-оос дээш гишүүний дэмжлэг авна, ийм хүнээр даргалуулчихъя гээд шийднэ гэдэг тийм хялбархан босго гэж энэ хууль санаачлагчдын зүгээс үзэхгүй байгаа юм. Энэ саналыг яг энэ асуудлыг ярилцсан, ТББХ-ны дэргэд гарсан ажлын хэсгээс энэ санал зүй зохистой байна гэж ажлын хэсэг дэмжээд өчигдөр ТББХ-ноос дэмжсэн гэдгийг та бүхэнд хэлье.

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: Тэгээд өнгөрсөн яах вэ 7 сонсголын тухай хэлээд л байх шиг байна. Гэхдээ энэ чинь би хэлээд байгаа шүү дээ. 76-тай парламентад нэг нам хэт олонх болчихсон ийм бүтэц дээр та гарсан кэйсээ одоогийн ийм тогтолцоо нь өөрчлөгдчихсөн, сонгуулийн тогтолцоо чинь ийм парламенттайгаа наагаад энэ асуудлаа одоо ч гэсэн асуудал юм шиг ингээд байгаа нь юу байхгүй юу, болохгүй байхгүй юу.

Зүгээр миний хэлээд байгаа юм нь уг нь энэ түр хорооны үйл ажиллагаа ямар байх вэ, ямар чиг үүрэгтэй байх вэ, юу болно, болохгүй энэ журмыг нарийвчилж харах хэрэгтэй байгаа юм. Тэгээд нөгөө бүрэлдэхүүндээ хэн, хэн орох юм гэдэг нь одоо ч гэсэн нэг ийм тодорхойгүй бараг дураараа саналаа өгөөд л болчхож байгаа юм шиг. Энэ чинь өөрөө намын бүлгүүд хоорондоо зөвшилцөөд, энийгээ хэд нь, аль нам нь авч суудал, түр хорооны бүрэлдэхүүн хэдэн хүнтэй байх юм 11 юм уу, 13 юм уу, аль, аль нь хэдэн хувиар авах юм гэдэг юмаа ч хүртэл ярьдаг ийм практиктай юм байхгүй юу. Тэгээд даргаа яаж сонгох вэ, ур чадвартай, энэ асуудал дээр үнэхээр хараат бусаар ямар нэгэн biase-гүйгээр аваад явчих боломжтой юу гэдгийг хараад ингээд л шийддэг юм байгаа юм. Тэгээд энэ зарчим маань.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Өнөөдрөөс яг нэг жилийн өмнө энэ танхимд суугаа бүх Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын гишүүний тангаргаа өргөж, Улсын Их Хурлын анхдугаар чуулган хуралдсан. Яг энэ цаг мөчид би та бүхэнд Улсын Их Хурлын гишүүний тангаргийг сануулахыг хүсэж байна. Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлоос ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэхүү тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ гэжээ.

Тэгээд Улсын Их Хурал яг нэг жилийнхээ ой дээр Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах замаар Улсын Их Хурлын хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг илүү бэхжүүлэх, энэ танхимд бодит мэтгэлцээн өрнөж, Улсын Их Хурлын бүтэц болох Байнгын хороод, дэд хороод, түр хороодын зохион байгуулалт, үйл ажиллагаа, олонх, цөөнхийн хяналт, тэнцлийн асуудлыг сайжруулах чиглэлээр хуулийн төсөл хэлэлцэж байгаад маш их баяртай байна. Тиймээс орж ирсэн саналуудыг бүтнээр нь дэмжиж байгаа.

Манай зарим гишүүдийн хувьд болохлоор ХЗБХ-н дээр байгуулагдах Тусгай хяналтын дэд хороон дээр нэлээн эмзэглэж байх шиг байна. Тэгэхээр өнгөрсөн 35 жилийн хугацаанд бид энэ хууль хүчний байгууллагууд дээр хүний эрх, эрх чөлөөг дээдлэх тэр зарчмыг сахиулан хэрэгжүүлэх ийм эрмэлзлийг агуулж ажилласан боловч өнгөрсөн хугацаанд энэ хуулийн хонгил гэдэг ойлголт гарч, үе үеийн улс төрч энэ талаар ярьж, ийм асуудлууд олон удаагийн улс төрийн хэлмэгдүүлэлтүүдийн асуудлууд явж ирсэн.

Тэгэхээр би энэ чиглэлээр хууль санаачилсан Тэмүүжин гишүүнээс дараах зүйлийг асуумаар байна. Үнэхээр өнгөрсөн хугацаанд гүйцэтгэх засаглал дээр ажиллаж байсан, Хууль зүйн сайдаар томилогдож байсан, Ерөнхий сайдаар томилогдож байсан хүмүүс бүгдээрээ л хонгил нураана гэж орж ирсэн. Энэ

парламент үнэхээр хонгил нурааж чадах уу? Энэ 126 гишүүнтэй яг энэ ардчилсан тогтолцоо, парламентын тогтолцоондоо итгэж байгаа гэж ойлгож байгаа энэ парламент хонгилыг нураах асуудалд бид яг бодитоор хувь нэмрээ оруулж чадах уу? Таны санаачилсан энэ хууль энэ үйл хэрэгт хувь нэмэр оруулж чадах уу гэдэг асуулт байна? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тэмүүжин гишүүн хариулт өгье.

Х.Тэмүүжин: Би түрүүн хэлсэн. Үндсэн хууль батлагдаад 33 жил, 2008 оны 7 сарын 1-ний эмгэнэлт үйл явдал болоод 17 жил болж байна. Гэтэл бид 17 жил иргэнийхээ эрхийн төлөө хууль маш бага гаргасан. Эрх мэдэлтэн, дарга, төрийг эрх мэдэлтэй болох хуулийг маш ихээр үйлдвэрлэсэн. Сая Улсын Их Хурал бид стратеги төлөвлөгөөгөө баталсан. Хүний эрхэд суурилсан хүн төвтэй хууль зүйн бодлогын төлөө энэ 126 гишүүн ажиллана гэж хэлсэн. ХЗБХ-ны эрхлэх асуудал байна 23.10.1, 23.10.2. Хүний эрх, эрх чөлөө, түүний баталгааг хангах бол ХЗБХ-ны эрхлэх асуудал. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах бол ХЗБХ-ны эрхлэх асуудал, прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудал ХЗБХ-ны эрхлэх асуудал, эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудал ХЗБХ-ны эрхлэх асуудал, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах асуудал, түүнтэй холбоотой хууль зүйн бодлого боловсруулах ХЗБХ-ны эрхлэх асуудал.

Гэтэл эрхлэх асуудлаараа хяналт тавьж чаддаггүй Байнгын хороо яаж шийдвэр гаргах вэ, яаж асуудлыг бодитой дүгнэх вэ. Бид иргэнд зориулсан хуулийн шинэтгэл хийж чадахгүй байгаа учраас гудамжинд иргэд айдастай байж байгаа. Улс төрчид өөрсдөө хонгил ярьж байгаа, өөр хоорондоо утсаар ярихдаа сонсоод байна, дарга нарыг дуудахдаа 1, 2, 3 гээд бүр хочоор нь ярьж байгаа. Яг зүүн Германы нууц цагдаа шиг хувийн мэдээллээ хуулийн байгууллагуудад шүүхийн зөвшөөрөлгүй алддаг. Тэнд хууль биелж байгаа эсэхийг мэддэггүй. Иргэний эрх чөлөө хаана эвдэгдээд байгаа гэдэг ямар ч ойлголт байхгүй. Гэтэл гудамжинд нь иргэд нь хүнд хутгалуулж байдаг, зодуулж байдаг, хуулийн байгууллагад эрүү шүүлтэд өртөж байдаг. Монгол Улсын Үндсэн хууль дээр байж байгаа шүү дээ. Иргэний хамгийн чухал үндсэн эрхүүдийн нэг бол эрүү шүүлтээс ангид байх. Энэ эрхийг онц байдал зарласан үед ч үл хүндэтгэж болно гэсэн Үндсэн хуультай мөртөө жил болгон эрүү шүүлтэд өртсөн тухай, энэ нь бүр эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ёстой байгууллагууд нь иргэнийхээ эсрэг хийдэг болчихсон тухай сонсоод сууж байгаа.

Тэгсэн мөртөө энэний араас явдаг чиг үүрэг бүхий тусгай хяналтын дэд хороо байхгүй. ХЗБХ нь яг шүдгүй арслан шиг, гар, хөл нь боомилгогдохсон. Энэ асуудлыг шийдэж байж л бид яг хууль хаана биелэхгүй байгаа юм, хүний эрх хаана зөрчигдөөд байгаа юм, энэ гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагууд чинь өөрсдөө гэмт хэрэг хийгээд байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг Улсын Их Хурал өөрөө мэддэг болно. Улсын Их Хурал энэ парламентат ёсныхоо агуулгаар ардчиллаа хамгаалах чадвартай болно, хуулийн засаглалын төлөө зогсдог болно.

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя. Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан Асуултууд ер нь давхцаж байна. Тэмүүжин гишүүнээс нэг юм тодруулчихъя. Аюулгүй байдал дээр байгаа Тусгай хяналтын хороо Хууль зүйд очсоноороо энэ нэгд юу дээрдэх вэ? Одоо байгаа нь ямар дутагдалтай байгаа юм

бэ? Адилхан л Их Хурлын гишүүд байгаа шүү дээ. Тэгэхлээр ХЗБХ-н дээр очсоноороо яг ямар давуу талууд үүсэх юм бэ? Адилхан Их Хурлын Байнгын хороон дээр байгаа дэд хороонуудыг шилжүүлэх нь тийм ч айхтар ач холбогдол байна уу, үгүй юу гэдгийг нэг сайхан ойлготол хэлээд өгөөрэй гэж хүсэж байгаа юм?

2 дугаарт нь энэ түр хороонууд чинь сая хэн хэлчхэв дээ. Нэг их олон түр хороо байгуулаад л, бид чинь Их Хурлынхаа хуулиар Байнгын хороо, дэд хороодын тоог нэмээд байдаг. Тэгээд түр хороодын тоог нэмчихлээр давхардал үүсгэх вий л гэсэн болгоомжлол байна. Энэ дээр ажлын хэсгийн ахлагч хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Тэмүүжин гишүүн хариулт өгье.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурал үйл ажиллагаагаа Байнгын хороодоор зохион байгуулж хийдэг. Байнгын хороодоор эрхлэх асуудлуудыг хуваарилж өгдөг. ХЗБХ-ны эрхлэх асуудал гээд 23.10.1-ээс 23.10.17 хүртэл ийм эрхлэх асуудлууд байна. Би энэ ягаанаар тодруулчихлаа. Эрх зүйн бодлого, хүний эрх чөлөө, түүний баталгаа, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого, шүүх эрх мэдлийн эрх зүйн үндэс, хараат бус байдлыг хангах асуудал, прокурор, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, эрүү, иргэн, захиргаа, хэрэг маргааны зөрчил, хянан шийдвэрлэх ажиллагаа, эрх зүйн туслалцаа гэх мэтчилэн. Аюулгүй байдлын байнгын хорооны эрхлэх асуудал гээд 23.2.8 дээр 8 зүйл байна.

Гэтэл ХЗБХ-ны эрхлэх асуудал дотор хөндөгдөж байгаа асуудлыг эрхлэх асуудал нь байхгүй байгаа Аюулгүй байдлын байнгын хорооны Тусгай хяналтын дэд хороо шийдэж чадахгүй. Гэтэл энэ ХЗБХ-ны эрхлэх асуудал дотор чинь иргэний эрх, эрүү шүүлт, хохирогч хамгаалал, шударга ёс, хуулийн засаглал энэ бүхэн чинь явж байна. Эрхлэх асуудлаараа хяналт тавьж чадахгүй Байнгын хороо. Нөгөөдөх нь эрхлэх асуудалд нь огт хамаагүй Тусгай хяналтын дэд хороо. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо бол тагнуул, армитай холбоотой асуудлаа бол тусгай хяналтын дэд хорооныхоо эрхлэх асуудал өөрөө шийдэж болж байна.

Гэтэл гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах, ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэгдэж байгаа нууц мөрдөн шалгах ажиллагаа болон гүйцэтгэх ажиллагаатай холбоотой асуудлыг чинь Аюулгүй байдлын байнгын хороонд байгаа Тусгай хяналтын дэд хороо хийж чадахгүй. Яагаад гэвэл Байнгын хорооных нь эрхлэх асуудалд байхгүй. Дэд хороо Байнгын хорооныхоо эрхлэх асуудлын хүрээнд байгуулагддаг дэд хороо хуулиараа. Тэгэхээр энэ зөрчилдөөнийг бид шийдэхгүй бол болохгүй нь. 33 жил Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхүүд чинь хог дээр байна. Тэр дундаа гэмт хэрэгтэй тэмцэж, иргэний эрхийг хамгаалах ёстой байгууллагууд чинь энэ төрлийн гэмт хэргийг хийгээд, иргэний эрхийг зөрчөөд байна. Гэтэл Улсын Их Хурал энэ дээр хяналт тавихгүй байна.

Би маш тодорхой жишээ хэлье. Өнгөрсөн 8 жил та бүгдийг олонх байхад Тусгай хяналтын дэд хорооны даргыг Сү.Батболд гэдэг хүн хэрэгжүүлсэн. Энэ байгууллага одоо хүртэл уначихсан. 33 жил энэ Тусгай хяналтын дэд хорооны эрхлэх даргаар чинь хэн явсан бэ гэвэл энэ байгууллагыг зүгээр л өөрийнхөө асуудлыг шийдэхэд хуулийн байгууллагын дарга нартай хувийн хэлхээ харилцаа тогтоох энэ арга барилдаа ашигласан хүмүүс л ажиллуулсан байна. Энэ Тусгай хяналтын дэд хороо чинь огт ажил хийдэггүй байсан байна. Жилдээ зөвхөн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баярбаатар гишүүн нэмж хариулъя.

Б.Баярбаатар: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Тэгээд одоо мөрдөгдөж байгаа Их Хурлын тухай хуулиар 5 Байнгын хороо, 5 дэд хороотой үйл ажиллагаагаа явуулж байгаа. Нийтдээ 11 Байнгын хороо. Тэгээд энэ чиг үүргийн давхцал, бас дэд хорооны хэмжээнд ажиллачих боломжтой болон өмнөх парламентуудын үед дэд хороогоор ажиллаж байгаад одоо Байнгын хороо болчихсон 4 Байнгын хороог буцаагаад дэд хорооны чиг үүрэг рүү нь шилжүүлээд, харьяалагдах Байнгын хороонд өмнө нь харьяалагдаж байсан Байнгын хороонд нь хүргэсэн.

Дээр нь сая энэ Улсын Их Хурлын гишүүдийн өргөн барьсан, Ариунзаяа гишүүний өргөн барьсан хуулийн төсөл дээр нийтдээ 13 дэд хороо байгуулахаар чиглэлийнх нь дагуу төсөл орж ирсэн дээр зарчмын зөрүүтэй санал гараад, Аялал жуулчлалын дэд хороо нэмэгдээд ингээд нийтдээ 14 дэд хороо байгуулахаар төсөлд тусгасан байж байгаа.

Д.Амарбаясгалан: Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Гэр бүлийн асуудал ер нь аль Байнгын хороонд харьяалагдахаар байгаа вэ? Хэдүүлээ энэ гэр бүлийн асуудалд онцгой анхаарахгүй бол өчигдөр, уржигдархан сая нэг аймшигтай гэмт хэрэг гарсан шүү дээ. Тэгээд хэдэн эмэгтэйчүүдийгээ харгис нөхдийн гарт алдаад дуусах юм шиг байна. Тийм учраас гэр бүлийн асуудлыг аль Байнгын хороонд хамаатуулах вэ? Ер нь энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулиа нэг хуулийг дахин найруулж, дахин өргөн барьж, нэмэлт, өөрчлөлт хийхгүй бол хэдэн бүсгүйчүүдийгээ тийм харгис хэрцгий хүмүүсийн гарт хугацаа өгч байгаад алуулчихаад байна л даа. Тийм учраас энэ дээр та бүгд ямар бодолтой байна вэ гэж?

Д.Амарбаясгалан: Баярбаатар гишүүн хариулт өгье.

Б.Баярбаатар: Өнөөдөр салбарын яамных нь нэр нь өөрөө гэр бүл гэдэг нэрээр эхэлж байгаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Өнөөдөр ажлын хэсгээс оруулж байгаа санал дээр өмнө Нийгмийн бодлогын байнгын хороо гэж байсныг Хүний хөгжил, нийгмийн бодлогын гэж Байнгын хорооны нэр өөрчлөгдөж орж ирж байгаа. Энэ дотроо яг энэ толгой Байнгын хороогоороо Нийгмийн бодлогын байнгын хороо. Яг саяын таны ярьж байгаатай холбогдуулаад ХЗБХ, Хүний эрхийн дэд хороон дээр энэ гэр бүлийн асуудлууд чиг үүргийнхээ дагуу ингээд холбогдож ажиллахаар байгаа, тэгж туссан байж байгаа төсөлд.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураахаар байгаа. Зарчмын зөрүүтэй 25 санал байгаа. Гишүүдийн ирцийг хангалттай болохоор санал хураалт явуулах учраас санал хураалтыг түр хойшлууллаа. Өнөөдөр хэлэлцэж байгаа асуудлуудаа тусгайлан цаг зарлаж байж нэг дор санал хураалт явуулъя гэж бодож байна.

Гурав.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Уянга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт нийтээр тэмдэглэх баярын өдрийн талаар хуульчилж, 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүдэд Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг, цагаан сарыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүдэд, шинэ жилийг 1 дүгээр сарын 1-ний өдөр, олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг 3 дугаар сарын 8-нд, Хүүхдийн баярыг 6 дугаар сарын 1-ний өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярыг 12 дугаар сарын 29-ний өдөр, Их эзэн Чингис хааны өдрийг Их эзэн Чингис хаан мэндэлсний билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 01-нд, Бүгд найрамдах улс тунхагласан өдрийг 11 дүгээр сарын 26-нд, Бурхан багшийн их дүйчин өдрийг билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн 15-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тус тогтоосон байна.

Мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлд дээр дурдсан нийтээр амрах 9 баярын өдрүүдээр амрахаар хуульчилжээ. Гэвч 1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 77.3 дахь хэсэгт нийтээр амрах баярын өдөр 7 хоног бүрийн амралтын өдөр ойрхон тохиосон тохиолдолд 7 хоногийн ажил амралтын өдрийг Засгийн газрын шийдвэрээр зохицуулж болно гэж заасны дагуу тэмдэглэн өнгөрүүлж байсан боловч 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тус зохицуулалт тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл нийтээр амрах баярын өдрүүд нийтээр амрах өдөр буюу амралтын өдөртэй давхацсан тохиолдолд хэзээ тэмдэглэх, уг асуудлыг хэн шийдвэрлэх нь тодорхойгүй байгаа бөгөөд тухайн ажил олгогчийн зүгээс мөн шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээ уг хуульд тусгагдаагүй байгаа.

Иймд нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах хэрэгцээ шаардлагыг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д заасны дагуу нэмэлт оруулах хуулийн төслийг, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамтад нь боловсрууллаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, О.Батнайрамдал нарын зүгээс 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг ТББХ 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд нийтээр тэмдэглэх баярын өдөр нийтээр амрах өдөртэй давхацсан бол дараагийн ажлын өдөрт шилжүүлэх зохицуулалтыг тусгажээ. Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд хуулийн төслийг parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хуулийн төсөлд туссан тайлбарын хэрэгцээ шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж ийм агуулга бүхий хуулийн төслийг ЗГ өргөн мэдүүлсэн эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх, үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 52,6 хувийн саналаар, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 55 хувийн саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууна. Урьдчилан ирүүлсэн нэрийн дарааллын дагуу Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Одоо хүчин төгөлдөр байгаа Нийтээр тэмдэглэх баярын тэмдэглэлт өдрүүдээр бид 9 баяраар нийтдээ 16 хоног амарч байгаа. 2022 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нийтээр амрах өдрүүдийг заасан болохоос яг энэ өдрүүд баярын өдөр таарвал дараа нь яаж ажлын өдөрт шилжүүлэх вэ гэдэг зохицуулалтыг нь огт тусгаагүй орхисон. Үүнд хамгийн их хөндөгддөг албан тушаалтан нь болохоор 1 дүгээрт төрийн албан хаагч, түүн дотор

даа ялангуяа цагдаа, онцгой байдлын албан хаагчид, эмч нар байдаг. Яагаад гэвэл эдгээр хүмүүс яг энэ баяруудаар илүү уртасгасан цагаар ажиллах шаардлагатай болдог. Яг эдгээр албан тушаалтнууд. Харьцангуй юу гэдэг юм цагдаагийн байгууллагууд шууд хэв журмын хамгаалалтад гардаг, эмч бол өвдсөн гэнэт өвдсөн үед яаралтай тусламж үзүүлдэг, онцгой байдал гэнэтийн байдалд бэлэн байж байдаг. Тэгээд энэ хүмүүсийн асуудал хамгийн их хөндөгддөг. Тэгээд энэ хүмүүсийн асуудлыг 1 дүгээрт яаж тусгаж байгаа вэ гэдэг ийм байгаа? Яагаад гэвэл энэ Хөдөлмөрийн тухай хууль дээр одоо тодорхойгүй байгаа.

Яагаад энийг асууж байна вэ гэхээр бид юмаа аягүй тодорхой болгохгүй бол 6 сарын 4-ний өдөр гэхэд Засгийн газар хуралдаад баяр наадмын 2 өдрийг гэнэт амралтын өдөр болгочхож байгаа юм. 17, 18-ны өдрүүдийг. Тэгээд энэ яадаг вэ гэхээр ажлаа жилээр төлөвлөдөг, хагас жилээр төлөвлөдөг, магадгүй 2 сараар төлөвлөдөг хүмүүст хамгийн том хохиролтой болчхож байгаа юм. Жишээ нь яг энэ 17, 18-ны өдрүүд Монголд ирэх гадна, дотнын хөрөнгө оруулагчид төрийн байгууллагуудтай уулзах гэхээр төрийн байгууллага нь хаалттай болчхож байгаа юм. Ингээд сарын өмнө. Бид гадаадын хөрөнгө оруулагчдыг байнга урьдаг, Монголд ирээрэй гэдэг. Гэтэл ингээд сарын өмнө манайх тэдний өдөр амарна гээд ингээд ойлгомжгүй байдлуудыг бий болгочихдог. Тийм болохоор төр өөрөө тодорхой, ойлгомжтой ийм байх ёстой шаардлагатай юм. Тэгэхээр энэ юмнуудыг яаж зохицуулж байгаа юм бэ?

Би зүгээр маш энгийн жишээ аваад хэлье. Яг ний нуугүй хэлэхэд баяр наадмын билет борлуулалт, тасалбар борлуулалт гэхэд бид санаж байгаа бол дөнгөж өнөөдөр зарлагдсан, тэгээд худалдаанд гараад дууссан. Тэгтэл playtime гээд хөгжмийн фестиваль нэг жилийн өмнөөс тасалбараа зараад эхэлдэг. Энэ юу вэ гэхээр урьдчилж юмыг бэлдээд байна гэсэн үг, хувийн хэвшлийнхэн, орчин үеийн залуучууд, гадаадын хөрөнгө оруулагчид юмыг маш нарийн төлөвлөдөг болсон. Тэр Монголын төрийн ойлгомжгүй, хэзээ амрах нь тодорхойгүй, гэнэт юу өөрчлөгдөх нь ойлгомжгүй ийм нөхцөл байдлууд ажиллахад маш хүндрэлтэй. Төсөл санаачлагч нь, төсөл санаачилсан 2 маань яг өөрсдөө гаднын байгууллагуудад ажиллаж үзэж байсан 2 хүн бол энэ маш хүндрэлтэй байдаг, гэнэт амрахаар болчихдог. Тэгээд ийм юмнуудыг бид анхнаасаа ингээд хуулийн хүрээнд тодорхой болгох хэрэгтэй байгаад байгаа юм.

Тэгэхгүй бол ингээд л гэнэт 1 сарын өмнө шийдвэр гараад л, бид 17, 18-ны өдөр амарна гэхихдэг. Тэгээд амрахаар тэр 17, 18-ны өдрүүдэд бид амарч байхад тэнд ажлаа төлөвлөсөн гаднын байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулагчид, дотоодынх ингээд ажиллахаа больчихдог. Тэгээд чүү ай гэж нэг хэдэн төрийн албан хаагч нарыгаа гуйж ажиллуулна, эсвэл хэдэн сайд нь үлдэнэ. Дараа нь баярын өдрүүдээр хүртэл бид амралтгүй ажилладаг шүү дээ гээд ялархдаг ийм байдал руу үнэхээр орж болмооргүй байгаа юм.

Тэгэхээр ялангуяа би дахиад онцолж асууя. Баярын өдрүүдээр онцгойлон илүү нэмэлт цагаар ажилладаг эмч, цагдаа, онцгой байдлын албан хаагчдыг яаж зохицуулж байгаа вэ? Эд нар ингээд одоогийн Хөдөлмөрийн хуулиар тодорхойгүй, тухайн байгууллагын удирдлагад нь ийм хэм хэмжээг нь хагас дутуу тодорхойлоод өгчихсөн байдаг. Гэтэл тухайн хүн дараа нь ажлын өдөр амрах шаардлага үүсдэг. Тэгэхэд тэр хүн гэр бүлээрээ амарч чаддаггүй. Яагаад гэвэл ажлын өдрөөр амардаг, хүүхдүүд нь хичээл сургуульдаа явдаг, эхнэр нь ажилтай байдаг гэдэг ч юм уу.

Ингээд ийм нөхцөл байдлууд маш их үүсдэг. Энэ дээр яаж хийж байгаа вэ гэдэг л ийм асуулт байгаа.

Ер нь бид маш тодорхой байх хэрэгтэй, маш тодорхой, ойлгомжтой байх хэрэгтэй. Энэ бид нэгэнт эдийн засаг хүндрээд, бид Алт 3, гадаадын хөрөнгө оруулалт нэмнэ гээд ингэж байгаа тохиолдолд бүгдийг тодорхой, ойлгомжтой байлгахгүй бол маш хүндрэлтэй нөхцөл байдлууд энэ, ялангуяа хувийн хэвшил талдаа үүсэж байна. Би саяын playtime-р чинь авч хэллээ шүү дээ. Жилийн өмнө тасалбараа зарж байна, манай наадам 7 хоног, 9, 8 хоногийн өмнө тасалбараа зарж байна. Энэ бол ингээд яг менежментийн л ялгаа харагдаж байгаа байхгүй юу. Энэ дээр би асуулт асуух гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Уянга гишүүн хариулт өгье.

Б.Уянга: Шижиr гишүүнд баярлалаа. Тодорхой болгох хэрэгтэй байгаа гэдэг дээр санал 100 хувь нэг байгаа. Тодорхой биш байгаагаас болоод асуудлууд их үүсэж байгаа учраас энэ хуулийн төслийг санаачлаад, ингээд ажиллалаа. Өчигдөр ТББХ-н дээр Пүрэвдорж гишүүн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ агуулга бүхий төсөл орж ирсэн тухай мэдээлэл өгсөн. Тэгэхдээ тэр төсөл Засгийн газар дээр 6 сарын 4-ний өдөр танилцуулагдах гэж ороод, бүрдэл дутуу гээд буцсан юм байна лээ. Тэгэхээр яах вэ зүгээр өнөөдөр Их Хурал дээр 2 гишүүн саяхан болж өнгөрсөн цагаан сартай холбоотой асуудлуудаас үүдээд хуулийг судлаад, энэ бол байх ёстой заалт юм байна гэдгээ одоо танд хэлэх гэж байгаа заалтыг оруулж ирэхээр ингэж төслөө бэлдсэн байтал, салбарын яам нь бас энэ асуудлыгаа засах гэж төстэй, тэгэхдээ арай өөр шүү, тийм зохицуулалтаар агуулгаа бэлдчихсэн ер нь байгаа юм билээ. Тэгээд яах вэ зүгээр манайх 4 сарын үед, 2025 оны 4 сард хэлэлцүүлээд эхлээд саналаа авсан учраас ингээд арай түрүүлээд ороод ирчих шиг боллоо.

Тодорхой бол биш байсаар л ирсэн юм билээ. 1999 онд анх энэ хуулийн агуулга нийтээр тэмдэглэх баяртай холбоотой зохицуулалтууд хэрвээ амралтын өдөр тохиовол яах вэ гэдэг нь хуульд тусгагдсан байх үедээ яг хэрвээ амралтын өдөр нийтээр тэмдэглэх баяр байвал өмнө нь шилжүүлэх үү, хойш нь байлгах уу гэдгийг Засгийн газар шийдвэрлэнэ гэсэн заалт байсан байна лээ. Тэгээд 2022 онд болохоор Хөдөлмөрийн хуулиас аваад хаячихсан. Тэгэхээр Засгийн газар шийдвэрлэнэ гээд л хэн нэгний шийдвэр хэрэгтэй байхаараа л нөгөөдөх нь тулж гардаг, нэг жилийн өмнө мэдэгддэг биш байдаг асуудлууд байдаг. Тэгэхээр энэ хуулийн төсөл дээр ажиллаж байх явцад хуульчидтайгаа ярилцаад юу гэх нь зөв бэ гэж үзсэн гэхээр нийтээр тэмдэглэх баярын өдөр нийтээр амрах өдөртэй давхацсан бол дараагийн ажлын өдөрт шилжүүлнэ л гэххэж байгаа. Ерөөсөө ганц хөндөж орж ирж байгаа заалт бол энэ юм байгаа юм. Тэгэхээр энийг хууль дээр тодорхой яаж сууж өгч байгаа вэ гэдэгтээ итгэл төгс байгаа вэ гэвэл Засгийн газрын шийдвэр хүлээх хэрэггүй. Жишээ нь хувийн хэвшлийнхэн энэ 6.4 гэсэн заалтыг хараад энэ жил жишээ нь цагаан сарын амралт, цагаан сарын тэмдэглэлт өдрүүд энэ, энэ амралтын өдрүүдийг хагассайныг ч юм уу дайрч байна гэвэл дараагийн автоматаар ажлын өдрөө тоолоод ингээд төлөвлөх эрх нь нээгдэж байгаа гэж харсан.

Тэгээд хуульчидтайгаа яриад, энэ заалтыг хөндөж орж ирж байгаа юм. Тэгэхээр эмч, цагдаа, онцгой байдлынхан эртнээс төлөвлөх энэ байдал нь 6.4 гээд энэ шинээр нэмж байгаа заалтыг дагаад зохицуулагдаад явна гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Уянга гишүүнд баярлалаа. Бид чинь 9, хуулиар тогтоосон 9 баяраар 16 хоног амарчхаад байгаа шүү дээ ер нь бол яг 16 ажлын өдөр гэж тооцож байгаа. Гэхдээ энэ 9-ийг арай их үү гэж миний хувьд бодож байгаа. Ер нь яг үндэсний гэдэг тэмдэглэдэг цагаан сар, үндэсний их баяр наадам, мөн Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний өдөр, Их эзэн Чингис хааны өдөр гэдэг ийм түүхэн ач холбогдолтой өдрүүдээр амардаг, бусад өдрөөр ийм ажилладаг хэлбэр лүүгээ оруулах ийм боломж байгаагүй юу? Тэгэхгүй бол бид яг ний нуугүй хэлэхэд Бурхан багш их дүйцэн өдөр гээд энэ амрах ач холбогдол нь хэр байдаг юм гэдэг дээр асуулт байна. Ер нь яг ийм түүхэн ач холбогдолтой Үндэсний их баяр наадам, цагаан сар, мөн Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны ой, Их эзэн Чингис хааны өдөр гэдэг ч юм уу ингээд түүх, энэ улсын чинь оршихуй, эс оршихуй дээр байж байгаа ийм бидний гол бусдаас ялгарч байгаа онцлог энэ зүйлүүдээ шингээсэн ийм баяруудаараа амардаг болбол яасан юм бэ гэсэн нэг ийм саналтай байгаа. Энэ дээр та хэд судалгаа хийж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Уянга гишүүн нэмж хариулъя.

Б.Уянга: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд таны хэлсэнчлэн 9 баярыг тусгаж өгсөн байгаа. Яг эдгээр баяруудыг амралтын өдөр байдлаар амарч өнгөрөөх нь зүйтэй юу гэдэг дээр яг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан нэлээн тийм өргөн хүрээний хэлэлцүүлэг хийж байж оруулж ирэх нь зүйтэй байх гэж үзсэн юм. Тэгээд яах вэ энэ хуулийн төсөл дээр хуульчидтай суугаад ажиллаж байхад ер нь бусад улсуудад нийтээр тэмдэглэдэг баярт өдрийг амралтын өдрүүдтэй нь хамтад нь зүгээр тооцож үзсэн юм. Бусад улсуудад ямар байна гээд. Тэгэхэд Оросын Холбооны Улсад 365 хоногийн 121 өдөр нь нэг бол хагас, бүтэн сайн дайраад, нэг бол нийтээр амрах баярын өдөр дайраад явдаг юм байна лээ. Америкийн Нэгдсэн Улсад 119, Японд 120, Австралид 115, Монгол болохоор 119 гээд ер нь л нэг ойролцоо, хагас, бүтэн сайнаа нэмээд л, баярын өдрүүдээ нэмэхээр нэг иймэрхүү л амарч байгаа мэдээлэл манай энэ дэлгэрэнгүй танилцуулгад байгаа.

Д.Амарбаясгалан: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Эхлээд би нэг зарын чанартай гэх үү нэг юм хэлчихье. Манай төв халхын Өндөр гэгээн Занабазарын мэндэлсний 390 жилийн ой энэ жил 7 сарын 25, 26, 27-нд Өвөрхангай аймагт зохион байгуулагдахаар байгаа. Тэгээд үүнд энэ Монгол төрийг түшилцэж байгаа, төрд зүтгэж байгаа та бүхэн морилохыг урьж байна. Манай Өндөр гэгээний бүтээл дэлхий дахинд суу алдраа мандуулсан энэ нэр алдар бол мөнхлөгдөж байгаа. Тэгээд энэ сайхан хүний энэ түүхэн ойд та бүхнийг ач холбогдол өгч, анхаарлаа хандуулна гэдэгт итгэлтэй байна. Засгийн газрын тогтоол гараад энэ арга хэмжээ 7 сарын 25, 26, 27-нд Өвөрхангай аймгийн төв дээр зохион байгуулагдаж байгаа.

Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад би 2 асуулт асуух гэсэн юм. 1 дүгээрт нь энэ Гадаад харилцааны яамнаас санал авсан уу? Бид чинь нөгөө хөрш орнуудтайгаа хилийн боомтоор холбогдож байгаа. Тэгээд бид өөрсдөө энд ингээд амралтын өдрийг шилжүүлээд байхаар нөгөө улсдаа мэдэгдэх, ер нь албан ёсны протокол энэ юм нь ямар байдаг юм бэ? Ийм учраас энэ Гадаад харилцааны яамнаас санал авсан уу гээд?

Нөгөө талд нь хувийн хэвшлээс санал авсан уу? Хувийн хэвшил цаг наргүй л ажилладаг, амралтын өдөр ч байсан ээлжээр ингээд ажиллаж байгаа. Төрийн албан хаагчид мэдээж амарч болох байх. Хувийн хэвшил ресторан, баар, зочид буудал, хими цэвэрлэгээ юу байдаг юм бүгд л, такси гээд ингээд л бүгд л нийтээр тэмдэглэх баярын өдөр ч бай, ер нь албан ёсны амралтын өдөр ч бай ингээд л ажиллаж байдаг. 52 долоо хоногийн, долоо хоногт 2 өдөр амарч байгаа. Нийт 52 долоо хоног жилийн 104 өдөр нь хагас, бүтэн сайн гээд амралтын өдөр байгаа. Үүн дээр дахиад бид энэ 9 албан ёсны нийтээр тэмдэглэх өдөр, энийг ингээд 16 хоног амарчхаж байна. Дахиад энэ хуулийн зүйл, заалт өөрчлөгдсөнөөр дахиад амралтын өдөр хасагдахгүй л дээ. Нэмэгдэнэ гэж ойлгож байна. Тэгэхээр магадгүй 20 болдог ч юм уу? Ингэхээр 104 дээр 20-ийг нэмэхээр 124 өдөр ч юм уу ингээд жилийн 365 хоногийнхоо 1/3 нь бид амарчхаж байна. 2/3 нь ингээд албан ёсоор ажлын өдөр байна.

Тэгэхээр энэ ер нь цаашдаа бид энэ тэмдэглэлт олон энэ баяраар амардгийгаа жоохон багасгах. Ер нь яг нэг өвөл, зун, улиралд 1 удаа ч юм уу амарсан шиг амраад, амралтын өдрийг 2, 3 өдрөөр байлгадаг ч юм уу ийм зохицуулалтуудыг сайн бодмоор юм шиг байгаа юм. Тийм учраас гол асуулт бол энэ Гадаад харилцааны яам, хөрш орнууд, тэгээд энэ хувийн хэвшилтэйгээ ер нь уялдуулсан уу, эд нараасаа санал авсан уу гэдэг ийм асуултыг тавья?

Д.Амарбаясгалан: Уянга гишүүн хариулт өгье.

Б.Уянга: Монгол Улсын, хуулийн төсөлтэй холбоотойгоор Засгийн газраар хэлэлцүүлээд тэмдэглэл нь ирсэн байгаа. Тэгэхээр Засгийн газар дээр Гадаад хэргийн сайд бол ерөнхий агуулгаа сонсоод, тэгээд дэмжсэн санал ирсэн юм байгаа юм. Тэгэхээр энэ асуудлууд хууль хэрвээ тодорхой байх тохиолдолд асуудал нь шийдэгдээд явна гэж үзсэн болов уу. Яах вэ яг энэ 6 сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд юу гэж тусгасан, юуг, ямар шийдвэр ирсэн гэхээр Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, О.Батнайрамдал нарын санаачлан боловсруулсан Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд, зарчмын хувьд дэмжиж, ёслол, хүндэтгэл, цар хүрээг нь харгалзан зөвхөн Монгол үндэстний уламжлалт цагаан сар, үндэсний их баяр наадам, тухайн долоо хоногийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амрах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах саналыг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов. Өөрөөр хэлбэл яг Хосбаяр гишүүн таны хэлж байгаа агуулгыг ерөнхийд нь хөндсөн ийм хариу ирсэн гэж ойлгож байгаа.

Тэгэхээр өнөөдөр бүгдээрээ өргөн барьсан хуулийн төслийн хүрээнд буюу хэрвээ энэ 9 баярын өдрүүд хагас юм уу, хагас, бүтэн сайн өдрийн аль нэгэнтэй нь давхацвал хэн нэгэн субъектээс яах вэ гэдгийг нь тогтоох бус яг тодорхой байдлаар яаж зохицуулах вэ гэсэн өгүүлбэр л хөндөгдөж орж ирж байгаа юм. Тэгээд хэлэлцэх эсэх нь дэмжигдээд, ажлын хэсэг нь гараад явах хүрээнд энэ Засгийн газраас албан ёсоор ирсэн саналыг тусгаад явах бүрэн боломжтой. Тэр үед ярилцах боломжтой байх.

Та сая хувийн хэвшлээс санал авсан уу гэж асуулаа. 4 сарын 5-ны өдөр 2025 онд d.parliament дээр хуулийн төслөө байршуулаад, тэгээд өөрсдийнхөө цахим сувгаар саналыг авсан байгаа. Тэгэхээр яах вэ уул уурхайтай холбоотой ростероор

ажилладаг тийм байгууллагуудыг цалинжуулдаг тийм нөхдөөс коммент байсан. Түүн дээр болохоор жишээ нь олон хоног үргэлжлээд амарч байх тохиолдолд амралтын өдрөөр амарч байгаа тэр цалинг нь тооцохтой холбоотой коэффициенттой холбоотой асуултууд байсан. Тэгэхдээ бидний өнөөдрийн оруулж ирж байгаа энэ хуулийн төслийн заалт болохоороо ямар нэгэн байдлаар амралтын өдрийг нэмэх гэхээсээ илүү тэртээ тэргүй хуульчлагдчихсан байгаа баярын өдрүүд амралтын өдрөөр тохиож байвал яах вэ гэдэг зохицуулалтыг нь л хийж өгч байгаа ийм өгүүлбэр байгаа юм. Нэмэлт асуулт байвал хариулъя. Тийм, уламжлалт Монгол, болно шүү дээ ажлын хэсэг дээрээ л.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Хуулийн төсөлтэй холбоотой нэг нэр томьёо дээр тодруулах зүйл байгаад байна. Энэ дээр нийтээр тэмдэглэх баярын өдөр, нийтээр амрах өдөр, хуулийн үзэл баримтлал дээр болохоор долоо хоногийн амралтын өдөр гээд байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн төслөөр болохоор нийтээр амрах өдөртэй давхацсан бол гээд ирэхээр ойлголтын хувьд төөрөлдөхөөр ийм агуулга байгаад байна. Тэгэхээр Хууль тогтоомжийн тухай хуулиар нэг нэр томьёогоор өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх гэсэн зарчим байгаад байгаа юм. Тэгэхээр энүүгээр хараад үзэхээр энэ нийтээр тэмдэглэх баярын өдөр долоо хоног бүрийн амралтын өдөртэй давхацсан бол нийтээр амрах өдрийг дараагийн ажлын өдөрт шилжүүлнэ гэж өөрчилж найруулбал иймэрхүү байдлаар өөрчлөхгүй бол ийм давхар утгатай юм шиг ойлгогдоод байна. Тэгээд өөрөөр хэлбэл энэ нийтээр амрах өдөр гэдэг дотор чинь нийтээр тэмдэглэх баяр чинь орчихсон байгаа, долоо хоногийн амралтын өдөр чинь орчихсон байгаа учраас энэ нэг агуулгын хувьд 2 янзаар ойлгогдох ийм эрсдэл байгаа. Тэгэхээр энэ талаар ажлын хэсэг юу гэж бодож байгаагаа тайлбарлаж өгөөч?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Уянга гишүүн.

Б.Уянга: Нийтээр тэмдэглэх баярын өдөр, нийтээр амрах өдөртэй давхацсан бол дараагийн ажлын өдөрт шилжүүлнэ гэсэн 6.4 гэсэн заалтыг нэмэхээр энэ хуулийн төсөл өргөн баригдсан байгаа. Тэгэхээр нийтээр тэмдэглэх баярын өдөр гэдэг нь нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заагдсан байгаа 9 баяртай холбоотой өдрүүдийг хэлж байгаа. Нийтээр амрах өдөр гэдэг нь болохоор хагас, бүтэн сайн өдрүүд бямба, ням гаргуудыг хэлж байна гэж ойлгогдож энэ өгүүлбэр бичигдсэн юм байгаа юм. Тэгээд хэлэлцэх эсэх нь шийдэгдээд, тэгээд яг найруулга дээр Улсын Их Хурлын Тамгын газар дээр нэлээн сайн яригдаж болох байх. Тэгэхдээ бидний гол зорилго хуулийнхаа энэ зохицуулалтыг тодорхой болгох байгаа. Хэрвээ яг хууль тогтоогчид маань уншаад тодорхой ийм нэг асуулт яг таны сая хэлж байгаатай адилхан аргумент гарч ирвэл найруулга дээр алдаа байна гэж бол үзэж байна. Тэгэхээр илүү сайн ярилцах нь зүйтэй байх.

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Тийм, яг тийм асуудал гараад байгаа юм. Нийтээр амрах өдөр гээд ирэхээр энэ өөрөө нийтээр тэмдэглэх баярын өдрөө агуулаад байгаа учраас тодорхой болгох үүднээс долоо хоногийн амралтын өдөр гээд найруулах нь илүү зөв болох юм уу гэсэн ийм бодолтой байгаад байгаа юм. Тэгээд ажлын хэсэг гараад,

хэлэлцэх эсэх нь дэмжигдвэл ажлын хэсэг дээр зарчмын зөрүүтэй санал оруулаад, оруулъя гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Уянга гишүүн.

Б.Уянга: Долоо хоног бүрийн амралтын өдөр буюу бямба, ням гараг гэдгээр Энхтүвшин гишүүний санал гээд тэмдэглээд авлаа. Тэгээд бүгдээрээ ярилцаад, илүү тодорхой болгож болох байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт авч, хариулт авч дууслаа. Санал хураалтыг хойшлуулна.

15.20 цаг

Энэ хэлэлцэж байгаа асуудлуудтай холбоотой санал хураалтыг 16 цаг 30 минут орчим дээр санал хураалт хийнэ. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Байнгын хороодын хурал дуусахгүй байгаа учраас гишүүдийг хурлыг нь дуусгахыг хүлээж байна.

Дөрөв.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё. Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсын иргэний харьяаллыг, харьяалал хийгээд, харьяат болох харьяатаас гарах үндэслэл журмыг гагцхүү хуулиар тогтооно гэж заасан. Харьяатын тухай хуулиар Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч хуулийн холбогдох хэсэгт заасан нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгож болно гэж заасан.

Харьяатын тухай хуулийн дээрх зохицуулалтад олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төлбөрт төрөлд онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч тус хуульд заасны дагуу Монгол Улсын харьяат болгох агуулга бүхий нэмэлтийг оруулахаар боловсрууллаа. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль дээр болно гэсэн агуулга нь сонголт бүхий зохицуулалтаар заасан бөгөөд аль нэг этгээдэд заавал үүрэг болгосон агуулга заалт байхгүй болно.

Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, хөгжлийн бодлогын бичиг баримтууд, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь биеийн тамир, спортын талаарх арга хэмжээнүүд нь Монгол Улсад нийтийн биеийн

тамир, үндэсний спортыг хөгжүүлэхээс гадна спорт дахь хүний нөөцийг шинэ түвшинд гаргах, олимпизмын хөдөлгөөнийг дэмжих, ялангуяа олимпын хөтөлбөрт багтах спортын төрлийг дэмжих нэгдмэл зорилготой байна. Иймд хуулийн төслийн тандан судалгааны тайланг үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын олимпын төрлийн спортыг хөгжүүлэх, багийн спортыг хөгжүүлэх зорилгоор гадаад улсын дасгалжуулагч, мэргэжилтнийг урьж ажиллуулж байгаа ажил олгогчийн ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх зохицуулалтыг мөн дагалдах хуулиар тусгалаа. Нэгдсэн Үндэстний Байгууллагын зүгээс спортоор дамжуулан энх тайван, эв нэгдэл, эрх тэгш байдал, тогтвортой хөгжлийг ухуулан таниулахад ихээхэн ач холбогдол өгч байна. Өөрийн улсын нэрийг гаргах, түүгээр дамжуулан амжилт гаргах, өсөн дэвчих боломжтой улс орон хэмээн бусдад хоногшуулах нь спортын гүйцэтгэх чухал үүрэг юм.

Улс орнууд спортоор дамжуулан үндэсний үнэт зүйлээ, амин чанар, бахархлаа улам бэхжүүлж, шинэ залуу үеийнхэнд үндэсний үнэт зүйлийг таниулан бэхжүүлж, ашиглахын зэрэгцээ хүүхэд, залуучуудыг спортын нөлөөгөөр хүсэл мөрөөдөлтэй, тууштай, тэвчээр хатуужил, зөв төлөвшилтэй болгоход хүмүүжүүлэхэд анхаарч байна. Түүнчлэн спортыг түшиглэн аялал жуулчлал, үзвэр үйлчилгээ, хөрөнгө оруулалт, эдийн засаг, нийгэм, соёлын хамтын ажиллагааг өрнүүлж байна. Олимпын үзэл санааг дэлгэрүүлэх, спортод өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор, түүнчлэн спортын нийгэм, эдийн засгийн нөлөөллийг хүлээн зөвшөөрч, амжилт гаргах магадлалтай гадаадын иргэнд өөрийн улсын нэр дээрээс тэмцээнд оролцуулах замаар бусад орнууд ч гэсэн зохицуулалтыг хийж байна.

Дээрх хэрэгцээ шаардлагыг үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ч.Ундрэм, Н.Батсүмбэрэл, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, А.Ганбаатар, Д.Ганбат, Б.Жавхлан нарын хамтаар Харьяатын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулан та бүхэндээ танилцуулж байна. Түүнчлэн Засгийн газрын 2023 оны 62 дугаар тогтоолоор Харьят болгох журмыг нарийвчлан зохицуулж, Засгийн газрын хуралдаан, Ерөнхий сайдын танилцуулсны үндсэн дээр Ерөнхийлөгчид хүргүүлдэг процедур улам сайжирсан гэдгийг энэ ташрамд хэлмээр байна.

Хуулийн төслийг d.parliament.mn дээр байршуулан олон нийтээс санал авч байгаа болно. Хууль тогтоомжийн хуульд заасан шаардлагын дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авсан бөгөөд Олимпын үндэсний хорооноос хуулийн төслийг дэмжсэн санал ирүүлсэн болно. Хуулийн төслийн үзэл баримтлалыг Байнгын хороонд, Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нараас 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Харьяатын тухай хуульд нэмэлт

оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь спортын хөгжлийг дэмжих, хүний нөөцийг бэлтгэх, ялангуяа олимпын спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын харьяат болгож болох агуулга бүхий нэмэлт оруулах зохицуулалтыг тусгаж, хуулийн төслийг боловсруулжээ.

Хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад цаг хугацааны, хүний нөөцийн болон мөнгөн зардал үүсэхгүй гэж үзсэн байна. Уг хуулийн төслийг www.d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гадаадын зарим тамирчид Монгол Улсын нэрийн өмнөөс тэмцээнд оролцож амжилт гаргах болсонтой холбогдуулан хэчнээн гадаадын тамирчин, тэр дундаа олимпын төрөлд амжилт гаргах боломжтой хүмүүс иргэншил хүссэн эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулахад Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүд урьдчилж нэрээ ирүүлээгүй байна. Санал хураалтыг түр хойшлуулна.

15.28 цаг

Тав. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нарын 89 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Дараагийн асуудалд оръё. Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Нийслэлийн асуудал санал хураалтын дараа орно. 4 цаг 30, 16 цаг 30 минутаас санал хураалт явагдаад, тэрний араас

орно. Одоо Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал нарын 89 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2025 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасныг баримтлан тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ, хязгаар Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж, тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Энэ тийм Онтрагийн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах саналтай холбоотой асуудал явж байна, тогтоолын төсөл. Гишүүд нэрээ өгье. 2 гишүүнээр тасаллаа. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Да.Цогтбаатар: Оюу толгой төсөл өөрөө Монгол Улсад маш том төсөлд орж явж байгаа. Тэгээд энэ төсөл дээр Улсын Их Хурлын 81 нэр бүхий гишүүд ажлын хэсэг байгуулах нь зүйтэй. Монгол Улс байгуулсан гэрээ контрактаа эргэж харж, шинэчилж, сайжруулах ёстой гэдэг байр суурь дээр нэгдсэн. Миний бие энэхүү хяналт шалгалт хийх энэ хяналтын сонсгол хийлгэх энэ ажлын хэсэгт дэмжиж гарын үсэг зурсан. Энэ Улсын Их Хурлаас байгуулагдах ажлын хэсэгт албан ёсоор ажлын хэсгийн гишүүн болж орох саналаа илэрхийлж байна.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Эрдэнэбат: Оюу толгойн бүлэг ордтой холбоотой энэ Онтра-тай байгуулсан энэ гэрээ контракттай холбоотой асуудлаар сонсголыг хяналт шалгалтын түр хороо байгуулах асуудлыг дэмжсэн. Тэгээд үүнтэй ижилхэн ер нь өөр олон энэ стратегийн ордуудтай холбоотой ийм зүйл гарахыг үгүйсгэх аргагүй юм байна лээ. Тийм учраас энэ тал дээр ажлын хэсэгт оруулах саналаа хэлсэн байж байгаа. Тэгээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс асуухад энэ гэрээтэй холбоотой болон мөн тухайн үед Оюу толгойн гэрээг байгуулах гэж байгаатай холбоотой магадгүй анзаараагүй орхисон, хуулийн цоорхойг орхисон, мөн хууль тогтоомжтой холбоотой зарим цоорхой, хууль, эрх зүйн хувьд эргэж авч үзэхэд тээг саад болох ийм асуудлуудыг хэр зэрэг тооцож байгаа вэ гэдэг зүйлийг асуумаар байна.

Д.Амарбаясгалан: 89 гишүүн санаачилсан тогтоолын төсөл байгаа. Байгуулсны дараа Эрдэнэбат гишүүн ажлын хэсгээс асуулт асуух нь зүйтэй байх гэж бодож байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

15.36 цаг

7 дахь асуудал Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Улсын Их Хурлын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Байнгын хороо арай бэлэн болоогүй байна уу санал, дүгнэлт нь? Бэлэн болоогүй байна. Тэгэхээр санал хураалтууд руу орно. 16 цаг 30 минутаас санал хураалт явуулна гээд гишүүдэд зар хүргэчихсэн байгаа учраас 16 цаг 30 минут хүртэл чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулъя. Гишүүд яг цагтаа цуглахыг хүсье.

Зургаа.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Эхлээд хэлэлцэх эсэх танилцуулга хийгдэж байж болох юм байна. Асуулт хариулт явж байж болох юм байна. Тэгэхээр 4 дэх асуудал буюу, 5 дахь асуудал буюу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх нь. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайвангийн Бат-Амгалан уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Бат-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-ээс 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.2.5-д хот суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төлөвлөсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцын хороолол болгон хөгжүүлэх, хотын авто замын бүсчлэлийг тогтоож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах гэж, 3.2.13-д гэр хорооллын дундын болон захын бүсийг тэргүүн ээлжид инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр, эсвэл

хувийн хэвшлийн орон сууцаар шууд солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4.4-д Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагын төвийн системд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, гэрлэн дохионы зохицуулалтыг хөдөлгөөний урсгалаас хамаарч ухаалгаар зохицуулах боломжийг бүрдүүлнэ гэж, 1.1.3.1-д Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг үргэлжлүүлэн чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20 мянган айлыг орон сууцжуулах үйл ажиллагаагаар төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж Толгойт, Шар хад, Дэнжийн мянга, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд төв бүтцийг барьж байгуулна гэж заасан.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотой эдийн засаг, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг авах зорилгоор нийслэл рүү чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэж, 1990 онд 560,6 мянган хүн амтай байсан нийслэл Улаанбаатар хот 2000 онд 747,1 мянга, 2010 онд 1 сая 112 мянга, 2025 онд 1 сая 768,1 мянган хүн амтай болж өссөн бөгөөд үүнтэй холбоотой авто замын түгжрэл, агаар орчны бохирдол, гэр хорооллын тэлэлт гэх мэт үр дагаврыг бий болгоод байна. Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн зорилт нь иргэдийг саадгүй зорчих нөхцөл, нийтийн тээврийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах асуудал юм.

Хуулийг хэрэгжүүлж эхэлсэн 1 жил 6 сарын хугацаанд нийслэлийн нийтийн тээврийн шинэчлэл, авто зогсоолын менежмент, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх асуудал, гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагаа шинэ шатад гараад байна. Судалгаанаас харахад Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг батлагдах хүртэл хугацаанд буюу 2015 онд 72, 2016 онд 145, 2017 онд 253, 2018 онд 924, 2019 онд 576, 2020 онд 354, 2021 онд 138, 2022 онд 744, 2023 онд 202 нэгж талбарыг чөлөөлсөн бол хууль батлагдсаны дараа буюу 2024 онд 2082 нэгж талбарыг чөлөөлөөд байна. Нийслэлийн агаар, хөрс, орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэх, авто замын түгжрэлийг бууруулах, иргэдийн амьдрах таатай орчин нөхцөлийг сайжруулах үндэс шийдэл, оновчтой гарц нь гэр хорооллыг инженерийн дэд бүтцээр хангах дахин төлөвлөж барилгажуулах юм.

Ирэх жилүүдэд 20 минутын хот үзэл баримтлалын хүрээнд нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээд, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг дан ганц орон нутгийн төсвөөс шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүсээд байгаа бөгөөд газрыг өөрийг нь эргэлтэд оруулж, асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 18-ны 86 дугаар тогтоолоор Нийслэлийн теле камерын нэгдсэн төв байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгасан бөгөөд нийслэлийн теле камерын

нэгдсэн төв нь 9 дүүргийн Засаг даргын дэргэд Теле камерын хяналтын дэд төвүүдийг байгуулаад байна. Улаанбаатар хотын 176 уулзвар, гарц, авто замд 2606 камер суурилуулж, 10 төрлийн зөрчлийг хиймэл оюунд суурилсан систем ашиглан илрүүлэх нөхцөл бүрдсэн.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсрууллаа. Тодруулбал Нийслэл хотын газрыг дахин төлөвлөх, гэр хорооллыг орон сууцжуулах, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, орон сууцын санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн зохицуулалт, мэдээллийн систем, хиймэл оюун ашиглаж замын хөдөлгөөний урсгалыг оновчтой зохион байгуулах, түгжрэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах, зөрчил илрүүлэх, ослын хяналтыг сайжруулах зохицуулалт, мөн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн хүрээнд баригдсан орон сууцын газар чөлөөлөлтийн болон газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор борлуулах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулж, иргэдийн саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, гэр хорооллыг орон сууцжуулж иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, агаар, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилтын хүрээнд хуулийн төсөлтэй холбогдуулан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг ТББХ 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөл нийслэл хотын газрыг дахин төлөвлөх, гэр хорооллыг орон сууцжуулах, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, орон сууцын санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай газрыг дахин төлөвлөх гэр хорооллын хөгжлийн сан байгуулах, түүний хөрөнгийн эх үүсвэр санхүүжилтийн асуудал, мөн замын хөдөлгөөний урсгалыг оновчтой зохион байгуулах, түгжрэлийг бууруулах,

аюулгүй байдлыг хангах, зөрчил илрүүлэх, ослын хяналтыг сайжруулахад мэдээллийн систем, хиймэл оюун ашиглах талаар зохицуулалтыг тусгажээ.

Хуулийн төсөл батлагдсанаар тээврийн хэрэгслийн цахим системтэй холбогдсон радио давтамжаар тодорхойлох төхөөрөмж байршуулахад нэг удаа гарах нийт зардал 4 тэрбум 596 сая төгрөг. Түүнчлэн төлбөр төлөгч хуулийн этгээд замын хөдөлгөөний төлбөртэй бүсэд нэвтрэх төлбөрийг нэхэмжлэх үүссэнээс хойш ажлын 10 өдөрт багтаан холбогдох Төрийн санд төлөх үүрэг үүргийг хэрэгжүүлэхэд нэг жилд нийт 1 тэрбум 491 сая 890 мянган төгрөгийн зардал гарах талаар тооцоолсон байна. Хуулийн төслийг d.parliament цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн тайлан зарцуулалтыг ил тод, нээлттэй байх, мөн сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 52,9 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 64,7 хувийн саналаар, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64,7 хувийн саналаар, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 58,8 хувийн саналаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64,7 хувийн саналаар, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 58,8 хувийн саналаар, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 58,8 хувийн саналаар, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 58,8 хувийн саналаар, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 58,8 хувийн саналаар, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 58,8 хувийн саналаар, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 52,9 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг

хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууя.

Б.Хэрлэн: Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ саналыг зарчмын хувьд дэмжиж байна. Энэ дээр надад нэг тодруулж асуух 2 зүйл байна. Ялангуяа газрыг дахин төлөвлөх гэр хорооллын хөгжлийн санг байгуулахтай холбоотой тодруулах зүйл байна. Тэгэхээр энэ дээр ерөнхийдөө энэ газрыг дахин төлөвлөж, гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгийг юу юунд зарцуулах вэ гэдгийг энэ дээр 7.3 дээр тодорхой заасан байна л даа. Энд нөгөө газраа чөлөөлсөн иргэдэд түр суурьшуулах орон сууцын асуудлыг шийдвэрлэх тухай асуудал энд орох уу, үгүй юү? Ер нь нэлээн олон иргэд чинь нэг амьдарч байсан орон байраа суллаж өгөөд, газраа чөлөөлж өгөөд явчихдаг, байр түрээслээд амьдардаг, түрээснийх нь төлбөр зардлыг нь дийлэхгүй болоод явчихдаг. Тэгээд нөгөө байр нь ашиглалтад орохгүй хэсэг хугацаанд орох орон байрны хувьд хүндрэлтэй, дээр нь санхүү эдийн засгийн хувьд маш хүндрэлтэй асуудалд ороод байдаг иргэд их олон байгаад байдаг. Тэгэхээр энэ сангийн мөнгө энэ түр суурьшуулах орон сууцын асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээгээр зарцуулагдах уу, үгүй юү гэж 1 дүгээрт асуумаар байна?

2 дугаарт нь тухайлбал энэ сангийн хөрөнгө нөгөө ийм тэгш зарцуулагдах үүднээсээ магадгүй энэ дээр биччихсэн байна л даа. 7.3.3-д тухайлбал ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцын барилгыг буулгах, шинээр барихад энэ хөрөнгөөс зарцуулна гээд биччихсэн байгаад байна. Тэгэхээр энэ дээр 7.3.1 дээр нь ингээд ер нь инженерийн болон нийгмийн дэд бүтцийг бий болгоход зарцуулагдана гээд явчихсан байгаад байна. Тэгэхээр энэ өөрөөр хэлбэл нөгөө гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудал хийгдэж байгаа газар орон нутгууд чинь хөгжлийн хувьд, байршлын хувьд харилцан адилгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ сангийн хөрөнгийг аль болохоор жигд тэгш ингээд хүртээхийн тулд энэ дээр ямар зарчим баримтлах вэ? Тухайлбал хотын төв газруудад нөгөө ашиглалтын шаардлага хангахгүй барилгууд их олон болоод явчихна, олон байгаа байх. Тэгэхээр тэрийг чинь нураагаад, дахиад шинэ дээр барихад магадгүй энэ сангийн хөрөнгө түлхүү тийшээ хотын төв рүү арай орчих гээд байх юм биш байгаа даа гэж. Үгүй бол бүүр хотын захад болохоор чинь нөгөө дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ байхгүй газар ахиад өртөг тийшээ их шингэсэн ийм төслүүд хэрэгжвэл тийшээ мөнгө дийлэнх нь явчих юм биш байгаа даа. Тэгэхээр энийг тэнцвэртэй зарцуулах тал дээр ямар бодлого барих гэж байгаа гэж асуумаар байна?

3 дугаарт нь ерөнхийдөө энэ сангийн хөрөнгийг зарцуулахад тэр нөгөө ногоон байгууламжийн, ногоон байгууламжийг хөгжүүлэхэд энэ сангийн хөрөнгөөс зарцуулах тухай тийм санаанууд энд орох уу гэж би тодруулж асуух гэсэн юм?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Энхтайваны Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Маамын Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга, Ичинноровын

Баттөгс Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын зөвлөх. Нямбаатар дарга хариулт өгье, 4 дүгээр индэр.

Х.Нямбаатар: Хэрлэн гишүүний асуултад сүүлийнхээс нь хариулъя. Бид 2023 оны 12 дугаар сард Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлахтай зэрэгцэж Улаанбаатар хотод баригдах барилгын ногоон байгууламжийн харьцаанд өөрчлөлт оруулсан. Өөрөөр хэлбэл нийт барилгажих талбайн 60 хувьд нь барилгажна, үлдсэн 40 хувьд нь ногоон байгууламж, авто зам, зогсоол, хүүхдийн тоглоомын талбай байхаар ийм өөрчлөлтийг оруулсан. Тэр утгаараа Гэр хорооллыг орон сууцжуулах энэ хуулийн хүрээнд газар чөлөөлөлтийн сангаас хамгийн 1 дүгээрт бид газар чөлөөлөлтийн ажлыг зохион байгуулна. 2 дугаарт бид чөлөөлөгдсөн газар дээр инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг татах ажлыг зохион байгуулна. 3 дугаарт ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дахин барихад энэ сангийн хөрөнгийг зарцуулна гэж байгаа.

Сангийн өөрийнх нь хөрөнгийг захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлахаар байгаа. Саяын таны асуусан асуултын 2 дахь зүйл бол энэ ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцад амьдарч байгаа хүмүүсийн барилга орон сууцыг буулгасан тохиолдолд тэр хүмүүсийг түр орон сууцад шилжүүлэх зохицуулалт хөрөнгө эндээс гарах уу гэхээр энэ яг энэ тохиолдолд гарч явна. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцуудыг бид ерөнхийдөө ихэвчлэн төр, хувийн хэвшлийн түншлэлээр явуулъя. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр ашиглалтын шаардлага хангахгүй барилгууд дээр тендер зарлах замаар одоо ч гэсэн явж байгаа энэ жишгээрээ явж байгаа.

Бид нарын нэг гаргасан шийдвэр 40, 50 мянгат орчмын хотын төвийн 4 давхар орон сууцуудыг үндсэндээ одоогоор шийдэл гаргахгүй, 2040-өө батлагдсаны дараа өндөржилт, барилгажилтын хэмжээний талаар Их Хурлаас батлагдсан ерөнхий төлөвлөгөө, үргэлжилж батлагдах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнийхөө хүрээнд энэ хавийг шийдье. Бусад ашиглалтын шаардлага хангахгүй газрууд дээрээ тендер зарлаад явж байгаа. Тухайлбал энэ 4 дүгээр дэлгүүр орчим дээр тендерүүд зарлагдчихсан явж байгаа гэдгийг хэлье.

Газрын хөгжлийн сангийн хувьд яагаад бид энэ хуулийг өнөөдөр ингээд зайлшгүй оруулж ирэх шаардлага үүссэн бэ гэхээр яг өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод энэ 8, 9 дүгээр сараас эхэлж зарах урт хугацаатай хөгжлийн зээлээр баригдсан болон буцалтгүй тусламжаар баригдсан 2 мянга орчим айлын орон сууцыг бид зарах шаардлага үүсэж байгаа юм. Энэ зарах, зарагдсан барилгыг бид нэгдсэн санд төвлөрүүлээд, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнийхөө дагуу газар чөлөөлөлтийн ажлуудыг төлөвлөгөөтэй үргэлжлүүлж явуулах, түүндээ дэд бүтэц татах шаардлагатай байгаа. Өмнө нь ийм зорилготой хэд хэдэн барилгууд баригдсан. Бондын мөнгөөр хэд хэдэн орон сууцын хорооллууд боссон боловч дараа дараагийн газар чөлөөлөлтийнхөө сан нөхөн бүрдүүлэлтийг хийгээгүйн улмаас газар чөлөөлөлтийн ажлууд ингээд үндсэндээ өнгөрсөн жилүүдэд явагдаагүй энэ гашуун туршлага дээр үндэслэж бид энэ санг байгуулж байгаа.

Д.Амарбаясгалан: Хэрлэн гишүүн тодруулъя.

Б.Хэрлэн: Яг тэгэхээр энэ газар ашиглалтын биш, газар дахин төлөвлөх гэр хорооллын хөгжлийн сангийн удирдлага, зохион байгуулалт, энэ хяналтын энэ үйл

ажиллагаанд иргэдийн оролцоог, оролцогч талуудын идэвхтэй, тэгш оролцоог хангах тал дээр та ямар бодлого баримтлах вэ гэж би асуумаар байна?

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга нэмж хариулъя.

Х.Нямбаатар: Би өмнө нь хэлсэн газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг НИТХ батална. Энэ баталсан акт нь өөрөө нийтээр дагаж мөрдөх акт учраас ХЗДХЯ-ны захиргааны актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж явна. Энэ утгаараа иргэдийн оролцоо тухайн Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, тухайн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тухайн нэгж хорооллыг хөгжүүлэх төлөвлөгөөнд нийцүүлж, энэ хөрөнгийг захиран зарцуулах энэ чиглэлээр ажиллана. Мэдээж хэрэг олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт, төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж, энэ хөрөнгийг захиран зарцуулах Удирдах зөвлөл бүрэлдэж ажиллана л гэсэн ийм үндсэн төлөвлөлттэй байгаа. Журам маань тэгж боловсрогдоно хууль батлагдсаны дараа. Удирдах зөвлөлд орох бүрэлдэхүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах яг одоогийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Энэ хуулийг ер нь дэмжиж байгаа. Бид энэ миний хувьд ч гэсэн энэ орон сууцжуулалтын бодлого дээр, Сэлбэ бүтээн байгуулалтыг энэ газар чөлөөлөлтийн журам дээр ажиллаж байсан хүний хувьд бид энэ орон сууцжуулалтын бодлогоо олон нийгмийн төлөөлөл оролцсон ийм орон сууцын нийгмийн талаас нь бодлогоо харж хийхийн тулд энэ өөрчлөлтүүд их чухал байгаа. Тэгэхгүй бол бид өмнөх улсуудын өөр улсуудын алдааг давтаж, зөвхөн юу гэдэг юм нэг нийгмийн төлөөлөл, нэг давхаргын төлөөлөл ч гэдэг юм уу, Америк эд нарт нэлээн тийм орон сууцжуулалтын төлөвлөлт дээр гарсан алдаанууд байдаг. Тэрийг давтахгүйн төлөө энийг дэмжиж байгаа.

Энэ дээр ганцхан асуулт байна. Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн өөрчлөлт дээр байх шиг байсан 7.1.1 дээр нөгөө дэмжлэг үзүүлэх асуудал дээр автобусны гэсний дараа таксины гэж орж байгаа юм байна. Энэ таксины гэдэг дээр ямар дэмжлэгийн талаар ер нь оруулж ирж байгаа юм бол энэний талаар эхлээд нэг тайлбар авъя гэж бодож байна?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье, Нийслэлийн Засаг дарга Нямбаатар дарга, 4 дүгээр индэр.

Х.Нямбаатар: Бид хэд яг Номинчимэг гишүүн зөв хэллээ. Бид анх удаагаа Нийтийн тээврийг хөгжүүлэх сан гэдэг санг байгуулсан. 2009 онд Засгийн газраас 400 автобус нийтийн тээврийн парк шинэчлэлийг хийж өгөөд, харамсалтай нь энэ 400 автобусыг төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад шинээр нь нийлүүлсэн боловч эргэн төлөлт огт хийгдэхгүй явсан. Хамгийн сүүлд Улсын дээд шүүхээс 2016 онд байдаг байх, бүр ашиглалтын хугацаа дууссаных нь дараа нөгөө аж ахуйн нэгжүүдээс нийслэл автобусныхаа нөгөө кузовыг буцааж авбал боломжтой, авах боломжтой гэдэг ийм айхтар шийдвэр гарсан. Ингээд бид Нийтийн тээврийг хөгжүүлэх санг эргэж байгуулаад, өмнөх тэр 400 автобусны эргэн төлөлт, сүүлд авсан саарал автобуснууд, улаан автобуснуудын эргэн төлөлтийг бид 7 жилийн хугацаатай, жилийн тодорхой хувийн хүүтэйгээр нийтийн тээврийг хөгжүүлэх санг бүрдүүлээд явж байгаа.

Ингээд нийтийн тээврийн зөвхөн нэг төрөл дээр бид илүү анхаарахаасаа илүүтэй цаашид нийслэлийн нийтийн тээврийн нэг төрөл хэлбэр болох таксины үйлчилгээг стандартын дагуу Монгол Улсад нэвтрүүлъя. Энэ утгаараа нийтийн тээврийг хөгжүүлэх сангаас такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагуудад тодорхой хүүтэй, тодорхой нөхцөлтэйгөөр нийтийн тээврийг хөгжүүлэх сангаас таксины үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлдэг ийм хэлбэр лүү шилжье гэж байгаа юм. Өнөөдөр манай улсад таксины тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж байгаа. Үүнээс гадна Uber-тэй төстэй ийм аппликэйшнд суурилсан үйлчилгээнүүд байгаа. Бусад дэлхийн жишиг хотуудад байдаг таксины үйлчилгээний тэр төрөл, хэлбэрийг нэвтрүүлэхийн тулд Нийтийн тээврийг хөгжүүлэх санд заасан журмын дагуу бид таксины үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх хүүтэй, эргэн төлөлттэй ийм зээл олгох механизмыг бий болгоё л гэдэг энэ агуулгаар орж ирж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Хэдэн асуулт асуух гэсэн юм. Өмнө нь энэ Улаанбаатар хот чинь ер нь их зайгүй шигүү хот болчихсон, барилга буулгаад барилга барьдаг. Жишээлэхэд энэ төмөр зам хавиар байгаа 3 давхар орон сууцыг буулгаад 20 давхрыг барихаар хэмжээний газар байхгүй байхад л чихээд л 20 давхрыг бариад байхаар яаж тэнчээ түгжрэл бууруулах вэ, тэнчээ үсрээд л 20, 30 айлын асуудал шийдэгдэж байсан газар дээр 200, 300-гаар нь чихээд байхаар түгжрэлийн асуудлыг яаж шийдэх вэ? Энийг ойлгохгүй байгаа. Тэгээд хотоо тэлэх, энэ дээр таны байр суурийг сонсох гэсэн юм.

Тэгээд хотоо тэлэх, дэд бүтцээ өргөтгөх төвүүдийг олноор барьж байж энэ дахин төлөвлөлтөд орж байгаа 3 давхар орон сууцыг үсрээд л 5 юм уу, 6 давхраар бариад л нэг барилгын компани ашигтай ажиллаад л болчихвол болчихмоор санагдаад байгаа юм. Тэгээд энэнийхээ оронд бүр хотоо тэлээд, дэд төвүүдээ бариад тэр дулааны, цахилгааны, усны дэд төвүүдээ бариад явбал илүү өргөн ийм тэлсэн хот болж чадах юм биш үү? Энэ дээр таны байр суурийг сонсох гэсэн юм.

Энэ замын түгжрэлийн чинь үндсэн асуудал нь ер нь автомашины асуудал. Танай дарга нар Байнгын хорооны хурал дээр орж ирчхээд лизингээр приус авч унаад байгаа хүмүүсийг буруутгаад бүүр үзэн ядаад яриад байхаар нь би 2, 3 үг хэлсэн юм. Тэрэн дээр буруу ойлгосон байж магадгүй. Гэхдээ жолооч нарт асуудал байгаад байна. Яг үнэхээр ур чадвар муутай жолооч нар бэлдээд байгаа жолооны курсүүддээ ямар арга хэмжээ авах юм, саад учруулж дүрэм зөрчөөд байгаа тэр жолооч нарт ямар арга хэмжээ авах юм, улаан гэрлээр улаан цагаан цагдаа нь зохицуулаад байхад дүрэм зөрчөөд байгаа жолооч нартаа ямар арга хэмжээ авах юм гээд нэг ийм авч байгаа арга хэмжээнүүд чинь нэг жоохон бодитой үр дүнтэй, тэр хариуцлага зөрчөөд байгаа жолооч нарт нэг ийм үнэхээр хариуцлага болохуйц хэмжээний юу гэдэг юм Австрали энэ тэрд 500 долларын торгуулийн хуудас ирнэ гээд хэн ч дүрэм зөрчихгүй болчихож байгаа шүү дээ. Тэгээд эд нарыг ингээд хатуугаар авч хэрэгжүүлэх ийм арга хэмжээнүүд бэлдэж байгаа юмнууд юу байна вэ?

Улаанбаатарын түгжрэлийн үндсэн шалтгаан чинь өөрөө автомашин. Хэн ч маргахгүй. Манай нийслэл хүртэл өөрсдөө автомашины шинээр орж ирж байгаа импортын автомашинд улсын дугаар олгох эсэхийг нэлээн хязгаарлаад явж байгаа

бодлого хэрэгжүүлж байгаа. Тэгтэл нийслэл өөрөө манлайлал үзүүлээд би бол танай нийслэлийнхнийг мэдэж байна, энэ дарга нь бүгдээрээ нэг ланд 300 унах нь унаад л, үнэтэй нөгөө микро унах нь унаад явж байгаа юм. Тэгэхээр та нар өөрсдөө манлайлал үзүүлээд юу гэдэг юм тэр скүүтэр, суррон, энэ автобус энэ тэрээрээ яваад байж болдоггүй юм уу? Энэ Нийслэлийн Засаг дарга намайг Улсын Их Хурлын гишүүн болж байхад энэ Ордон руу хүртэл автобус явуулаад түгжрэлгүй явъя гээд байсан та нар бүгдээрээ нийтийн тээврээ хэрэглэж байгаа юу? Миний хувьд төрөөс машин тэрэг унадаггүй учраас тэрийгээ албан ёсоор хэлж байгаад асууж байгаа юм асууж байгаа шүү. Энэ дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга 4 дүгээр микрофон.

Х.Нямбаатар: Би Цогтбаатар гишүүний эхний барилгажилттай холбоотой асуулт асууя. Яг энэ утгаараа бид дахиж ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцуудын барилгажилтын өндөр, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцуудын барилгажих талбайн хэмжээн дээр стандартад өөрчлөлт оруулсан. Тэр утгаараа төмөр зам орчмын тэр 3 давхар барилгууд дээр хамгийн сүүлийнх нь олон улсын билетийн кассын баруун талд байдаг 3 давхар барилгын тендер нь бүр эрт зарлагдаад, 3 удаагийн шүүхээр явсан энэ асуудлаар ингээд энэ хавийн барилгажилттай холбоотой зөвшөөрлийг зогсоож байгаа. Бид одоо юуг хүлээж байгаа вэ гэвэл Их Хурлаар Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөгөө батлагдахыг хүлээж байгаа. Ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг бид Засгийн газрын хуралдаанаар батлуулж чадвал дахиж Улаанбаатар хотоос архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын өндөр, намтай холбоотой зөвшөөрөл огт болино. Өөрөөр хэлбэл бид нэг мөсөн барилгажилтынхаа өндөр, нам, өргөн, нарийн, хорооллынхоо барилга, орон сууцын тоо хэмжээг нэг мөр Их Хурал, Засгийн газрын хуралдаанаар батлуулаад, тухайн газар эзэмшигч тэр зөвшөөрөгдсөн тэр хэмжээ, норм нормативын дагуу өөрөө байрлах энэ эрх, барилгаа барих энэ эрх зүйн орчныг бүрдүүлэхээр төлөвлөж байгаа.

Хот төлөвлөлт, тэлэлт дээр бид Хүннү хот дээр дэд бүтцийн хэд хэдэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд хийгдээд явж байна. Салбар шугамууд үндсэндээ магистрал шугамууд тавигдсан. Сая цэвэрлэх байгууламжийнх нь тендер зарлагдаад одоо сонгон шалгаруулалт хийгдэж байгаа. Дулаан хангамж дээр бид анх удаагаа газрын гүний дулаан буюу гео терма гээд бүүр 3 мянган метрээс гүний өрөмдлөгийг Азийн хөгжлийн банктэй хамтарч хийхээр урьдчилсан ТЭЗҮ хийгдсэн, эцсийн ТЭЗҮ боловсруулах шатдаа явж байна. Сэлбэ төв дээр мөн өрөмдлөгтэй ТЭЗҮ хийх, өрөмдлөгтэй ТЭЗҮ хайгуул хийх ажил энэ 9 дүгээр сард эхлэх бэлтгэл ажлуудаа хангаад ажиллаж байна. Ер нь бид 20 40-д заасан тэр концепцынхоо дагуу Улаанбаатар хотыг өмнө тал руугаа тэлэх, баруун тал руугаа тэлэх, зүүн тал руугаа тэлэх энэ тэлэлтийн тийм төлөвлөлтүүдийг хийсэн. Одоогийн суурьшил нягтрал газрууд дээр тэлэлт хийхгүй байхаар төлөвлөж байгаа.

Автомашин хувьд би зүгээр нэг статистик хэлэхэд 1976 онд Улаанбаатар хотын хөгжлийн 3 дугаар ерөнхий төлөвлөгөөг батлагдахад одоогийн замын мастер зураг зурагдсан юм. Энэ мастер зургаар 84 мянган машин зорчихоор зурагдсан. Өнөөдөр 804 мянган машин явж байгаа учраас өнөөдөр үнэхээр замын ачаалал дийлэхгүй байгаа учраас бид экспресс замуудыг энэ жилдээ эхлүүлэхээр ингээд төлөвлөөд явж байна. Жолооны хариуцлагыг нэмэгдүүлсэн зохицуулалтыг оруулж ирж байгаа. Тухайлбал энэ өргөн барьсан хуулийн төслийн Замын хөдөлгөөний

аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйл 14.6-д сургалт явуулах стандартын шаардлага хангаагүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нямбаатар даргын микрофоныг нэмж өгье.

Х.Нямбаатар: Энэ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Яг саяын өөрийн чинь хөндсөн асуудлыг. Сургалт явуулах стандартын шаардлага хангаагүй, эсхүл сургалтыг хангалтгүй зохион байгуулсан нь жолооч бэлтгэх сургалтын байгууллагын үйл ажиллагааг зогсоох үндэслэл болно гээд энэ хяналтаа одоо тавихгүй бол энэ дээр тавьдаг хяналтгүй болчихоод жолооч бэлтгэх үйл ажиллагаа ерөөсөө ингээд ар араасаа төгсөлтүүд хийгдээд ингээд явж байгаа гэдэг нэг зүйл байгаа.

2 дугаарт одоо бидэнд бас нэг байгаа тулгамдаад байгаа асуудал бол автомашины техникийн үзлэг оношилгоо. Өнөөдөр энэний тал хэсгийг нь Зам тээврийн яамны дэргэдэх Авто тээврийн үндэсний төв хариуцаж байгаа, талыг нь аж ахуйн нэгж байгууллагууд хэрэгжүүлж байгаа юм. Зүгээр зарим хүндрэлтэй юмнууд байгаа 100 мянган төгрөгөөр үүдэнд нь нүүрсэн яндан түр сольж үзлэгт оруулдаг хүртэл ийм үйлчилгээнүүд явж байгаа. Энэ жилээс арга ядаад нөгөө нүүрсэн яндан дээр нь улсын дугаарын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар, Даваагийн Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Да.Цогтбаатар: Одоо хэрэгжээд байгаа тэр төмөр зам орчмын орон сууцууд чинь яг л нүдэн дээр 3 давхар байшинг буулгаад л 20 давхар бариад байгаа учраас л танаас асуусан юм. Одоо тэр хэрэгжээд байгаа тэр нөгөө зөвшөөрөл олгоод байгаа нөхцөл байдал энэ тэрээ нэг хязгаарлахгүй бол бүр машин байтугай, явган хүн ч түгжрэх хэмжээний асуудлууд үүсэх гээд байгаа. Тэрийг та анзаарахгүй бол хууль хүлээгээд эсвэл Засгийн газрын гаргах шийдвэрийг хүлээгээд байгаад байна гэвэл нийслэл түгжрээд л байгаад байх гээд байна.

2 дугаарт тэр жолоочийн хариуцлагын асуудал. Жолооч нартаа ямар хариуцлага хүлээлгэх юм бэ? Тэрэн дээр та хариулж амжсангүй дуусчихлаа. Тэгээд тэр нөгөө нэг танай нам л засаг бариад л 8 жил болчихсон, нийслэлийг удирдаад сүүлийн хэдэн жил явчхаж байгаа. Энэ дээр хариуцлагын асуудлыг одоо та ярьж эхэлнэ гэвэл нэг жоохон эмгэнэлтэй дүр зураг. Та Хууль зүйн сайд хүртэл байсан хүн. Одоо байгаа хүмүүст нь хариуцлагыг нь шууд хүлээлгэх санал та гаргаад явахад хангалттай хэмжээний бярттай байгаа гэж л таныг ойлгоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр та шууд хариуцлагынх нь механизмыг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга нэмж хариулъя.

Х.Нямбаатар: Би түрүүн дахиад хэлсэн. Олон улсын билетийн кассын хажуу талын 3 давхар байшин дээр иргэд нь, оролцогчид нь удаа дараа шүүхдсэний эцэст өмнөх Засаг дарга нарын үед олгогдсон тэр 3 давхар барилгыг нурааж, дахиж барих зөвшөөрөл явж байгаа. Би ирснээсээ хойш нэмж тийм нягтаршил ихтэй байдлаар ашиглалтын шаардлага хангахгүй газар нэмэлт барилгын зөвшөөрөл өгөөгүй байгаа гэдгийг хэлье. Өмнөхүүд нь дандаа шүүхийн шийдвэрээр явж байгаа.

2 дугаарт би нэг статистик хэлье. Өнөөдөр Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд дунджаар 580 мянган машин өдөрт дунджаар орж байгаа. 5 сараас өмнө 600 гаруй машин, 5 сарын 15-наас хойш 520, 30 ингээд дундажлахад 580 мянган машин орж байгаа. Долоо хоногт 3 төрлийн зөрчил дээр манай жолоочид 5 сая зөрчил үйлдэж байгаа. Нийтдээ 15 төрлийн зөрчлийг бид хиймэл оюун ухаанд код бичиж оруулахаар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нямбаатар даргад нэмж минут өгье.

Х.Нямбаатар: Долоо хоногт дунджаар гуравхан төрлийн зөрчил дээр 5 сая зөрчлийг манай жолоочид үйлдэж байгаа. Бид Замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу 15 төрлийн зөрчлийг бүгдийг нь код бичиж оруулаад ингээд зөрчлийг тоолбол 7 хоногт 10 хэдэн сая зөрчил үйлдэх гээд байгаа юм. Тэгэхээр энэ нь юуг хараад байна вэ гэхээр Улаанбаатар хотод өнөөдөр дүрэмгүй ийм хотын хэлбэр лүүгээ явж байгаа учраас бид хиймэл оюун ухаан бүхий камерын нэгдсэн системээр жолоочид хариуцлага тооцдог болъё. Энийгээ ирэх оны 1 сарын 1-нээс хэрэгжүүлъя. Энэ болтол туршилтаар сануулах мессежнүүдийг явуулъя. Энэ тохиолдолд замын хөдөлгөөний түгжрэл 20-оос 30 хувь буурна гэдэг ийм статистик тооцоо гарч байгаа. Өөрөөр хэлбэл бүгд дүрмээрээ явдаг болсон тохиолдолд замын хөдөлгөөний хурд сайжирна, зөрчил багасна, эрчим нэмэгдэнэ гэдэг ийм статистиктай. Тэр утгаараа энэ нэмэлт, өөрчлөлтийг энэ удаа оруулж ирж байгаа.

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Нийслэл Улаанбаатар хот 2020 оноос хойш л дэргэдээ их тийм судалгааны институтүүдтэй болсон. Өмнө байсан судалгааны институтүүд нь хотын ер нь зүгээр нийгэм, эдийн засаг, соёлын бүхий л харилцааг нарийн судалж, энэнтэй уялдсан байдлаар шийдвэрийн хувилбарууд гаргадаг болсон. Яг хот төлөвлөлт бол харьцангуй шинжлэх ухааны үндэстэй суурьтай болсон гэдгийг энэ ялдамд хэлмээр байна. Энийг Монгол Ардын нам сонгуулийнхаа 2020 оны нийслэлийн болон үндэсний хэмжээний сонгуульд зорилт болгож байсан.

Мэдээж сорилт байсан. Сорилтыг та бүхэн мэдэж байгаа. Хүн амын жишээ нь дотоод шилжих хөдөлгөөний улмаас Улаанбаатар хотын хүн амын тоо бидний хүсэн хүлээж байснаас, эсвэл бидний төсөөлж байснаас даруй хэд дахин нэмэгдсэн. Тэрийгээ дагаад жишээ нь нийслэл хотын төлөвлөлт алдагдсан, тэрийг дагаад энэ асуудал гарсан. Тэгэхлээр би энэ хуулийн төслийг бид шуурхай хэлэлцэж, шийдэх ёстой гэж ойлгож байгаа юм. Хот өөрөө практик шийдэл шаарддаг, прагматик жишээ нь ажил хэрэг шаарддаг ийм нийгэм, эдийн засгийн бүх л ийм бүрэлдэхүүн, зохион байгуулалт. Улсын Их Хурал дээрээс энэ хуулийг яаралтай бид хэлэлцээд, шуурхай шийдэж өгөөд, бүтээн байгуулалтын энэ улирал эхэлсэн үед нь дэмжээд явах нь зүйтэй гэсэн ийм саналтай байна.

Сая Нямбаатар дарга маш тодорхой зүйл хэлж байна шүү дээ. Социализмын үед 84 мянган авто тээврийн хэрэгсэл явахаар жишээ нь зохион байгуулагдсан авто замын сүлжээн дээр бид өнөөдөр 800 мянга хүртэлх авто замыг багтаах гэж ядаж байгаа энэ нөхцөлтэй уялдсан байдлаар бүтээн байгуулалтууд, төлөвлөлтүүд

хийгдэж байгаа гэдгийг хэлж байна. Хууль дээр маш шинэ, шинэ гэдэг юм уу, бидний хувьд одоо хэрэглэж эхэлсэн боловч зарим нэг сорилт гараад, илүү сайжруулаад явж байгаа нэг хэлбэр байна. Энэ газар төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбоотой. Энэ нь юу гэхлээр зэрэг газар чөлөөлөлтийн сан байгуулаад түүгээрээ дамжуулаад саяын хэлсэн орон сууц барихтай холбоотой, нэг талаар жишээ нь газар чөлөөлөх, цаашлаад дэд бүтцийн асуудлыг цогц байдлаар шийддэг олон улсад туршигдсан, бид бас тодорхой түвшинд туршаад зарим нэг сорилтыг даваад, боловсронгуй болгож байгаа энэ ажлыг оруулж ирж байгаа учраас энийг бид шуурхай шийдэх ёстой.

Орон сууцын төлөвлөлт зөв байж саяын хэлсэн төвлөрлийн асуудлыг, түгжрэлийн асуудлыг шийдэх учраас энэ өөрөө чухал болж байна гэдгийг энд онцлон тэмдэглэж байна. Энэ дээр та бүхэн жишээ нь авто замын зохион байгуулалттай холбоотойгоор энэ авто замын зөрчлийн зохион байгуулалттай холбоотой хиймэл оюун ухаан ашигласан, энэний цаана захиргааны жишээ нь хүнд суртал, захиргааны үйл явцыг хялбаршуулах, цаашлаад зөрчлийг дор нь тогтоож, энэтэй уялдсан соёл тогтоох шинэ зүйл гарч ирж байгаа юм. Тэгэхлээр энийг бид цааш нь дэмжих ёстой гэж ойлгож байна. Өөрөөр хэлбэл энэ хууль цаг үетэйгээ уялдсан өөрчлөлтийг бидэнд шаардаж байгаа бол тэрийг өөрчлөлтийг хийх боломжийг олгооч гэсэн хүсэлт байна гэж үзэж байна.

Усны тухай хууль өөрөө тийм практик асуудал. Ер нь ихэнх хотууд, дэлхийн ихэнх хотууд тодорхой гол дагаж байгуулагддаг. Хүн төрөлхтөн энэ иргэншлийнхээ 10 мянган жилд анхны суурин байгуулахдаа л ерөөсөө гол дагуулаад байгуулдаг байсан. Манай хот ч гэсэн Туул голын хөвөөнд байгуулагдсан ийм хот. Одоо энэ байгаа хуулиар Туул голын хөвөөнд байгаа зарим газруудад бид дэд бүтцийн байгууламж барихад энэ хязгаарлалттай байгаа юм. Тэгэхээр энийг жишээ нь даван туулах хуулийн гаргалгаа хийж өгч байгаа. Гэхдээ энэ хуулийн дагуу хийгдэж байгаа. Дагаад энэний цаана үл хөдлөхийн газрын бусад жишээ нь аж ахуйн нэгжийн бизнесийн нөхцөлүүд бүрддэг учраас энийг бид дэмжих ёстой гэж үзэж байна. Энэ мэтчилэн маш олон жишээ нь заалтууд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой нийтийн тээврээр зорчих эрхийг нь хангасан зохицуулалтууд орж ирж байна. Энэ өөрөө их чухал. Манай парламент чинь хүний эрхийг дээдэлсэн шийдвэр гаргана гэдэг бид асуудал ярьж байгаа бол энэ асуудал руу чиглэсэн хуулийн шийдлүүд орж ирж байна. Тэгэхээр эрхэм Улсын Их Хурлын гишүүд та бүхэн энэхүү хуулийг дэмжиж, шуурхай баталж өгөхийг би уриалж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга хариулт өгье, 4 дүгээр индэр.

Х.Нямбаатар: Сая гишүүн үг хэлчихсэн. Би тэр усны юун дээр тодотгоод хэлчихье. Зулпхар гишүүн их чухал асуудал хөндөж байгаа. Бид ер нь энэ Усны тухай хуулийн 22 дугаар зүйл дээр бид тодотгол хийхгүй бол гол дамжиж, гол дээгүүр гүүрэн байгууламж, инженерийн байгууламж хийхдээ бид хуулийн зохицуулалтгүй явж ирсэн юм байна. Тийм учраас бид Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтад голын голдирлын бүсэд гэсний дараа нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих нийтийн инженерийн дэд бүтэц, барилга, байгууламжаас бусад зүйл барихыг хориглоно гэсэн ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа. Энэ зохицуулалт бидэнд их ус, агаар мэт хэрэгтэй байгаа. Учир юу вэ гэвэл бид Туулын хурдны замын бүтээн байгуулалтын ажлыг энэ 7 сард эхлүүлж байгаа, 9 сар гэхэд бид тойрог замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр байгаа. Аль, аль нь голын тэр сав дагуу инженерийн барилга байгууламж, гүүр, хийцлэл хийх

ийм шаардлагатай байгаа учраас хийх бүтээн байгуулалтын ажлаа хуультай нийцүүлж гэдэг ийм өөрчлөлтийг оруулж ирж байгаа гэдгийг хэлж.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Энэ хуулийг дэмжиж байгаа. 3-хан асуулт байна Нямбаатар дарга. 1 дүгээрт энэ нөгөө гэр хорооллыг орон сууцжуулах гэж байгаа юм. Тэгээд дээр нь нөгөө ашиглалтын шаардлага хангахгүй байгаа орон сууцнуудыг дахин төлөвлөнө гэж байгаа юм. Түүн дээр энэ огт бизнесийн хувьд ашиггүй байршилд байгаа тийм барилгуудыг ер нь яах вэ? Жишээ нь Био комбинатад байгаа, тэгээд тэрийг нураагаад ороод байшин барь гэхлээр хэн ч сонирхохгүй. Тэгээд иргэд нь маш хүнд байдалтай байдаг. Энэ иймэрхүү төслүүдийг ер нь яаж шийдэх вэ? Тэрнээс бизнесийн байгууллага орохгүй юм байна лээ.

2 дугаарт нь та бид 2 Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд Жигүүр Гранд гэдэг компанитай уулзаад тохироод газраа буцааж өгөөд, оронд нь нийслэлээс газар аваад тэгээд сургууль эхлэхээр болсон. Тэгээд сургуулийн барилгын гүйцэтгэгч нь сонгогдчихсон байж байгаа. Гэтэл өнөөдрийг болтол нөгөө муу Жигүүр Гранд компани чинь газраа чөлөөлж өгөхгүй байна. Сургуулийн барилгаа эхэлмээр байна. Энэ дээр ямар арга хэмжээ хэдүүлээ авах вэ гэж?

3-д нь Бат-Амгалан гишүүнд ирсэн ийм нэг юу байгаа юм. Энгийг би дамжуулахгүй болохгүй байна. Баянзүрх 26 дугаар хорооны True L хотхоны яг урд зөвшөөрөлгүй маш том барилгыг стандартын бус барилгыг эхлүүлсэн байна гэсэн ийм шаардлагыг иргэдээс мессежээр ирүүлсэн байна. Энэ дээр онцгой анхаарч өгөөч гэж. Ийм 3 асуултыг эхний ээлжид асуучихъя.

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга хариулт өгье.

Х.Нямбаатар: Одоо яг Улаанбаатар хотод хамгийн том асуудал болоод байгаа зүйл бол энэ ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцад амьдарч байгаа болон орон сууцаа төслийн компанитай гэрээ байгуулсны үндсэн дээр нураасан ийм асуудлууд үүсээд байгаа. Тухайлбал Баянзүрх дээр ICTC гээд 200, 201 дүгээр байрыг нураагаад, шинээр барилга барина гээд айлуудыг нь ингээд орох оронгүй болгочихсон. Тэгээд каркас цутгагдсан, өөр цаашаа хийсэн ажилгүй, аудит оруулахаар 35 айлын л мөнгө орсон, үлдсэн нь ороогүй байна гэдэг дүгнэлт гаргадаг. Өөрсдөө болохоор бүх айлаас захиалга авчихсан гэдэг. Ингээд эрүүгийн журмаар уг асуудлыг шалгуулж байгаа. Гэсэн хэдий цаана нь иргэд хохироод байгаа энэ тохиолдлуудад бид гэр хорооллын энэ газар чөлөөлөлтийн сангаас яг ийм төслүүдийг бид гүйцээн дуусгаж, тухайн айлуудыг хохиролгүй болгох, нөгөө талдаа энэ сан өөрөө гаргасан мөнгөө эргэн олж авах ийм нөхцөл тохироотойгоор бид энэ санг ашиглана гэж үзэж байгаа цөөн тохиолдолд. Ихэвчлэн газар чөлөөлөлт рүүгээ энэ сан явагдана гэж хэлнэ.

Био Комбинат болон нэлээн алслагдсан Шувуун фабрик энэ тэрд байгаа ашиглалтын шаардлага хангахгүй газрууд дээр бид аж ахуйн нэгж байгууллагууд дээр бизнесийн бусад идэвх сонирхлыг нь төрүүлэх, худалдаа үйлчилгээний төв барих ийм газрыг нэмж олгох байдлаар төслийг эдийн засгийн үр өгөөжтэй болгох талаасаа бид илүү менежмент хийж ажиллах ийм төлөвлөгөөтэй байгаа. Гэхдээ эхний ээлжид бид өнөөдөр ингээд яг нураагдчихсан байгаа, айлууд нь өөрсдөө орох оронгүй болчихоод байгаа энэ төсөл, хөтөлбөрүүдийг Улаанбаатар орон

сууцжуулалтын корпорац арилжааны банкнаас тодорхой нөхцөлтэй, хүүтэй зээл авах замаар барилгуудыг гүйцээн боловсруулах, гүйцээн барих ажлуудыг хийгдээд явж байгаа. Энэ цаашид энэ сантай уялдаж ажиллана гэдгийг хэлье.

Жигүүр Грандад албан шаардлага өгсөн. Бид нэгэнт 2 талаасаа хэлцэл хийгдээд, хэлцэл хүчин төгөлдөр болсон учраас шаардлагатай гэж үзвэл бид албадан чөлөөлж, сургуулийн барилгыг эхлүүлнэ.

Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд тэр баригдаж байгаа барилгын талаар мэдээлэл ирсэн. Хотын стандартын газар болон Хотын хяналт шалгалтын газрыг бид газар дээр нь очиж шалгалт хийлгэ гээд явуулсан. Энэ дээр та бид 2 нэг зүйл ярьж байгаа бол зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй 2 барилгын асуудал яригдаж байгаа. Энийг бид тухай бүрд нь эргээд бичгээр мэдэгдье.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууя.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Бид Улаанбаатар хот, энэ хотуудын хөгжлийн төлөө бүгдээрээ ингээд санаа сэтгэлээ чилээж явдаг хүмүүс. Хэдхэн хоногийн өмнө Хууль тогтоомжийн тухай хуулийг баталсан. Улсын Их Хурлаар хэлэлцүүлэгдэж байгаа хуулиуд бол хүний эрх, хувийн өмчийн асуудалд маш болгоомжтой байх, хуулийг хэлэлцүүлэхдээ иргэд, олон нийтээс ингээд санал авна гэж байгаа. Энэ хууль дээр би зарчмын нэг 4 асуудал дээр саналын зөрүүтэй байгаа юм Нямбаатар дарга.

1 дүгээрт энэ яаралтай горимоор оруулж ирсэн. Энэ хуулийн цаана газрын эзэн, өмчийн эзэн, үл хөдлөхийн эзэн гээд өмч хариуцаж байгаа хүмүүсийн өмчийг өмчийн эзэнтэй тохиролцохгүй бол яах вэ гэдэг Үндсэн хуулийн зүйл, заалтыг зөрчиж байгаа юм. Энэ асуудал. Тэгээд ингээд хүний өмчтэй холбоотой, хувийн өмчтэй холбоотой асуудлыг яагаад ингээд яаралтай горимоор өргөн барьж байгаа юм бол? Энийг хэлэлцүүлээд, энэ шийдвэрийн үр дүнд оролцох хүмүүсээс яагаад асууж тодруулаагүй юм бэ гэдгийг 1 дүгээрт асуумаар байна?

2 дугаарт нь нэг сан байгуулах юм байна. Сангийн орлого яаж бүрдэх вэ гэхээр Улаанбаатар хот барилга, орон сууц бариад борлуулах юм байна. Дахиад хувийн хэвшлийн асуудлыг хөндөж байна. Орон сууцын менежментийг, орон сууц барихыг Улаанбаатар хотод, Монгол Улсад хувийн хэвшлүүд хийх боломж байна. Тэр боломжийг нь бид гаргаж өгөх байтал ингээд дахин төлөвлөлт нэрийн дор хот өөрөө орон сууц барих гээд байгаа юм уу гэдэг ийм асуудал байна.

3 дахь асуудал нийтийн тээврийг дэмжих сангийн хүрээнд татвар төлөгчдийн мөнгөөр яагаад таксинд дэмжлэг үзүүлэх гээд байгаа юм бэ? Хот өөрөө таксины стандартаа гаргаад, банкнууд магадгүй ногоон green тийм цахилгаан такси оруулж ирж байгаа бол татварын хөнгөлөлт энэ тэр үзүүлэх замаар л дэлхийн хотууд таксины менежментийг хийдэг болохоос биш шууд ингээд татвар төлөгчдийн мөнгөөр ингээд такси компаниудад мөнгө өгнө гэдэг чинь өөрөө эргээд олон асуудал дагуулах юм биш үү? Энэ дээрээ ямар байр суурьтай байгаа юм бэ?

4 дэх асуулт энэ өмчийн эзэнтэй өмчийг тохиролцохгүй бол шууд ингээд яаралтай горимоор өмчийг нь чөлөөлүүлэх ийм асуудлыг яриад байгаа юм байна. Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэдээс санал, гомдол ирж байна. Та энэ амралтын өдрүүдэд энэ хүмүүстэй уулзаж, ярилцах боломж байгаа юм уу? Тийм

учраас энэ хуулийг би яаралтай горимоор хэлэлцэхийг дэмжихгүй байгаа гэдгийг албан ёсоор хэлээд, асуултдаа хариулт авъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга хариулт өгье, 4 дүгээр индэр.

Х.Нямбаатар: Баатархүү гишүүн энэ дээр ер нь танд өргөн барьсан энэ хуулийн төсөл дээр ямар нэгэн тийм албадан чөлөөлөх, хүний өмчийн эрхэд халдах тухай огт зохицуулалт ерөөсөө байхгүй байгаа. Өөрөөр хэлбэл бид гэр хорооллын энэ газар чөлөөлөлт дээр аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй харилцан зөвшилцөж, үнэлгээ оруулах зөвшөөрөл өгсөн тохиолдолд үнэлгээ оруулж, үнэлгээг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд иргэний эрх зүйн хэлцэл хийж, уг газар байршлыг чөлөөлж байгаа. Таны сонгогдож байсан Чингэлтэй дүүрэг болон Сүхбаатар дүүргээс одоогийн байдлаар хэн нэг хүний газрыг хотоос албадан чөлөөлж, буулгаж, нураасан гэсэн нэг ч гомдол санал тан дээр ирээгүй байх. Тийм учраас энэ өргөн барьж байгаа төсөлтэй энэ асуудал ерөөсөө огт уялдаагүй гэдгийг 1 дүгээрт хэлье.

2 дугаарт хот барилга барих тухай ойлголт байхгүй. Өөрөөр хэлбэл бид газраа чөлөөлж өгөөд, инженерийн шугам сүлжээгээ татаж өгөөд, тэгээд барилгын компанид Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр уг төслийг хэрэгжүүлэх эрхийг олгоно. Барилга барьсан компани баригдсан барилгаасаа тодорхой хувийг буюу 10-аас 15, 20 хувийг эргүүлээд газрын төлбөр болон инженерийн шугам сүлжээ тавьсных нь төлөө буцааж өгнө. Тэр нь эргээд сандаа төвлөрнө. Санд төвлөрөхөөр дараагийн байршлыг бид дахиж чөлөөлөөд, дараагийн хувийн секторт газар олгох ийм асуудлаар явж байгаа юм.

2 дугаарт таксины үйлчилгээ гэж Улаанбаатар хотод ерөөсөө огт яг албан ёсны таксины үйлчилгээ үндсэндээ уначихсан. 1990-ээд оны сүүл үеэр шар таксинууд орж ирээд, тухайн шар таксинууд тухайн үедээ арилжааны банкнуудын зээл болон бусад санхүүжилтийн эх үүсвэрээр шийдэгдсэн боловч эргэн төлөлт нь хийгдээгүй гэдэг асуудлууд одоо болтол байдаг юм байна лээ. Тийм учраас бид такси дээр тодорхой стандартыг тогтоосон. Тэр утгаараа ногоон, тэгээд байгаль орчинд ээлтэй энэ төслийг хэрэгжүүлэх ийм нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий компаниудын дунд бид нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, тодорхой хөнгөлөлттэй зээлээр уг таксины үйлчилгээг нийтийн хүртээл болгоё, эргээд эргэн төлөлт нь нийтийн тээврийг хөгжүүлэх сандаа төвлөрч явах ийм зохицуулалтаар бид явахаар ингэж төлөвлөсөн байгаа гэдгийг хэлье.

Эцэст нь хэлэхэд Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүргийн одоогийн чөлөөлөгдөөд байгаа 2 мянга гаруй иргэн, аж ахуйн нэгжийн газраас гадна одоо чөлөөлөгдөөгүй байгаа 198 аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөлтэй бид уулзалтууд хийсэн. Бид заавал газрыг чинь чөлөөлөх шаардлагагүй. Бидний төлөвлөлтөд нийцүүлээд орон сууц, үйлчилгээний төвөө барь гэдэг ийм саналуудыг тавьсан. Ирсэн, уулзалтад оролцсон аж ахуйн нэгжүүдийн 50 хувь нь дэмжсэн. Зарим газартаа бид байршлыг нь сольж, хэмжээг нь нэмж өгөх байдлаар энэ Сэлбэ хотын бүтээн байгуулалтын ажлыг хэсэгчилсэн ерөнхий.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн тодруулж асууя.

Ц.Баатархүү: Дөнгөж өнөөдөр Чингэлтэй дүүргийн яг энэ дахин төлөвлөлтийн тойрогт хамрагдаж байгаа өрхүүдийн төлөөлөл бол уулзсан. Энэ хууль анхнаасаа батлагдахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийг зөрчөөд яаралтай горимоор баталчихсан юм байна лээ. 10 айлын 3, 4 айл нь үнэ тохирохгүй бол шууд чөлөөлөөд явах ийм хууль, эрх зүйн боломжийг олгочихсон. Одоо энэ дээрээ ингээд нэг сан байгуулж байна. Тэгээд татвар төлөгчдийн мөнгөөр такси үйлчилгээг дэмжинэ гээд байгаа. Эргээд энэ нэг эдийн засгийн хувьд нэг хувийн хэвшлийг ингээд төр бүх юмыг нь ингээд чиглүүлэх гэсэн арга барилын хувьд арай буруу юм биш үү гэж би бодоод байна л даа. Тэгээд энэ асуудлыг ингээд нэлээн сайн хэлэлцэж байгаад ярьсан нь зөв гэж бодож байгаа. Тийм учраас би энэ асуудлыг дэмжихгүй гэдгээ хэлье.

2 дугаарт зөвхөн тэр үл хөдлөхийг үнэлээд байна. Тэнд жишээлбэл авто засвар ажиллуулж байгаа хүн бол жил.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга хариулт өгье, 4 дүгээр индэр.

Х.Нямбаатар: Баатархүү гишүүн бид тухайн нэгж талбарын хөрөнгийг үнэлэхдээ Азийн хөгжлийн банкны барьдаг жишиг тэр журмын дагуу хөрөнгийг бүрэн орлуулах үнэлэх аргаар үнэлж байгаа гэдгийг танд хэлье. Дунджаар 300м² газартай 6х4-ийн харьцаатай байшинтай айлын газрыг 170-аас 180 сая төгрөгөөр үнэлж авч байгаа. Өөрөөр хэлбэл тан дээр болон бусад Их Хурлын өргөдөл, гомдлын албанд манай газрыг хотын захиргаанаас хүчээр албадаж буулгасан, нураасан, чөлөөлсөн гэсэн нэг ч гомдол энэ жил гаруйн хугацаанд ирээгүй. Тийм учраас дандаа бид хэлцэл хийх аргаар уг асуудалд хандаж байгаа гэдгийг хэлье. Дээр нь аж ахуй, айл өрхүүд тэндээ амины орон сууц хэлбэрээр амьдрах сонирхолтой тохиолдолд бид байршлыг нь сольж байгаа газрынх нь хэмжээг нэмэгдүүлж олгож байгаа гэдгийг хэлье. Дээр нь хувийн секторуудыг бид зарим.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Энэ Сэлбэ дэд төв гээд дараа дараагийн төслүүд нь энэ төслийнхөө үр дүнгээс хамаараад шууд үргэлжлээд явна гэж ойлгож байгаа. Зарчмын хувьд яах вэ энийг дэмжиж байгаа. Гэхдээ өмнөх алдаа буюу энэ Зуун айл, Баянзүрх дүүргийн дахин төлөвлөлт шиг нэг ийм цементэн ширэнгүүд арай босчихгүй болов уу гэж би бодож байгаа. Хот энэ төлөвлөлтдөө нарийн хяналт тавьж, хувийн хэвшил болон юутай ярихгүй бол эргээд ийм, ийм алдаа давтагдах магадлал үүсэх арга бол байхгүй гэдгийг хэлмээр байна. Мөн боловсролын үйлчилгээг дагаж энэ замын хөдөлгөөний түгжрэл яг үнэндээ дагаж байна. Тийм учраас энэ ялангуяа энэ зах хорооллууд руу дахин төлөвлөлттэй газарт сургуулийг нь барьж өгөөд, сургуулийг нь илүү чанартай хүн болгон магадгүй тэр хавийнхан бүгдээрээ тэнд хүүхдээ өгөхийг хүсдэг гэдэг энэ зүйлийг хот өөрөө давхар анхаарал хандуулж, нийслэл, дүүргүүд өөрөө энэ боловсон хүчнийхээ тогтвор суурьшил, суурьшил, чанар хүртээмж дээрээ анхаарах, энэ асуудлыг цаашдаа энэ замын түгжрэлийг шууд боловсролтой яаж холбогддог юм гэдэг байдлаар ойлгож хийвэл энэ их амжилттай болно. Хүүхдийн хичээл амрангуут үндсэндээ замын түгжрэл маш хурдан буурчхаж байгаа энэ бол энэнтэй холбоотой гэдгийг хэлмээр байна.

Тэр хувийн хэвшлийг оролцуулаад явах нь маш зөв. Сая Нямбаатар дарга хэллээ, би бас энийг асуух гээд байсан сая хариултаа ингээд авчихлаа. Дээрээс нь

нэг зүйл ингээд туршлага гэж аваад үзэхэд манайд шөнө ашиглагддаггүй том, том зах, худалдааны төвүүд, оффисууд сул зогсоолуудаа хаагаад, хаагаад явчихдаг, хажуу талынх нь орон сууцууд нь шөнө нөгөө машин нь багтдаггүй, шөнөжин тойрдог, эсхүл замуудаа хаагаад тавьдаг гэдэг дээр хот зохицуулалт хийгээд, зогсоолыг шөнийн хугацаанд гэдэг юм уу, оройн 20 цагаас өглөөний 7 цаг хүртэл тодорхой тэр төлбөр юмыг нь хөнгөлөлттэй share-лэх энэ хууль эрх зүйн болон зохицуулалтыг нь хийх боломж бололцоо байгаа юу гэдгийг хэлмээр байна.

Такси бол үнэн. Манай Улаанбаатар хот шиг яг ингээд нэгдсэн ийм тодорхой, ойлгомжтой ийм таксины үйлчилгээ байдаггүй ийм хот бараг байхгүй болчихоод байна. Тийм учраас энэ тал дээр яг тэр таксины яг ямар үйлчилгээ яах гээд байж байгааг жоохон тодруулаад өгөөч гэдгийг би хүсмээр байна? Өөрөөр хэлбэл хүн болгонд такси олдохгүй болохоор замын түгжрэл дээр такси бариад зогсоход түгжрэлээр ямар ч такси олдохгүй. Өвлийн хүйтэнд өглөө хүүхдээ хүргэж өгөхөд ямар ч такси олддоггүй. Тэгэнгүүт хүмүүс яаж байна гэхээр машин авахаас өөр аргагүй юм байна гэдэг юм руу л бүгд хошуурч байгаа. Тийм учраас нэг ийм тэвчээрийн цэгийн хугарал дээр л бид энэ таксиныхаа үйлчилгээг аваачиж өгвөл иргэд аяндаа заавал машин барьж түгжрэл, мөн зогсоолыг хайж явахгүй гэдэг ийм юм руугаа ордог юм байна лээ. Тийм учраас энэ тал дээр байнга тэр хувийн компаниудад төсвөөс мөнгө өгөх гээд байгаа гэдэг дээр би яг ямар мөнгө өгөх гээд байгаа юм бэ? Түрүүн Баатархүү гишүүн асуулаа. Тодорхой хэмжээний дэмжлэг хугацаанд хэрэгтэй юм байна лээ. Хятадын энэ том, том хотуудаар ингээд харж байхад маш олон зөвхөн такси үйлчилгээ байдаг, хувиараа машин барьдаг хүн бараг байдаггүй. Тэр нь өөрөө соёлтой. Тэгээд түгжрэлийн үед нь тодорхой хугацаанд тэр метр нь гүйж байдаг энэ тэр гээд зохицуулалт хийж өгөхгүй бол энэ такси руу чинь хүн ашиг хайж байгаа учраас орохгүй. Тийм учраас яг энийг яаж зохицуулах гэж байгаа гэдэг дээр тодруулаад өгөөч гэдгийг хэлмээр байна.

Эцэст нь хэлэхэд маш олон хүнээс санал ирэх юм. Энэ зуслан лагерийн газруудыг ер нь яагаад өмчлөхгүй байгаа юм бэ, эзэмшүүлэхгүй байгаа юм бэ гэдэг ийм саналууд ирээд байгаа юм. Энийг ер нь хэзээ хийх вэ? Магадгүй өмчлөөд шийдээд өгвөл энэ хүмүүс өөрөө тэндээ дахин төлөвлөлтөө хийгээд, заавал Улаанбаатар хот руу 2 гэртэй биш, тэндээ суурьшаад явах, тэндээ өөрөө дэд бүтцээ, бие даасан дэд бүтцүүд рүүгээ хөрөнгө оруулалт хийх ийм хүлээлт байгаад байгаа юм биш байгаа гэдэг дээр асуулт асуумаар байна?

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга хариулт өгье, 4 дүгээр индэр.

Х.Нямбаатар: Бид яг Эрдэнэбат гишүүний ярьж байгаачлан Сэлбэ хотыг дотроо ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролыг олгодог цэцэрлэгийн хүртээмжийг хангалттай байдлаар төлөвлөж байгаа. Дээр нь нэмээд бид холимог орон сууцын хороолол үүсэх үүднээс хөтөлбөртэй сургууль 2-оос 3-ыг гаргая гээд Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байгаа хувийн ерөнхий боловсролын сургуулиудтай хэд хэдэн удаагийн уулзалтууд хийсэн. Зарим сургуулиуд нь бидэнд газрын асуудал, дэд бүтцийг шийдэж өгсөн тохиолдолд бид сургууль барихад бэлэн байна гэдгээ илэрхийлээд байгаа. Ийм учраас бид энэ боловсрол гэдэг зүйл хамгийн чухал учраас Сингапурын хөтөлбөртэй сургууль энэ 13 дугаар хороололд байгаа техникийн шинжлэх ухааны мэдэгдэхүүн олгодог ерөнхий боловсролын сургууль, мөн Их засаг олон улсын их сургууль зэрэг хэд хэдэн хувийн их дунд сургуулиудтай бид эхний уулзалтууд хийсэн. Одоо дараагийн бусад хувийн сургуулиудтай уулзалтууд хийнэ. Бид тодорхой байршлуудыг санал

болгож, хөтөлбөртэй болон ерөнхий боловсролын сургуулиудыг олноор байгуулахаар ингээд төлөвлөж байгаа гэдгийг хэлье.

Такси дээр таны яг хэлж байгаа асуудлыг л бид шийдэх гээд байгаа юм. Өнөөдөр Улаанбаатар хотод яг албан ёсны таксины үйлчилгээтэй, таксины симфортой, такси метртэй ийм үйлчилгээ үзүүлдэг байгууллага бараг байхгүй байгаад байгаа. Тийм учраас бид байгаль орчинд ээлтэй ногоон ийм такси үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж байгууллагуудад нийтийн тээврийг хөгжүүлэх сангаас тодорхой хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлийг олгох замаар нийтэд Улаанбаатар хотод таксины үйлчилгээг жигдрүүлж нэвтрүүлэх гэдэг ийм бодлого барьж, нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн автобус гэсний араас таслал тавиад такси гэдэг өгүүлбэр оруулж, нээлттэй сонгон шалгаруулалтаар тодорхой үйлчилгээг үзүүлэх гэдэг ийм зорилго тавьж ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Сүүлийн асуултыг би Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Бямбацогт дарга, Барилга, хот байгуулалтын сайд Бат-Амгалан сайд 2 хариулах нь зөв байх. Яагаад гэвэл Монгол Улсын газрын харилцааны бодлого Хэрэг эрхлэх газар, Барилга, хот байгуулалтын яам 2 дээр хариуцаж байгаа. Энэ утгаараа тэр Улаанбаатар орчмын ногоон бүсийн газар өмчлөлийн асуудлын талаарх би бодлогыг яг хэлж мэдэхгүй байна гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье, Эрдэнэбат гишүүний асуултад.

С.Бямбацогт: Газартай холбоотой асуудал Ерөнхий сайдын харьяа агентлаг болсон. Тэгээд газрын асуудал өөрөө байгаль орчин хамгаалахтай, уул уурхай олборлохтой, барилга байшин барих, зам харгуй барих, тэгээд л эрчим хүч барих гээд олон асуудлуудын зангилаа байдаг учраас Ерөнхий сайдын харьяанд ирсэн юм байна лээ. Газар олгох, эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх асуудал дээр Засгийн газрын хуралдаанаар шийдвэр гардаг болсон нь иргэдийн хувьд нэлээн тийм хүндрэл учирдаг болсон байгаа. Тэгээд үүнийг ойрын хугацаанд засаж залруулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт газар эзэмшүүлэх, ашиглуулах энэ эрхийг нь олгох тал дээр илүү иргэдэд хүнд сурталгүй, хурдан шуурхай үйлчлэх тал дээр Засгийн газар ойрын үед шийдвэр гаргана.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе. Хуулийн төсөлтэй танилцахад ямар ч байсан нэг газрыг дахин төлөвлөх гэр хорооллын хөгжлийн сан байгуулагдах юм байна. Нөхөн олговрын асуудал бодитойгоор шийдэгдэх тэр үндэслэл тавигдах юм байна гэж ойлгогдож байна. Хажуугаар нь нийтийн тээврийн асуудал дээр автобус болон автобус гэснийг автобус, таксины гэж өөрчлөн, иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн, илүү уян хатан шийдлийг олж байна гэж тайлбарлаж байх шиг байна. Мөн ухаалаг шийдэл бүхий хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын системийг нэвтрүүлнэ, энийг уялдуулан сайжруулна гэсэн ийм агуулга явж байна гэж ойлгож байна.

Тэгэхээр миний хувьд нийслэлийн Төлөөлөгч байсан хүний хувьд яаралтай горимоор орж ирэхийг нь ойлгож байна. Нийслэлийн асуудал нэг үзүүрээс нь татахаар нэг өөр зүйл гараад ирдэг. Газар чөлөөлөх процесс, энэ маш олон зүйлүүд нь цаг аваад байдаг ийм асуудалтай байдаг. Дээрээс нь энэ Улаанбаатар хотоор

дүүрэн түгсэн цахилгааны кабелиуд, дулааны, цэвэр усны, бохирын гээд тэр нь нийслэлд харьяалагддаггүй учраас аливаа ажил зохион байгуулахад цаг алдах тохиолдол байдаг гэж хардаг. Тиймээс нийслэлийн бүтээн байгуулалтыг хөгжүүлбэ гэвэл цаг хэмнэх талыг дэмжих нь зүйтэй байх гэж бодож байна. Гэхдээ сайны хажуугаар саар гэдэг шиг зарим зүйлүүдийг анхаарах ёстой, хэд хэдэн асуулт байна.

1 дүгээрт Санхүүжилтийн ил тод байдал. Сангийн хөрөнгийг бүрдүүлэхдээ, мөн захиран зарцуулахдаа ил тод байдлыг хангаж чадаж байгаа юу? 2 дугаарт гэр хорооллын оршин суугчдын эрхийн асуудал, ялангуяа газар чөлөөлөлтийн нөхөн олговрын механизм, түүний хэмжээ шударга байдал хангагдаж байгаа эсэх дээр та бүхэн маань тооцсон уу?

Нийслэлийн үнэт цаасны зохицуулалтын дагуу энэ үнэт цаасыг хөрөнгө оруулалтын хувьд татан оролцуулахын тулд банкнуудтай хуульд нэмэлт оруулах шаардлагатайг дурдаж байгаа ч тусдаа асуудал байж тус хуулийн төсөлтэй уялдаагүй орхигдсон байж болзошгүй байна гэж дүгнэх байна.

Дараагийн дугаарт энэ гэр хорооллын хөрсний бохирдол, мөн жишээгээр дурдвал энэ Цагаан давааны хогийн цэг ингээд үер болохоор ингээд Улиастайн гол руугаа урсаад ороод ирдэг, өвөл болохоор утаа нь ороод ирдэг, зун болохоор ингээд үерлэхээр хог нь урсаад ороод ирдэг гэх мэтийн асуудлууд байдаг юм. Нэгэнтээ энэ гэр хорооллын асуудал, санхүүжилтийн асуудал яригдвал энэ гэр хорооллын хөрсний бохирдлын асуудлыг энэ сантайгаа уялдуулаад, энэ газар чөлөөлөлтэйгөө уялдуулаад төлөвлөгөөгөө уясан болов уу гэж асуумаар байна? Дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга хариулт өгье.

Х.Нямбаатар: Баярлалаа Пүрэвдаваа гишүүн. Бид энэ яагаад яаралтай горимоор оруулж ирж байгаа вэ гээд сая Баатархүү гишүүн асууж байх шиг байсан. Энэ 7 дугаар сардаа багтаад энэ хууль батлагдсан тохиолдолд бид Туулын хурдны замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх гээд байгаа юм. Усны тухай хууль дээр байгаа тэр голын сав дагуу гүүрэн байгууламж, инженерийн байгууламж барих энэ эрхийг Усны тухай хуулиар бид нээж авахгүй бол манай өмнөх гүүрэн байгууламжууд ерөнхийдөө энэ Усны тухай хуулийнхаа 22 дугаар зүйлийг баримталдаггүй явчихсан ийм зохицуулалтыг бид гажуудлыг нь арилгаж байгаа гэдгийг хэлбэ.

2 дугаарт газрыг ер нь хэрхэн үнэлж авч байгаа юм бэ гээд. Өөрөөр хэлбэл гэр хорооллын иргэдийн өөрсдийнх нь гол өмч болсон энэ газар, хашаа байшин, түүн дотор байгаа байгууламжуудыг бид бүхэлд нь үнэлж, хөрөнгийг бүрэн орлуулан үнэлэх арга буюу Азийн хөгжлийн банкны баримталдаг энэ аргачлалыг баримталж явж байгаа. Өнөөдөр нийслэл Улаанбаатар хотод яг одоогийн байдлаар 71 байршилд газар чөлөөлөлтийн ажил хийгдэж байгаа. Тэгэхээр одоо иргэд үзэл бодлоо илэрхийлэх эрх нь чөлөөтэй болчихсон энэ үед Нийслэлээс газрыг ингээд хүчээр булааж авлаа, тэглээ гэдэг ийм гомдол, санал Их Хурал дээр ямар нэгэн байдлаар ерөөсөө огт гарч байгаагүй. Энэ бол бид цэвэр хэлцлийн үр дүнд явагдаж байгаа гэдгийг хэлбэ.

2 дугаарт үнэт цаасан дээр энэ нөгөө гэр хорооллыг орон сууцжуулах энэ бодлоготой холбоотой үнэт цаасны бодлого өөрөө цуг уялдаж явж байгаа. Өөрөөр

хэлбэл Засгийн газрын үнэт цаастай дотоод нийслэлийн үнэт цаасыг адилтгаж, дотоодын арилжааны банкнуудад худалдаж авах энэ боломжийг л 10 гэдгийг 20 болгож байгаа Засгийн газрын үнэт цаастай адилтгаж хувь тавьж байгаа ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа гэдгийг хэлье.

Хөрсний бохирдлыг мэдээж хэрэг шийдэж байж энэ цаашаа орон сууцжуулах бодлого, байгаль экологийг хамгаалах бодлого явагдана. Зүгээр танд нэмэлт мэдээлэл болгоод хэлэхэд энэ 8 дугаар сарын 1 гэхэд НИТХ Улаанбаатар хотод хамгийн анхны хог шатаах үйлдвэрийн хэлцлийг хийж дуусгаж, эцсийн шийдвэр гаргах ийм хуулийн хугацаатай явж байгаа. Хэлэлцээр үргэлжлээд явж байгаа. Энэ тохиолдолд бид 5 жилээс дотогш хугацаанд булсан landfilled-сэн Цагаан давааны болон Улаан чулуутын хогийн цэгийг хог шатаах үйлдвэрт шатааж, Урбан майнинг гэдэг ойлголтын дагуу энэ байгаль орчныг нөхөн сэргээх ийм ажлуудыг хийхээр бид энэ төсөл дээрээ хамтад дурдаад явж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Ил тод байдлын тухай та хариулсангүй. Хамгийн чухал нь ил тод байдал гэж харж байгаа. Ялангуяа энэ нийслэл Улаанбаатар хот 1,5 сая хүн амтай болчихсон. Жишээгээр энэ парламентын түвшинд хэлэлцэж байгаа асуудлууд d.parliament гэдэг сайтаар ороод жишээгээр 100 мянган иргэний санал төвлөрвөл ажлын хэсэг байгуулагддаг ийм зохицуулалттай байгаа. Нийслэл яг иймэрхүү хэмжээний зохицуулалт хийх боломж байдаггүй юм уу? Ялангуяа энэ гэр хороололтой холбоотой бодлогын хувьд асуудал гарвал наашаа хандаад байхгүйгээр нийслэлийнхээ хурлынхаа дэргэд ийм платформыг бий болгох нь зүйтэй шүү. Энэнд та хиймэл оюун ухаан гээд холбогдож байна. Тэрийгээ ингээд уяад, тэгээд иргэд маань шууд асуудлаа иргэдийн хурал дээрээ шийддэг байдлаар шийдэх боломжтой юу?

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга нэмж хариулт өгье.

Х.Нямбаатар: Яг d.parliament-тай адилхан манайх санал асуулга хэлэлцүүлгийн платформ бэлэн болгосон байгаа. Удахгүй бид олон нийтэд танилцуулна. Улаанбаатар хотын иргэн бүр уг аппликэйшныг татаж авснаар Улаанбаатар хотын бүх төрлийн үйлчилгээг авахаас гадна, Улаанбаатар хотод гарах гэж байгаа шийдвэртэй холбоотой санал, хэлэлцүүлэг зохион байгуулдаг. Түүнээс гадна green score буюу ногоон оноо үнэлгээ авдаг ийм аппликэйшныг удахгүй танилцуулахад бид бэлэн болсон байгаа гэдгийг хэлье. Яг энэ дээрээ энэ ил тод байдлын шаардлагыг хангаж ажиллана.

2 гэвэл таны өмнө нь хэд хэдэн удаа сонгогдсон НИТХ энэ газар чөлөөлөлтийн сангийн нийтлэг журам, түүнд хяналт тавих журмыг батална. Энэ журмынхаа дагуу Удирдах зөвлөлийг олон нийтээс нээлттэй, сонгон шалгаруулалтаар сонгон шалгаруулж, Удирдах зөвлөлийг бүрдүүлэхээр төлөвлөж байгаа гэдгийг нэмж хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан дэмжсэн болон дэмжээгүй байр суурийг илэрхийлж Улсын Их Хурлын гишүүд үг хэлнэ. 2 гишүүн нэр өгсөн байна. Энийгээ болино, горимын

санал. Пүрэвжавын Сайнзориг гишүүн, гишүүд үгээ татаж байна. Сая асуулт дээр үгээ хэлсэн байна. Гишүүд үг хэлж дууслаа. Цогтгэрэл дарга горимын санал.

О.Цогтгэрэл: Гишүүдэд үдээс хойшийн мэндийг хүргэе. Гэр хорооллыг барилгажуулах, утаа түгжрэлийг бууруулах тухай хуулийн өөрчлөлтийн хэлэлцэх эсэх явж байна л даа. Тэгэхээр хэлэлцэх эсэх явж байгаа үед энэ үзэл баримтлалын шинжтэй зөрөөтэй байр сууриуд гарч байна. Жишээ нь энэ хууль дээр барилгажуулах сан байгуулна гэж байгаа юм. Сан юм чинь мэдээж орлоготой, зарлагатай байж таарна. Хуулийн төсөлд бичсэнээр гэр хорооллыг дахин төлөвлөлтийн хүрээнд бий болсон орон сууцыг худалдан борлуулснаас орлого олно. Сангийн орлогыг үндсэндээ нийслэл орон сууц худалдан борлуулж орлого олно. Энэ ингээд нэг ийм бизнесийн харилцаанд яг яаж оролцох гээд байгаа юм. Сангийн зарлага хэсэг нь ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцын барилгыг буулгах, шинээр барихад энэ сангийн мөнгө зарцуулагдана. Барилга нийслэлээс шинээр барина гэдэг нь яг ямар ойлголтууд энэний цаана явж байна вэ?

Тэгэхээр яг өнөөдөр Засгийн газраас шинэ Засгийн газраас тодотгол өргөн барьж байна. Энэ тодотголын үндсэн бодлого, чиглэлийг эдийн засаг дахь, бизнес дэх төрийн оролцоог хэрхэн, яаж бууруулах вэ, зохицуулалтыг хэрхэн, яаж бууруулах вэ, энэ төвлөрсөн удирдлагыг хэрхэн, яаж тараах вэ, төвлөрсөн зохицуулалтыг яаж багасгах вэ гэдэг үзэл баримтлалын өөрчлөлт энд өнөөдөр өргөн барьсан хэдийгээр төсвийн тодотгол ч гэсэн энэ хүрээнд төсвийн бодлого дээр энэ асуудлууд явж байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхээр үзэл баримтлалын түвшинд, Засгийн газраас барьж байгаа бодлогын түвшинд энэ хуулийн энэ зарим өөрчлөлтүүд нийцэхгүй байна гэдэг энэ хүрээнд Ардчилсан намын бүлгийн гишүүдээс, олон гишүүнээс санал гарч байгаа учраас Ардчилсан намын бүлэг энэ хуулийн төслийн өөрчлөлт дээр 3 хоногийн завсарлага авъя. Ирэх долоо хоногийн Даваа гаргийн Бүлгийн хурлаар бид энэ асуудлыг хэлэлцэж, байр сууриа нэгтгэх, хуулийн төсөл санаачлагчдаас нэмэлт мэдээлэл авах ийм шаардлагуудтай байна. Иймээс Ардчилсан намын бүлэгт завсарлага өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: 3 хоногийн завсарлага гэхээр чинь, энийгээ эхлээд яаралтай горимоор хэлэлцэх эсэх асуудлаа санал хураагаад шийдчихвэл яаж байна вэ? Санал хураалтууд байгаад байгаа өнөөдөр хэлэлцэх асуудлуудын. Богино хугацаатай авч болохгүй юу? Гол нь өнөөдрийн энэ бусад хэлэлцэж байгаа хуулиуд чинь нөгөө хэлэлцүүлэг хоорондын хугацаа 5 хоног гэдэг асуудалтай байж байгаа. Тэгэхээр санал хураалт, бусад асуудлынхаа санал хураалтад яах юм бэ, оролцоод явчих юм уу энэнээс завсарлага аваад? Одоо ерөөсөө зөвхөн санал хураалтууд үлдээд байна шүү дээ. Төсвийн хууль маргааш орж ирнэ. Санал хураалтад. Монгол Ардын намын бүлгийн дарга Бат-Эрдэнэд үг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2 цагийн завсарлага хүсэж байна. 2 цаг.

Д.Амарбаясгалан: Өнөөдөр гол нь гишүүд хэлэлцэж байгаа асуудал маань хэлэлцүүлэг хоорондын хугацаа 5 хоногоор хэмжигдэж байгаа. Тэгэхээр бид энэ санал хураалтуудыг өнөөдөртөө хийж дуусгавал 7 дугаар сарын 9-ний өдөр буюу ирэх долоо хоногийн 3 дахь өдөр ажлын өдрүүддээ багтаж асуудлаа шийдээд дуусна. 10-наас эхлээд амралтын өдрүүд тоологдоод эхэлнэ. Тэгэхээр бидэнд энэ хэлэлцэх хугацаатай холбоотой асуудал чухал байна.

2 дугаарт Ардчилсан намын бүлгийн завсарлага авъя гэж байгаа хот байгуулалтын биш ээ, Нийслэлийн түгжрэлийг бууруулах тухай хуулийг яаралтай горимоор хэлэлцүүлж өгөөч гээд Засгийн газраас хүсэлт ирчихсэн байж байгаа учраас 3 хоногийн завсарлага өгөөд байх боломж алга байна. Тэгэхээр 2 цагийн завсарлага Ардын намын бүлэгт өгье. 2 цагийн дараа яг ирцээрээ цуглана, санал хураалт явна. Завсарлага авчхаж байгаа учраас бусад асуудлууд бүгд санал хураалтаар явагдах ёстой. Энэ завсарлагын хугацаа дууссаны дараа санал хураалтаа үргэлжлүүлье./16:57/

Хуралдаан 18 цаг 09 минутаас үргэлжлэв.

Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлага дууссан байна. Гишүүд танхимд орж ирье. Гишүүд танхимд орж ирье. Шууд завсарлага дуусаад, санал хураалтаар Улсын Их Хурлын үйл ажиллагаа үргэлжилж явагдана. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд ирцдээ, санал хураалтдаа бэлтгэе. Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлага дууссан байна. Завсарлагын хугацаа дууссан байна. Монгол Ардын намын бүлгийн дарга Бат-Эрдэнэ гишүүнд үг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын авсан 2 цагийн завсарлага дууссан тул чуулганыг эхлүүлэе гэж.

Д.Амарбаясгалан: Чуулган үргэлжилье гэж байна. Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл дарга завсарлага авах хүсэлт тавьсан байгаа. Энэнтэй холбоотойгоор Цогтгэрэл даргын үгийг өгье.

О.Цогтгэрэл: Саяын нийслэлийн түгжрэл, орон сууцжуулах хуультай холбоотой асуудлаар Ардчилсан намын бүлгээс завсарлага авах хүсэлт тавьсан, тавьсан байсан. Тэгээд сая бас бид Бүлэг дээр ярилцлаа. Завсарлагын хугацаанд. Тэгээд нөхцөл байдлыг харгалзаад, энэ хууль дээр анхаарах олон зүйлүүд байгаа юм. Жишээ нь энэ сан байгуулна, сангаас такси үйлчилгээнд татаас өгөх ийм утга бүхий заалт гэх мэтийн ийм, ийм заалтууд байгаа. Энэ заалтуудыг тэгээд энэ хуулийн дараагийн, хэлэлцүүлгийн дараагийн үе шатууд дээр гэх зэрэг ийм заалтууд дээр бүлгийн гишүүд их эсрэг байр сууриудтай байгаа. Тэгэхдээ хуулийн процесс явагдаад, энийг явцын дунд ажлын хэсэг дээрээ илүү ярилцаад явж болох юм гэдэг байр сууриа нэгтгэсэн. Ийм учраас Ардчилсан намын бүлгийн завсарлага авах хүсэлтийг цуцалж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Тэгвэл намын бүлгүүдийн завсарлагын хугацаа дууссан, авах хүсэлтээ цуцалж байна. Гишүүд санал хураалтад бэлдье, шууд санал хураалт эхэлнэ. Маш олон санал хураалт байгаа. Тэгэхээр гишүүд тогтвортой сууж байгаад, санал хураалтаа түргэн шуурхай явуулах нь зүйтэй байна. Санал хураалтаа эхэлье.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт. Яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60 гишүүн буюу 56,6 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ. Олонх дэмжсэн, Байнгын хороодод шилжүүлнэ.

18.12 цаг

Дараагийн асуудалд оръё. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг эхлүүлнэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байна. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Нийт 25 санал байна. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Нэг.ТББХ-ны дэмжсэн санал.

Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.26 дахь хэсгийн “Хүний эрхийн Үндэсний Комисс,” гэсний дараа “Үндэсний статистикийн хороо,” гэж, мөн заалтын 21.25, 21.30 дахь хэсгийн “мэдээллийг” гэсний дараа “санаатайгаар” гэж, мөн зүйлийн 5 дахь заалт буюу 23.8.1 дэх заалтын “судлах,” гэсний дараа “холбогдох Байнгын хорооны саналыг үндэслэн тухайн асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах, сонсох,” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, Алтаншагай, Сайнзориг, Уянгахишиг Шижир. Цаашид ажлын хэсэг гэх. Шинэ санал хураалт явах гэж байгаа учраас санал хураалтад дахиж бэлдэх юм байна. Гишүүд санал хураалтад бэлдье. Эхний асуудлаар санал хураалт. 75 гишүүн буюу 70,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 21.26 дахь хэсгийн “21.25-д” гэснийг “21.24-д” гэж, мөн заалтын 21.28 дахь хэсгийн “Улсын Их Хуралд” гэснийг, мөн 21.30 дахь хэсгийн “Нэгдсэн хуралдаанд” гэснийг “Улсын Их Хурлын асуулгын цаг, Тусгай хяналтын дэд хорооны сонсгол, Хяналт шалгалтын түр хорооны сонсгол болон Хяналтын сонсголд, эсхүл нэгдсэн хуралдаанаар гишүүний асуулгын хариу, улсын төсөв, төсвийн төсөл, гүйцэтгэлийн хэлэлцэхэд” гэж тус тус, мөн 21.28 дахь хэсгийн “тухайн нам, эвслийн бүлэг, эсхүл 10-аас” гэснийг “нам, эвслийн бүлэг, эсхүл 20-оос” гэж, 21.30 дахь хэсгийн “32.7-д” гэснийг “32.8-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82 гишүүн буюу 77,4 хувиар санал дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 21.24 дэх хэсгийн “Тусгай хяналтын дэд хороо,” гэсний дараа “Хяналтын сонсгол болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82 гишүүн буюу 77,4 хувиар санал дэмжигдлээ.

4.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 22.6.7 дахь заалтын, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 23.7 дахь хэсгийн, мөн зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.3 дахь заалтын “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг “Хүний хөгжил, нийгмийн бодлогын” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 79 гишүүн буюу 73,8 хувиар дэмжигдлээ.

5.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.3 дахь заалтын, мөн зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.14 дэх заалтын “Шинжлэх ухааны” гэснийг “Боловсрол, шинжлэх ухааны” гэж, 27.5.1 дэх заалтын “асуудлаарх” гэснийг

“талаарх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82 гишүүн буюу 76,6 хувиар санал дэмжигдлээ. Саяын саналыг ажлын хэсэг мөн Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин гаргасан санал байна.

Зургаа дахь санал хураалт. Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.7 дахь заалтын “Эдийн засгийн байнгын хороонд” гэсний дараа “Аялал жуулчлалын хөгжлийн,” гэж нэмж, мөн зүйлийн 7 дахь заалтад доор дурдсан агуулгатай 27.5.2 дахь заалт нэмэх:

“27.5.2.Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо нь аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын асуудлыг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 83 гишүүн буюу 77,6 хувиар санал дэмжигдлээ.

7.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.9 дэх заалтын “тагнуулын гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 27.5.11 дэх заалтын “явуулж байгаа” гэсний дараа “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагад харьяалуулснаас бусад” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82 гишүүн буюу 76,6 хувиар санал дэмжигдлээ.

8.Нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82 гишүүн буюу 76,6 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.ТББХ-ны дэмжээгүй санал. 1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 23.11.21, 23.11.22, 23.11.23 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.7 дахь заалтын “Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн,” гэснийг, мөн зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.4 дэх заалтыг, төслийн 6 дугаар зүйлээс “22.6.1,” “23.1” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн. Санал хураалт. Дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёолол. 79 гишүүн буюу 73,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 23.7.1, 23.7.3, 23.7.4, 23.7.6, 23.7.7, 23.7.8, 23.7.11 дэх заалтыг, мөн зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.3 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.6, 27.5.14 дэх заалтыг хасаж, 6 дугаар зүйлийн “22.6.4-22.6.6” гэснийг “22.6.5, 22.6.6” гэж, “23.4-23.6” гэснийг “23.5, 23.6” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Зулпхар, Мөнхтуяа, Энхнасан. Санал хураалт дэмжээгүйг дэмжье. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг өгье.

М.Бадамсүрэн: Энэ заалтыг нэр бүхий 4 Их Хурлын гишүүн буюу Зулпхар, Мөнхтуяа, Энхнасан бид 4-ийн хувьд гаргасан. Боловсрол, шинжлэх ухааны байнгын хороог татан буулгахыг дэмжихгүй байгаа саналаа илэрхийлж энэ саналыг гаргасан. Тэгээд яах вэ ажлын хэсэг дэмжээгүй юм байна, ТББХ дэмжээгүй юм байна. Тэгээд улс орны хувьд иргэдийг ядуурлаас гаргах, хүүхдүүдийг ирээдүйд хамгийн улс эх орондоо хэрэгтэй хүн болгож хөгжүүлэхэд боловсролын салбар хамгийн чухал нэг.

2 дугаарт улс орны эдийн засаг, хөгжил, бусад хүний хөгжил, бүхий л зүйлийн хөгжлийн үндэс бол шинжлэх ухаан. Тэгээд энэ Боловсрол, шинжлэх ухааны

байнгын хороо байгуулсан энэ зорилтоосоо ухарч байгаад туйлын харамсалтай байгаа. Тэгээд Боловсролын яам ажлаа сайн хийгээрэй. Мөн Нийгмийн бодлогын байнгын хороо ингээд боловсролын асуудлыг нэгтгэж байгаа юм байна. Тэгээд ажлаа сайн хийгээрэй. Тэгээд ХҮН намынхандаа амжилт хүсье. Тэгээд энийг л хэлье дээ, тэгээд сайн ажиллаарай.

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүн тэгээд саналаа татаж байгаа юм уу, санал хураалгах юм уу? Санал хураалт. ТББХ-ны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ чинь хуулийн төсөлтэйгөө зөрчилдөөд яваад уналаа шүү дээ. Энэ Болормаа гишүүн сая юу яриад явчлав? Харин тийм. Энхбатын Болормаа гишүүн горимын санал гаргая.

Э.Болормаа: Уучлаарай дарга, сая нөгөө Бадамсүрэн даргын санал дээр будилаан төөрөлдөөд, тэгээд буруу зүйл хэлчихлээ. Тэгээд би сая хүрээгүй байж байгаад миний санал зөвшөөрснөөр биш, буруугаар гарсан байна. Тэгэхээр санал хураалтыг дахин явуулж өгнө үү гэж горимын санал гаргая, хүчингүй болгож өгнө үү гэж.

Д.Амарбаясгалан: Болормаа гишүүний гаргаж байгаа горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. 71 гишүүн буюу 66,4 хувиар санал дэмжигдлээ. Бадамсүрэн нарын гишүүдийн гаргасан саналыг ТББХ-ны дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 74 гишүүн буюу 69,2 хувиар санал дэмжигдлээ. Чимээгүй.

3.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын 27.3.6 дахь заалтын “Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Б.Энхбаяр гишүүнд үг өгье.

Б.Энхбаяр: Гишүүдийнхээ оройн амгаланг айлтгая. Тэгэхээр энэ зарчмын зөрүүтэй саналыг хуралдаан даргалагчаас санал хураалгахгүйгээр гүйцээн боловсруулах чиглэл өгөхийг хүсэж байна. Энэ асуудалтай холбоотойгоор парламентад суудалтай 2 намын бүлэг бас бүлгийн удирдлагуудын түвшинд, мөн хууль санаачлагч энэ саналыг гаргасан, миний бие ойлголцсон. Тэгэхээр энэ Тусгай хяналтын дэд хорооны асуудлыг бид ганцхан улс төрийн талцал хуваагдал гэхээс илүүтэй бидний дээр нэг том эрх ашиг байгаа нь Монгол Улс, Монголын ард түмэн, Монгол Улсын тусгаар тогтнол гэсэн нийтлэг эрх ашиг байгаа.

Тийм учраас Монгол Улсын үндэсний аюулгүй байдалтай холбоотой, Монгол Улсын төрийн хар хайрцгийн нууцлалтай холбоотой, ялангуяа энэ геополитикийн нөхцөл байдал гадна, дотно ийм хүндэрч байгаа үед бид энийг сэтгэл хөөрлөөр улс төрийн талцал хуваагдлаар шийдэж болохгүй. Миний хувьд мөн өөрийн намын бүлэгтээ тодорхой танилцуулга хийсэн. Сүүлийн 4 жил гүйцэтгэх ажилд хяналт тавих Улсын Их Хурлын бие даасан хуулийн төслийг боловсруулж дууссан байгаа. 4 жилийн ажлын үр дүн. Энэ хяналт өөрөө их онцлог байдаг. Зөвхөн энэ хяналтыг 2 Байнгын хорооны эрхлэх асуудалд хувааснаар ямар ч асуудал шийдэгдэхгүйг бид хаана хаанаа мэдэж байгаа. Энэ хуулийн хэлэлцүүлгийн шатад гишүүдийн дунд андуу ташаа ойлголт явсан нь энэ хяналтын хороо нь мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнтэй танилцдаг, эсвэл зөвшөөрөл өгдөг юм байна гэсэн ийм ойлголт гишүүдийн дотор их байна лээ.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд ганцхан прокурор хяналт тавьдаг. Энэ мөрдөн шалгах нууц ажиллагаанд зөвхөн прокурор зөвшөөрөл өгдөг. Энэний үр дүн зөвхөн тусгай хяналтын Монгол Улсад хоёрхон прокурор танилцаж, хяналт тавьж ажилладаг ийм онцлогтой. Энэ дээр парламент энэ үр дүнгийн талаар мэдээлэл авдаг ч юм шиг, танилцдаг ч юм шиг, зөвшөөрөл өгдөг ч юм шиг ийм ойлголт явсан, ийм ойлголт явсан. Тийм учраас энэ парламентын хяналт өөрөө их нарийн онцлогтой байдаг. Улсын Их Хурлын түвшинд гаднын дикаф гэж Олон улсын парламентын холбооноос гаргасан Женев төвтэй байгууллага байдаг. Дэлхийн парламентуудад өгсөн зөвлөмж бас байдаг. Тэгэхээр энэ зөвлөмж, судалгаа дэлхийн ардчилсан 27 улсын хуульд энэ чиглэлээр хяналтын хууль тогтоомжийг орчуулсан судалгаанууд өнгөрсөн 4 жилийн хугацаанд хийгдсэн. Улсын Их Хуралд суудалтай Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам гэсэн 3 намын хамтарсан манлайлал доор энэ хууль тогтоомж шинэчлэгдэнэ.

Тийм учраас 3 намын хамтарсан ажлын хэсэг байгуулаад, Улсын Их Хурлын намрын чуулганд энэ асуудлыг Эрүүгийн процессын хууль, мөн гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг бүтэн шинэчлэх хүрээнд цогцоор нь авч үзэж байж, гишүүдийн санаа чилээж зовоож байгаа энэ асуудал иж бүрнээрээ шийдэгдэнэ. Энийг миний бие өмнөх парламент энэ хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ахалж, бие даасан хуулийн төсөл боловсруулсан хүний хувьд, мөн нотолгоотойгоор, эх сурвалжтайгаар парламентын өмнө та бүхэнд батлан хэлж байна. Тийм учраас энэ хуулийн хугацааг 26 оны 5 сарын 1 хүртэлх хугацаагаар хойшлуулах ийм тохиролцоонд хүрсэн байгаа. Тэр үндэслэлээр чиглэл өгнө үү.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өгье.

4.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.9 дэх заалтын “тагнуулын гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон гүйцэтгэх” гэж өөрчлөх. Санал гаргасан Баттөмөрийн Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн. Үг өгье.

Б.Энхбаяр: Мөн энэ саналын томъёоллын хувьд сая хэлсэн, саяын ярьж байгаа Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны асуудлыг Улсын Их Хурлын гүйцэтгэх ажилд тавих хяналтын бие даасан хууль, бие даасан анхдагч хуулийг Улсын Их Хурал парламентад суудалтай намууд хамтарч өргөн барьж, хэлэлцүүлж батлах ийм боломжийг зөвшилцөлд хүрсэн учраас 2026 оны 5 сарын 1 хугацаагаар үйлчлэх хугацааг хойшлуулах ийм ойлголцолд парламентын бүлгийн дарга нар ойлголцол, зөвшилцөлд хүрсэн үндэслэлээр гүйцээн боловсруулах ийм чиглэлийг хурал даргалагчаас хүсэж байна. Мөн дараагийн 5 дахь саналын томъёоллыг мөн саяын үндэслэлээр гүйцээн боловсруулах чиглэл өгч өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: 4 дэх санал хураалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгье. 5 дахь асуудлыг гүйцээн боловсруулах чиглэл өгье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Нэг.ТББХ-ны дэмжсэн санал.

Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 69^{1.3} дахь хэсгийн “Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт төсвийн төслийн талаарх илтгэлийг Ерөнхий сайд танилцуулна.” гэснийг хасаж, мөн хэсгийн “илтгэлд” гэснийг

“танилцуулгад” гэж, мөн зүйлийн 69^{1.5} дахь хэсгийн “69^{1.3}-т” гэснийг “69^{1.4}-д” гэж, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 73^{1.1} дэх хэсгийн “хууль болон хамт баталсан хууль, тогтоолд” гэснийг “хуульд” гэж, “хууль, тогтоол” гэснийг “хуулийг” гэж, “хоригийн шинж байдлыг харгалзан” гэснийг “Төсвийн байнгын хорооны саналаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 84 гишүүн буюу 77,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 64.1.1 дахь заалтын “, үг хэлэх” гэснийг “үг хэлж болно. Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлнэ;” гэж, 64.1.3 дахь заалтын “үг хэлэх” гэснийг “үг хэлж болно. Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 64.1.2-т заасан санал тус бүрээр ил санал хураалт явуулна;” гэж өөрчилж, 64.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“64.1.2.хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно. Байнгын хороод зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо хамтарсан хуралдаанаар Байнгын хороодын санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 87 гишүүн буюу 80,6 хувиар санал дэмжигдлээ. Сая санал хураагаад шийдчихлээ шүү дээ. Тэгээд редакц дээр л. Тэгье.

3.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 64.1.4 дэх заалтын “төсвийн” гэснийг хасаж, 64.1.5 дахь заалтын “танилцуулгын талаар гишүүд тайлбар хийж, түүнтэй холбогдуулан асууж” гэснийг “танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 85 гишүүн буюу 78,7 хувиар санал дэмжигдлээ.

4.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 69.1.4 дэх заалтын “хоёр дахь” гэснийг “3 дахь” гэж, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 70.3 дахь хэсгийн “төслийн талаар” гэснийг “төслийн хэлэлцүүлэг хийсэн талаар” гэж өөрчилж, мөн зүйлийн 70.1, 70.3 дахь хэсгийн “, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, нам, эвслийн бүлэг” гэснийг, 70.2 дахь хэсгийн “болон дэд” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 83 гишүүн буюу 76,9 хувиар санал дэмжигдлээ.

5.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг” гэснийг “зөвлөмжийг” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн “42.2.2 дахь заалтын” гэсний дараах “дүгнэлтийг” гэснийг “энэ хуулийн 34.1-д заасан хууль зүйн дүгнэлтийг” гэж, мөн зүйлийн “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг “Хүний хөгжил, нийгмийн бодлогын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 гишүүн буюу 74,1 хувиар санал дэмжигдлээ.

6.Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийн “70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82 гишүүн буюу 75,9 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.ТББХ-ны дэмжээгүй санал. 1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 69¹ дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батжаргал. Төсвийн байнгын хороо дэмжээгүй, Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 80 гишүүн буюу 74,1 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Нэг.ТББХ-ны дэмжсэн санал.

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйл буюу 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.8.Түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулах бөгөөд уг гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроосоо түр хорооны даргаа олонхын саналаар сонгоно. Түр хороо байгуулах санал тавьсан гишүүд даргаа дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсэг гишүүн билүү? Номинчимэг гишүүнд үг өгье.

О.Номинчимэг: Би энийг зориуд протоколд тэмдэглэж үлдээх зорилгоор энэ өөрчилж байгаа саналыг дэмжихгүй байгаагаа хэлмээр байгаа. Тэгээд бид ийм дэлхийд байхгүй түр хорооны даргыг томилдог ийм журамтай болж байна. Ур чадвар, туршлага, хараат бус байдлыг харж сонгодог энэ байдлыг зүгээр анх санаачилсан гэдэг ийм хуулийн томьёолол оруулж ирж байна. Өмнөх 76-тай парламентын зовлонгоо одоо ямар байгаа гэдгийг бодож ирэхгүйгээр тэр зовлонгоо шийдэх шийдэл гэж одоо 126-тай парламентад оруулж ирж байгаа.

Тэгээд энэ дээр ер нь түр хорооны даргыг туршлагатай гишүүн гэхээрээ мэдээж зөвхөн олон сонгогдсон гэж ойлгож болохгүй. Анх удаагаа сонгогдсон ч гэсэн тухайн асуудлаар туршлагатай, ур чадвартай, хамгийн гол нь хараат бусаар ажиллах чадвартай байх гэдэг энэ шалгуурыг тавьдаг. Тэгээд санаачилж, анх санаачилж байгаа буюу анх санаачилж байгаа бол олон хүн байгаа л даа. Тэрний энэ зүгээр нэг нь бланкаа ашиглуулж байгаа гишүүн нь ийм байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ ийм байхгүй тохиолдол гарах вий. Тэгвэл нөгөө бидний зорьж байгаа олон нийт парламентад итгэх итгэл, парламентын хяналтын чиг үүргээ үр дүнтэй, үр өгөөжтэй хэрэгжүүлж байгаа байдал, ил тод байдал, ямар нэгэн ашиг сонирхлын зөрчил, хараат бусаар ажиллах байдал энэ бүх юманд бас сөргөөр нөлөөлөх вий гэсэн ийм зовнил байгаа.

Тэгэхээр хэрвээ энэ заалт маань энэ чигээрээ батлагдвал цаашид хэрэгжилтээр маш нарийвчилж, 32 гишүүн зурах гэж байгаа бол энийгээ маш их бодолцож ер нь хийх ёстой. Миний хувьд энийг ерөөсөө дэмжихгүй байгаа, дэлхийд байхгүй хууль гаргаж байгаа шүү гэдгийг дахин хэлье.

Д.Амарбаясгалан: Энэ дээр Цогтгэрэл гишүүн ажлын хэсэг дээр ер нь юмаа нэгтгэчихсэн үү? Энэ дээр анх ярьж байсан саналаар бол анх санаачилсан гишүүдийн гэдэг ойлголт байсан шүү дээ. Тэгэхээр одоо ганцхан гишүүн гээд ганц тоон дээр ороод ирсэн байна шүү дээ. Гишүүдийн гэдэг нь бас байгаа юу? Тэгвэл энэ чинь ТББХ-ны дэмжсэн санал, 1 дэх санал. Саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 69 гишүүн буюу 63,9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “Тогтвортой” гэснийг “Төсвийн тогтвортой” гэж өөрчилж, “24 дүгээр зүйлийн” гэсний дараа “24.2, 24.3 дахь хэсгийн “Хоёр” гэснийг “Гурав” гэж, мөн зүйлийн 24.2 дахь хэсгийн “хоёр” гэснийг “гурав” гэж,” гэж нэмж, “ , 24.4 дэх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 84 гишүүн буюу 77,8 хувиар санал дэмжигдлээ.

18 цаг болсон байна. Өнөөдөр энэ санал хураалтуудыг дуусгана 1 дүгээрт. 2 дугаарт 2024 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх хуваарьтай байгаа. Тэгэхээр эдгээр асуудлаа хэлэлцэж дуустал чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлбэ гэсэн саналтай байна. Гишүүд дэмжиж байна уу? Дэмжиж байгаа гишүүд гараа өргөө. Гишүүдийн олонх дэмжиж байгаа тул чуулганы хуралдааныг сунгаж уралдуулъя.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Нэг.ТББХ-ны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “чуулганы нэгдсэн хуралдаанд” гэснийг “тухай хуулийн 21.28, 21.30-д заасан асуудлаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82 гишүүн буюу 76,6 хувиар санал дэмжигдлээ.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. ТББХ-ны дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалтын “гүйцэтгэх ажлын” гэснийг “гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны” гэж, мөн заалтын “тусгай хяналтын” гэснийг “хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын” гэж” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Үг өгье.

Б.Энхбаяр: Энэ саналыг мөн түрүүн хэлсэн парламентад суудалтай Монгол Ардын нам, Ардчилсан намын бүлгийн удирдлагууд улс төрийн зөвшилцөл хийж, Тусгай хяналтын холбоотой Улсын Их Хурлын хуульд орж байгаа өөрчлөлтийг 2026 оны 5 сарын 1-ний өдрөөс үйлчлүүлэхээр зөвшилцсөн тул гүйцээн боловсруулах чиглэл хүсэж байна.

Дараагийнх нь мөн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй мөн миний Байнгын хороон дээр дэмжигдээгүй заалт дээр мөн саяын үндэслэлээр гүйцээн боловсруулах чиглэл хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Цагдаагийн албаны тухай хуулийн өөрчлөлтөөр гаргасан зарчмын зөрүүтэй ТББХ-ны дэмжигдээгүй санал, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

ТББХ-ны дэмжээгүй саналыг тус тус гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. Дараагийн асуудал. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

18.42 цаг

Дараагийн асуудал. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхээр гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Одоо санал хураалтад орно. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70 гишүүн буюу 65,4 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 75 гишүүн буюу 70,1 хувиар санал дэмжигдлээ. Гантөмөр гишүүний төхөөрөмж дээр алдаа зааж байна гэж байна, очъё. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

18.44 цаг

Дараагийн асуудал руу оръё. Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар санал хураалт явуулна. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт.

1.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Байж байгаарай, 2, 3 гишүүний төхөөрөмж. Санал хураалт. Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 74 гишүүн буюу 69,2 хувиар санал дэмжигдлээ.

2.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 67 гишүүн буюу 62,6 хувиар санал дэмжигдлээ. Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүллээ.

18.46 цаг

Дараагийн асуудалд оръё. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар санал хураалт явуулна. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 56 гишүүн буюу 52,3 хувиар санал дэмжигдлээ. Түрүүн Цогтгэрэл дарга хэлэлцүүлгийн явцад санал гаргаж, засаж сайжруулах зүйлс байгаа гэдгээ бас илэрхийлсэн. Тэгэхээр Байнгын хороод, намын бүлгүүд хэлэлцүүлгийнхээ явцад асуудлыг түргэн шуурхай, дээрээс нь ойлголцож, асуудлаа шийдвэрлэх ёстой гэсэн ийм байр суурьтай байна.

Хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 59 гишүүн буюу 55,1 хувиар санал дэмжигдлээ.

3.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 67 гишүүн буюу 62,6 хувиар санал дэмжигдлээ.

4.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64 гишүүн буюу 59,8 хувиар санал дэмжигдлээ.
4.Усны тухай хуульд нэмэлт.

5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 81 гишүүн буюу 75,7 хувиар санал дэмжигдлээ.

6.Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70 гишүүн буюу 65,4 хувиар санал дэмжигдлээ.

7.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 73 гишүүн буюу 68,2 хувиар санал дэмжигдлээ.

8.Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 66 гишүүн буюу 61,7 хувиар санал дэмжигдлээ.

9.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 71 гишүүн буюу 66,4 хувиар санал дэмжигдлээ.

10.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70 гишүүн буюу 65,4 хувиар санал дэмжигдлээ.

11.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 67 гишүүн буюу 62,6 хувиар санал дэмжигдлээ. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ болон ЭЗБХ, ХЗБХ, БОХХАА-н байнгын хороонд шилжүүллээ.

18.52 цаг

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар санал хураалт явуулна. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Санал хураалт.

1.Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалтдаа бэлдье. Баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 78 гишүүн буюу 72,9 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

18.53 цаг

Нийслэлийн хууль дээр Төсвийн байнгын хороог нэмэх юм байна. Ингээд 5 Байнгын хороогоор хэлэлцүүлэгдэх юм байна шүү. Төсвийн байнгын хороонд Нийслэлийн түгжрэлийг бууруулах хуулиудын төслийг бас шилжүүллээ.

Долоо.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Далайн Батбаяр гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Доржготовын Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Жамсранжавын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Бэлтрэгийн Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Чойжилсүрэнгийн Тавинжил Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Очиржанцаны Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Жаргалсайханы Гэрэлбат Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан, бүртгэлийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Нямдаваагийн Саруул Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татварын бодлогын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалт, удирдлагын арга зүйн газрын дарга. Далайн Батбаяр гишүүнийг индэрт урьж байна.

Д.Батбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Улсын Их Хурлын Байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн зарлагын хяналтын дэд хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2 дахь заалтын дагуу 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл болон Улсын Их Хурлын байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг хэлэлцэн нэгтгэж, та бүхэнд танилцуулж байна. Үндэсний аудитын газраас Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, Улсын Их Хуралд дүгнэлтээ хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтэд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн өмнөх оноосоо 27,4 хувиар өсөж, 29 их наяд 670 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 35,9 хувиар өсөж, 30 их наяд 591 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 920,3 тэрбум төгрөгийн алдагдалтай байна гэсэн дүгнэжээ. Түүнчлэн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан боловч 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор төсвийн хүрээний мэдэгдэлд дахин өөрчлөлт оруулж байгаа нь төсвийн тогтвортой байдлын зарчим алдагдаж байгаад анхаарлаа хандуулах, мөн төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлах зөрчил давтагдаж байгаа тул төсвийн төсөлд шаардлага хангаагүй арга хэмжээг санал хүргүүлсэн, өргөн барьсан, баталсан тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн орчныг сайжруулах, улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар өмнө жилүүдэд Улсын Их Хуралд толилуулсан, Засгийн газарт зөвлөсөн асуудалд шинжилгээ хийж, улсын төсвийн хөрөнгө оруулалтыг дунд хугацаанд төлөвлөхгүй орхигдож буй тогтолцооны алдааг залруулах тодорхой шийдвэр гаргах зэрэг зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн байна.

Мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу гаргасан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэлийн дүгнэлтэд гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжаар гүйцэтгэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үр нөлөө, эргэн төлөлтийг олон нийтэд нээлттэй хэлэлцүүлж, нөхцөл байдлыг үнэлэх. Мөн гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн тоо хэмжээтэй нэмэгдсэн холбоотой зээлийн зардал өсөж байгааг анхаарах. Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан хариуцлагын зохицуулалтыг бодитоор хэрэгжүүлдэг байх. Төсвийг үр ашиггүй зарцуулсан Үндэсний аудитын газрын аудитаар өгсөн зөвлөмж, шаардлагыг биелүүлээгүй, зөрчлөө арилгаагүй төсвийн захирагчдыг албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болох эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байгааг онцолсон байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т заасны дагуу Улсын Их Хурлын Байнгын хороод 2025 оны 6 дугаар сарын 30, 7 дугаар сарын 1-ний өдрүүдэд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлэг явуулж, дараах санал, дүгнэлтийг ирүүлснийг танилцуулж байна.

1. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Малын гоц халдварт өвчний зардлын ангилал, хөнгөн үйлдвэрлэлийн төсөл, Засгийн газрын үр өгөөжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц төсвийн бодлого, төлөвлөгөөний зорилт, шалгуурын хэрэгжилт, Улсын Их Хурлын гишүүн Очирбат төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн уялдаа, зардлын шинэчлэл, аудитын дүгнэлтийн хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдаваа татварын зөрчил, мөнгө угаах, татварын өрийн зохицуулалтын талаар тус тус санал хэллээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр Элчин сайдын яамны барилга, Зэвсэгт хүчний сан, Өвөрхангайн цэргийн ангийн хөрөнгө оруулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл онцгой байдлын техник, албан хаагчдын нөхцөл байдал, дипломат

байгууллагын зардал, хяналтын хэрэгжилт, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд Төрийн шийдвэр гаргалтын үе шатад мэдээллийн нэгдсэн санг эргэлтэд оруулж, шийдвэр гаргалтыг эрэмбэлэх, Үндэсний аудитын газар төрийн шийдвэр гаргалтын үнэлгээг хийх төсөөтэй аргын судалгааг боловсруулж, эрэмбэлэх загварчлал хийх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Гадаад харилцааны яамны зарлагын гүйцэтгэл, зөрөөгийн шалтгаан, алдааг засах арга хэмжээ, Улсын Их Хурлын гишүүн Анар татварын зөрчил, төсвийн тодотгол, ачааллын, төсвийн тодотголын ачааллын талаар асуулт асууж, санал гаргасан.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ Үндэсний аудитын газрын бодлогын түвшинд ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх, аудитын дүгнэлтэд зөрчлийг зөв нэгтгэн тусгах, бодлогын шийдэлд тулгуурласан санал, дүгнэлт боловсруулах шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар төсвийн зөрчил, хариуцлагын асуудал болон зарцуулаагүй төсвийн үлдэгдлийг хэрхэн шийдвэрлэх талаар асуулт асууж, санал гаргасан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун их, дээд сургуулийн тогтмол зардлыг бууруулах нь багш, ажилчдын цалин, сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буйг онцолж, өөр хувилбар байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл боловсрол, соёлын салбарын төсвийн хэмнэлтийн шалтгаан, бодит хэрэгцээнд нийцэж буй эсэх талаар асуулт асууж, санал гаргасан.

Ёс зүй, дэгийн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Очирбат батлагдсан төсвийг байнга тодотгоод байгаа нь хуультай зөрчилдөх эсэх, татварын өр, зарлагын өсөлт ба иргэдийн орлогын харьцаа, аудитын байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх улс төрийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл Төрийн албаны зөвлөлийн зардлын хэмнэлт, гүйцэтгээгүй ажлын нийцлийн аудит, хариуцлага, ирээдүйн төлөвлөлтийн үндэслэлийн талаар асуулт асууж, санал гаргасан.

Инновац, цахим бодлогын байнгын хороо Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй холбоотой санал, дүгнэлт гаргаагүй болно.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжээгүй хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өр, авлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат орон нутгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, тендерийн асуудал, авлагын барагдуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Баярмаа Хавдар судлалын үндэсний төв 2 төслийн хэрэгжилт, тоног, төхөөрөмжийн санхүүжилтийг хассан талаар, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ аудитын зөвлөмжийн хэрэгжилт, арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун гадаад дахь хөдөлмөр, халамжийн байгууллагын байдал, холбогдох институтын үйл ажиллагааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа хэрэгжээгүй 29 төсөл, аудитын дүгнэлтийн агуулгын талаар, Улсын Их Хурлын гишүүн Бейсен Баян-Өлгий аймгийн эрүүл мэндийн салбарын гүйцэтгэл, даатгалын сангийн өрийн асуудлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхнасан эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах болон эрүүл мэндийг дэмжих сангийн гүйцэтгэлийн талаар асуулт асууж, санал гаргасан.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Болормаа төсвийн гүйцэтгэлийг зөвхөн 100 хувь зарцуулалтаар бус бүтээмж, ажлын чанараар нь үнэлэх, хэмнэлт хийсэн байгууллагыг урамшуулах хэмнэлтийн тогтолцоог бий болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг нарийн ангилан тайлбарлаж, олон нийтэд зөв ойлголт өгөх нь чухал бөгөөд нягтлан бодох бүртгэлийг залруулж болох зөрчил, санхүүгийн сахилга баттай байдал, батгүй байдал, гэмт хэргийн шинжтэй зөрчлүүдийг ялгаж мэдээлэх талаар санал гаргасан.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар гадаад, зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, төрийн өмчит компани, Төрийн банкны үйл ажиллагаа, аудитын зөрчлийг тодруулсан бол, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар гадаад зээл, мөнгөн урсгалын төлөвлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн зарцуулалт, зөрчлийг арилгах талаар Засгийн газар, төсвийн ерөнхийлөн захирагчид анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн хариуцлага, сахилгыг сайжруулах, гүйцэтгэлийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх хугацааг сунгах талаар санал гаргасан.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд аудитын дүгнэлт, зөвлөмжид хэрэглэгдэж буй анхаарах гэх нэр томьёо нь эрх зүйн болон бодлогын агуулгаар зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай зөрчил, дутагдлыг илэрхийлж байгаа эсэх талаар, хууль сахиулах болон шударга ёсыг хангах чиг үүрэгтэй байгууллагын төсөв, хүний нөөц дээр цомхотголын бодлого хэрхэн тусгагдсан талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд Шинжлэх ухааны цогцолборын гүйцэтгэл, барилга, хот байгуулалтын салбар дахь аудитын зөрчил, Улсын Их Хурлын гишүүн Мандхай аж ахуйн нэгжийн орлогын албан татар, нэмэгдсэн өртгийн албан татварын хамаарлыг хэрхэн бууруулах, аудитын дүгнэлтэд дурдагдсан төсвийн зөрчил болон хяналт хариуцлага, өртгийн ялгаа, зардлын үр ашгийн дүн шинжилгээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан орон нутгийн үнэт цаас, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан мега төслийн хэрэгжилт, цахилгааны үнэ, олимпын зардлын талаар асууж, санал хэлсэн. Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат татаас, 20 минутын хотын худалдан авалт, уул уурхайн хөдөлмөр, аюулгүй байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Батчимэг улсын, орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг хамтатган хэлэлцэх, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц хөтөлбөрийн үр дүн, гүйцэтгэлийн тайлагналын чанарыг сайжруулах саналуудыг гаргасан болно.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Батболд аудитын зөрчилтэй дүгнэлт гаргасан байгаа төсвийн ерөнхийлөн захирагч нарт хариуцлага тооцох талаар, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө ашиглалтыг сайжруулахад гаргалгаа гаргаж, гэрээний нөхцөлийг сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Төсвийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход анхаарах, төсвийн гүйцэтгэлийг хагас жил тутамд хянадаг тогтолцоог бүрдүүлэх, давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалаад төсвийн хүрээгээ хөндөж, төсвийн тодотгол хийдэг асуудал үүсэж байгаа тул эрх зүйн орчныг сайжруулах, төсвийн захирагч нарын боловсрол тогтвортой байхад анхаарч, программ хангамжийг сайжруулах, хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлыг хангах бүтцийг бий болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар улсын

төсвийн орлого бол иргэд, аж ахуйн нэгжийн татварын орлого тул төсөв батлахдаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах, төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн зарцуулалтын зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох, орон нутгийн төсөв, онцгойлон нийслэлийн төсвийг хянах талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдаваа аудитын байгууллагын дүгнэлтээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг зөрчсөн 161,6 тэрбум төгрөг, харьяа байгууллагын төсвийг санхүүжүүлсэн 150 тэрбум төгрөг, Тавантолгойн ноогдол ашгийн хуваарилаагүй 108 тэрбум төгрөг, Шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Бейсен эрүүл мэндийн салбарт он дамжсан өр төлбөрийг хэрхэн шийдэж байгаа эсэх талаар, Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийг хүлээн авч, үйл ажиллагааг эрхлүүлэх талаар, Их хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Батбаяр төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 14 мега төслийн 2024 оны гүйцэтгэлийн талаар, төсөвтэй холбоотой бүх мэдээллийг 1 системээр хадгалах, түүнийг аудитын байгууллага хянах, төсвийн гүйцэтгэлийн тоон мэдээллийг нэг стандартад оруулах, Баруунбүрэн сумын гүүрний бүтээн байгуулалтын ажлын санхүүжилт, хяналтын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын төсвийн зардлын, зардлуудын эдийн засгийн ангилал болон улсын стандартын дагуу Олон улсын валютын сангийн GFS-ээр хийгдэж байгаа боловч төсвийн урсгал зардлын ангилалд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид хамаарах задаргааг илүү оновчтой тодорхой болгох шаардлагатай байна. Тодруулбал, Монгол Улсын 2023 болон 2024 оны төсвийн гүйцэтгэл дэх бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг харьцуулсан мэдээллийг харахад ерөнхий дүнгээрээ 2023 онд 1,1 их наяд төгрөг байсан бол 2024 онд 1,49 их наяд болж, 38 хувиар өссөн байна.

Нийгэм, эдийн засгийн үр нөлөөг харгалзаж, төсвийн гүйцэтгэлийг үнэлэх буюу хуваарилсан төсвөө зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж чадаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх ёстой. Үүний тулд гүйцэтгэлийн үр дүн үнэлэх үзүүлэлтийг зөв тодорхойлж, улс орны хөгжлийг бодит хэмжүүрээр нь дүгнэх нь цаашдын зорилго, зорилтод эрэмбэлэхэд ач тустай юм. Одоогийн мөрдөж байгаа гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг үзүүлэлтийн суурь түвшин, хэмжих нэгжийг өөр өөрөөр тогтоосон байгаад цаашид анхаарах шаардлагатай байна. Нөгөөтгээгүүр төсвөө зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байгаа эсэхэд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, хязгаарлагдмал нөөц бололцоог үр ашигтай зарцуулахын тулд төсвийн гүйцэтгэлийн хяналтыг эрсдэлд суурилсан байх зарчмыг тууштай баримтлан нэвтрүүлэх, төрийн хяналт шалгалт хэрэгжүүлдэг байгууллагуудын мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээлэл солилцоо, эрсдэлийн үнэлгээ хийхэд нийтлэг стандарттай болох зэрэг асуудлуудыг шийдвэрлэх мөн шаардлагатай байна.

Үндсэн хуульд заасан ёсоор Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах нь Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах билээ. Энэхүү бүрэн эрхээ хангалттай бүрэн хэрэгжүүлэхийн тулд юуны түрүүнд улсын нэгдсэн төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх цаглаврын хугацааг нэмэгдүүлж, Улсын Их Хурлын гишүүдийг нэмэлт мэдээлэл, тайлбар авах, сонгогчдын саналыг сонсох боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байгааг онцлон тэмдэглэмээр байна. Жишээлбэл Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол үндэсний, Монголын Үндэсний аудитын газрын тайлан,

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт зэрэг 600 гаруй хуудас баримт бичгүүдийг энэ 6 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авсан ба үүнийг 10 хүрэхгүй хоногт уншин судлах, харьцуулалт хийх, нэмэлт мэдээлэл авах, иргэдийн санал хүсэлтийг авах боломжгүй байгаа нь тодорхой байна. Иймээс улсын нэгдсэн төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх цаг цаглаварт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Жил бүр улсын төсвийг батлахдаа Засгийн газарт төсвийн ил тод, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн бүх шатын төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлага дээшлүүлэх, аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудалд хариуцлага тооцож, холбогдох хуульд нийцүүлэн хийдэл, зөрчлийг арилгуулах зэрэг арга хэмжээг авахаар заасан байдаг. Гэтэл хувийн хэвшлийн байгууллага, иргэдэд тавьсан актын биелэлт бараг 90 хувьтай байхад Үндэсний аудитын газраас илрүүлсэн зөрчил, тавьсан акт, албан шаардлагын 50 орчим хувь нь биелэгдэхгүй байхад анхаарч, хариуцлага тооцож, ил тод мэдээлж байхыг шаардлагатай байна. Үүний тулд Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан хариуцлагын зохицуулалтыг бодитоор хэрэгжүүлдэг байх, төсвийг үр ашиггүй зарцуулсан, Үндэсний аудитын газрын аудитаар өгсөн зөвлөмж, шаардлагыг биелүүлээгүй, зөрчлөө арилгаагүй, төсвийн захирагчдыг албан тушаалаас нь огцруулах хуулийн заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тухайн жилийн, Засгийн газар аливаа хөтөлбөр хэрэгжүүлэн тусгайлан жил болгон зарласан бол хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд ирүүлдэг байх шаардлагатай байна. Жишээлбэл 2024 онд Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарласан. Мөн гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжаар гүйцэтгэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үр нөлөө, эргэн төлөлтийн талаар ил тод мэдээлэх, нөхцөл байдалд үнэлгээ хийхийн чацуу гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн тоо, хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой зээлийн зардал өсөж байгааг анхаарах шаардлагатай байна. Төсвийн зарлагын хяналтыг сайжруулах зорилгоор Сангийн яам бүх шатын төсвийн захирагч, захиран зарцуулагчдын санхүүгийн тайланг бүртгэл талаас нь нэгтгэдэг байх, төсвийн гүйцэтгэлийг хүрсэн үр дүнгээр нь тайлагнадаг болох асуудлыг судалж, тодорхой арга хэмжээ авах, мөн төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн тодотголоор хүрсэн үр дүнгээ тайлагнаж ирүүлэх зэрэг шаардлага тавих, үүнд нийцүүлэн дотоодын аудитын тухай хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтыг сайжруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэх журамд өөрчлөлт оруулах хэрэгтэй байна. 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан гарсан Улсын Их Хурлын холбогдох хууль, тогтоолын хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг танилцууллаа. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 3 гишүүнээр тасаллаа. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Оройн мэнд хүргэе. Дийлэнх гишүүд маань явчих шиг боллоо. Энэ нэг холбогдолтой нэг асуудал асуухаасаа өмнө Улсын Их Хурлын гишүүддээ нэг уриалга дэвшүүлэх гэсэн юм. Өнөөдөр бидний жилийн өмнө тангараг өргөж, гишүүн болж эх орон, иргэд, олон нийтийнхээ эрх ашгийн төлөө тангараг өргөсөн өдрийн нэг жилийн ойн өдөр болж байна. Тэгээд нийт гишүүддээ баяр хүргэе. Тэгээд үүсгэн байгуулагдсанаасаа хойш өнөөдрийг хүртэл ер нь бүхий л түвшинд энэ парламент бүх түвшинд хэмнэлтийг, таналтыг Засгийн газар, холбогдох яам, агентлаг, газруудаас шаардаж шахсаар ирж байгаа. Харин энэ өөрчлөлтийг Улсын Их Хурлын гишүүд өөрсдөөсөө эхэлье гэж дуугарахгүй байгаад их гайхаж, эгдүүцэж байна. Тийм учраас би энэ дээр шүүмжлэлтэй хандмаар байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурлын 126 гишүүн бүрд сар бүрийн цалин, зөвлөх, туслахын цалин, хот доторх унааны мөнгийг нь хүртэл 940 билүү мянган төгрөг өгч байгаа шүү дээ. Энэнээс цаана бидэнд бас төсвийн яг мөнгөн дүнгээр нь хэмжвэл 23 сая орчим төгрөг байгаа. Тэгэхээр энэ юу гэнэ вэ, энэ мөнгө байна шүү дээ, энэ мөнгийг яг үнэнийг хэлэхэд зориулалтаар нь зарцуулахгүй байгаа Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн байна. Тийм учраас би шүүмжлэлтэй хандаж байгаа юм. Зарим Улсын Их Хурлын гишүүд өрөө дүүрэн үр хүүхэд, өөрсдийнхөө ах дүү, амраг садан, хүргэн, бэрүүдээ авчраад ингээд цалингийн зардлаар зөвлөх, туслах гээд, тэртээ тэргүй орон тооны 1 зөвлөх, 1 туслахыг цаанаас нь тавьчихаад, төрөөс цалинжуулаад, татвар төлөгчдийн мөнгөөр цалинжуулаад байхад дахиад өрөө дүүрэн хүмүүс авчирчихаад тэд нарынхаа бүгдийг нь ингээд ах дүү, амраг саднаа цалингийн зардлаар тэжээж байгаа хүмүүс ч гэсэн байна.

Тэгэхээр зэрэг би энэ сар бүрийн энэ Улсын Их Хурлын төсвийн, гишүүдийн төсвийг бүрэн байхгүй болгож танаад, ингэснээрээ бид сар болгон 2,8 тэр тэрбум төгрөг, жилд 35 тэрбум төгрөг хэмнэж, үлдсэн 3 жилийн хугацаанд бид 100 орчим тэрбум төгрөгийг хэмнэж, энэ улсын татвар төлөгчдийн өмнө нэг буян болох ийм боломж байна гэж би уриалж байгаа юм. Тэгэхээр энэ мөнгөнөөс яг үнэнийг хэлэхэд энэ гадаад, дотоод бүхий л томилолтыг түүдэг хэдэн гишүүд байна. Заримынх нь бараг хэл нь ч хүрэхгүй шахам байж явж л байдаг. Тэгэхээр ийм хүмүүсийн зүгээр нэг гадаад явж үздэг мөнгө, эсхүл ах дүү, амраг саднаа цалинжуулдаг ийм мөнгө байлгахын эсрэг бас уриалга дэвшүүлж байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ мөнгийг бүгдээрээ болиод, харин энэ мөнгөөрөө бид хэмнээд, тэр бусдаас хэмнэ, тана гэж шаарддаг энэ мөнгөө бид өөрсдөө хэмнэе.

Тэгээд энэ татвар төлөгчдийн мөнгөөр хэвлэлийн PR өөрсдийнхөө хувийн улс төрчийн PR хийдэг энэ мөнгө бас ингэж зарцуулагдаж байгаа шүү дээ. Тэгэхээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут чинь тодруулахад зориулдаг юм. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүнд 1 минут нэмж өгье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр энэ Улсын Их Хурлын гишүүд өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлмээр байна гэдэг санал, санаачилгыг дэвшүүлж байгаа юм. Т

Энэ 24 оны төсвийн гүйцэтгэл дээр нэг ийм сошиал дээр нэг ийм юм яваад байна. 9 их наядын зөрчил гарсан гээд яваад байна. Энэ болохоороо зэрэг тэнцвэржүүлсэн тэнцэл 920 тэрбум төгрөгийн алдагдалтай байна гээд байна. Энэ

хоёрын аль нь үнэн юм бэ? 9 их наядын зөрчил гэдэг нь алдагдал юм уу, зөрчил гэдэг нь эсхүл төрийн хулгай юм уу, юу юм бэ энийг тодруулж өгөөч? Хаана нь үнэн юм байгаад байна гэдгийг энэ аудитын газраас бас тодруулж өгнө үү гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий аудитор Магнайсүрэн дарга 4 дүгээр индрээс хариулъя. Нэмж Далайн Батбаяр гишүүн хариулт өгч болно. Танай санал, дүгнэлттэй холбогдсон учраас.

С.Магнайсүрэн: Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Ерөнхий аудитор Магнайсүрэн. 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлээр аудитын дүгнэлтэд зөрчлийн дүнг нэгтгэж оруулсан. Энэ дотор ер нь өнгөрсөн жилүүдийн дундаж, жилүүдийн зөрчлийн дүнг харвал 4 орчим их наядын ийм зөрчилтэй явж ирсэн юм байна лээ. Тэгээд энэнээс буурсан, нэмэгдсэн гээд ингээд дүгнээд явж байсан. Энэ жилийн хувьд 9,2 гээд энэ их наядын зөрчил гэдэг ийм дүн гарсан. Энэ дээр гол зөрчил нь болохоор зэрэг 5 их наядын нягтлан бодох бүртгэлийн стандартын бүртгэлтэй холбоотой зөрчил төрийн Сангийн яамны Төрийн сангийн бүртгэл дээр гарч ирсэн гэдгээр энэ зөрчил ингэж огцом нэмэгдсэн ийм дүн гарсан.

Ер нь эндээс 27 тэрбум төгрөгийн 2364 төлбөрийн акт тогтоогдсон, 60 тэрбум төгрөгийн зөрчил дээр 165 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 151 албан шаардлага хүргүүлсэн, 1,6 их наядын зөрчил дээр 6009 зөвлөмж өгсөн, 10,2 тэрбум төгрөгийн зөрчил дээр, 10,2 тэрбум төгрөгийн 26 зөрчлийг бид хууль хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй гэж ингэж дүн гарч ирсэн байгаа. Зөрчлийн асуудлаар Байнгын хороод дээр хэлэлцэж байх явцад энэ тал дээр онцгойлон анхаарч ажиллах ёстой гэж үзсэн. Бид 8 сараас завсрын аудитдаа орохдоо энэ зөрчлийн асуудлаар онцгойлон анхаарч, дараагийн 25 оны тайлан, гүйцэтгэлийн аудитын үед энэ зөрчлүүдийг эрс багасгах ийм төлөвлөлт, төсвийн ерөнхийлөн захирагчидтай хамтран ажиллах ийм ажлыг энэ 8 сараас эхлүүлнэ гэж тооцож байгаа юм. Энэ удаагийн зөрчлийн 24 оны тухайд ийм тайлбар өгөхөөр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нарантуяа-Нара гишүүн тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр үүссэн зөрчил дээр арга хэмжээ, ямар хариуцлагын арга хэмжээ авдаг юм бэ? Энэ ялангуяа улсыг хохиролтой болгосон, энэ цагтаа хийгээгүй энэ хариуцлагыг хэн хүлээх юм бэ? Холбогдох яам, газар, тэр гүйцэтгэх төсвийн ерөнхийлөн захирагчид нөхөж хүлээх юм уу, эсхүл энийг нь 25 он руу нь шингээгээд ингээд явах юм уу? Ямар байдлаар шийдэх юм бэ?

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс Магнайсүрэн дарга хариулт өгье.

С.Магнайсүрэн: Нарантуяа гишүүний асуултад тодруулж хариулъя. 24 оны гүйцэтгэлээр бид 165 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн. Энэ бол 60 орчим тэрбум төгрөгийн зөрчил дээр, мөн 10,2 тэрбум төгрөгийн зөрчлийг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзээд хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Хууль хяналтын байгууллагад шилжүүлээд гэмт хэргийн чанартай бол эрүүгийн хариуцлага хүлээгдэнэ. Саяын 151 албан шаардлагаар 165 албан тушаалтанд хариуцлага тооцуулах асуудлаа бид бүртгэл, хяналтдаа аваад, энэ хариуцлагыг нь тооцуулна.

2 дугаарт Төсвийн тухай хуулийн 70.3 дээр байдаг энэ заалтаар бол энэ төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, хууль тогтоомж зөрчиж энэ хөрөнгийг, өмч хөрөнгийн асуудал дээр зөрчил гаргасан тохиолдолд албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно гээд ингээд тодорхой заачихсан заалтууд бий. Тийм учраас бид энэ Төсвийн тухай хуулийн энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Магнайсүрэн дарга гүйцээж хариулах уу, болсон уу? Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Төсвийн гүйцэтгэл бол Улсын Их Хурлын гишүүдийн өндөр ач холбогдол өгөх ёстой чухал асуудлуудын нэг. 2024 онд Засгийн газар нийт 30,5 их наяд төгрөгийг зарцуулсан. Бид өнөөдөр энд үрж дуусгасан мөнгө ярьж болохгүй, үр дүн ярих ёстой. Төсвийн мөнгө улсын мөнгө гэж байхгүй, татвар төлөгчдийн мөнгө л гэж байгаа. Засгийн газар үр дүнгээ зөв, бодитоор тайлагнаж, харин Улсын Их Хурал хяналт тавьж, үр дүнд суурилсан засаглалыг Засгийн газраас нэхэж шаардаж, шахаж ажиллах ёстой. Ингэж байж Монгол Улс жил бүр алхам алхмаар хөгжиж, иргэдийн амьдрал сайжрах боломж бүрдэнэ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Улсын Их Хурлын Тамгын газрын дүгнэлтэд үндэслээд дараах 4 асуудлуудын шалтгаан болон шийдлийг асууя.

1 дүгээрт, Засгийн газар төрийн бүтцийг цомхотгоно гэсэн зорилго тавьсан. 2023 онтой харьцуулахад төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани, төслийн нэгж, сангуудын тоо 190-ээр өсөөд, төр улам томорсон байна.

2 дугаарт, Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банкнуудад байршуулсан 257 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн. Нийт 142 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах ажил удаашралтай байгаад байна. Энийг хэзээ барагдуулах вэ?

3 дугаарт, Хөдөлмөр эрхлэлт, Боловсролыг дэмжих, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөрүүдээр нийт олгосон зээл болон дэмжлэгээс 97 тэрбум төгрөг нь чанаргүй, 212 тэрбум төгрөгийн үлдэгдэл нь эргэн төлөгдөөгүй, эсвэл хугацаа хэтэрсэн байна. Олон төрлийн хөнгөлөлт олгоод байхад 2024 оны эцэст ажилгүйдлийн түвшин 5,3 хувь болж, өмнөх онтой харьцуулахад 1,4 хувь өссөн байна. Үүний шалтгаан шийдлийг юу гэж харж байна вэ?

4 дүгээрт нь, хамгийн ноцтой нь төсөвт байгууллагуудын авлага 729 тэрбум, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын авлага 3,1 их наяд, төрийн сангийн авлага 1,4 их наяд, төсөл, сангийн авлага 1,5 их наяд болоод нийтдээ 6,8 их наяд төгрөгийг буюу улсын төсвийн нийт зарлагын 22 хувьтай нь энэ дүн нь тэнцэж байна. Татвар төлөгчдийн мөнгөнд ингэж хариуцлагагүй хандаж болохгүй. Энэ авлагыг хэзээ авах вэ, энэ боломж бүрдэх үү? Улсын төсвийн гүйцэтгэл бол компанийн гүйцэтгэх захирал санхүү, үйл ажиллагааны тайлангаа Төлөөлөн удирдах зөвлөлдөө танилцуулж байгаатай адилхан. Хэрвээ хувийн хэвшил ийм тайлан тавиад, ийм нөхцөл байдалтай сууж байвал хариуцлагын энэ асуудал маш ноцтой яригдана. Энийг яаж, засаж залруулах вэ гэдэг 4 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Тогтвортой байдлын зөвлөлөөс, Тогтвортой байдлын зөвлөлөөс хариулт өгье. Индэр, 3 дугаар индэр.

Р.Ринчинбазар: Тэгэхээр бид, Тогтвортой байдлын зөвлөлийн Ринчинбазар. Бид төсвийн гүйцэтгэл дээр санал, дүгнэлтээ, зөвлөмжөө бичсэн байгаа. Тэрнээс бид яг тэр өр авлага барагдуулах юм уу, цаашдын үйл ажиллагаа дээр, тэр хариуцлага тооцох энэ тэр тийм эрх мэдэлтэй субъект биш. Тэгээд тэн дээр бол бид юундаа дүгнэлтдээ тодорхой зөвлөмжөө бичсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд хариулт өгье. Өөрийнхөө салбарын асуудлаар.

П.Наранбаяр: Боловсролын зээлийн сангийн ихэнх үлдэгдэл нь дандаа гадаадад сурсан хүмүүсийн эргэн төлөлт байдаг. Тэгээд бид нийт 14 мянган хүний материалыг Монголбанканд шилжүүлж, эргэн төлөлт эрс сайжирсан. Энэ жилийн тухайд хагас жилийн байдлаар 8 тэрбум төгрөг эргэн төлөгдсөн. Гэхдээ төсөв дээр суухдаа 33,6 тэрбум төгрөгийг эргүүлэн төлүүлэх ийм үүрэг хүлээсэн байгаа. Цаашдаа энэ эргэн төлөлт илүү сайжирна. Бид журмаа шинэчилсэн энэ ийм байгаа. Тэгээд 24 онд нийтдээ 14,5 тэрбум төгрөгийг төлүүлсэн байгаа. Чанаргүй зээлийг энэ үүсчхээд байгаа төлөгдөөгүй байгаа энэ зээлийг эргүүлэн төлүүлэхийн тулд хуулийн баг авч ажиллуулахаар ярьж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс хариулт өгье. Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр 4 тодорхой асуултуудыг асууж байна. Ер нь энэ 1 дүгээрт төсөвт байгууллага болон энэ төрийн албан хаагчдын орон тооны асуудлыг бид намрын 2026 оны төсвийг өргөхдөө чиг үүргийн шинжилгээг нарийвчилсан байдлаар хийе гэдэг ийм төлөвлөгөө гаргаад явж байгаа. 4 чиглэлээр хийнэ гэсэн бодолтой байгаа. 1 дүгээрт Засгийн газрын чиглэлээр, 2 дугаарт орон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиглэлээр, 3 дугаарт шүүх байгууллага, 4 дүгээрт Их Хурлын харьяа байгууллагууд гэдэг байдлаар яваад, ингэсэн тохиолдолд бид тодорхой тэр пропорцыг гаргаж ирэх боломжтой гэж үзэж байна. Тэгсэн тохиолдолд энэ төсвийн байгууллага болон орон тоог нь зөв пропорцыг гаргаж ирээд, төр өөрийнхөө үүрэх энэ чиг үүргүүдээ тогтоох боломжтой гэж үзэж байна.

2 дугаар асуудал энэ банкнуудад байгаа мөнгөн хөрөнгийн эрсдэлд орсон асуудлыг яах вэ гэдэг зүйл ярьж байгаа. Энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

М.Санжаадорж: Энэ эрсдэлд орсон мөнгөн хөрөнгийг авах чиглэлээр сүүлийн үед үе үеийн тухайн салбарын сайдууд албан бичгийг хүргүүлээд, мөн прокурорт хандаад ингээд явж байгаа. Манай улсын хуулиар Дампуурлын тухай хуулиар хэний хөрөнгийг түрүүлж барагдуулах вэ гэхлээр иргэний хөрөнгийг барагдуулчихаад байдаг. Гэхдээ энэ өөрөө бас иргэдийн хадгалуулж байгаа тодорхой хөрөнгө байдаггүй учраас шүүхэд хандаад тодорхой үр дүнд хүрсэн ийм ажлууд байгаа. Гэхдээ бодит үр дүн дээр 1 дүгээрт мөнгөн хөрөнгийн cash-г бид барагдуулах асуудал, 2 дугаарт бодит үл хөдлөх хөрөнгийн асуудал, 3 дугаарт яаж байна вэ гэхлээр авлагуудын асуудал орж ирсэн тохиолдолд энэ барагдах ийм боломжтой болчихоод байгаа юм.

3 дугаар асуудал Засгийн газрын тусгай сантай холбоотой асуудал байна. Бид уг нь энэ сая тодотголыг дагуулж өргөсөн тогтоол дээр 2, 3 зарчмын зүйл оруулсан. Засгийн газрын тусгай сангуудыг одоо өөрөө өөрийгөө санхүүжүүлэх боломжтой сангаас бусад сангуудыг татан буулгая гэж байгаа. Улсын төсвөөс зүгээр санхүүжилт аваад явж байгаа энэ сангуудыг татан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Санжаадорж даргад дахин 1 минут өгье.

М.Санжаадорж: Уучлаарай. Тэгэхлээр ийм зарчмын асуудал оруулж ирсэн байгаа. Дараачийн ээлжид энэ авлагатай холбоотой асуудал байгаа. Авлагатай холбоотой асуудлаар бид өр авлага үүсгэхгүй байх талаар одоо гишүүдийн яг асуугаад байгаа гүйцэтгэл дээр ингээд олон зөрчил яриад байдаг яах вэ гээд байгаа. Энэ дээр хариуцлага тооцье гэсэн заалт оруулж ирсэн байгаа. Мөн түүнчлэн таны ярьж байгаа энэ зүйлүүдийн эцсийн зүйл нь үр дүнгээ бид яаж хэмжих вэ л гэдэг асуудал байгаад байгаа. Үр дүнтэй холбоотой асуудлыг улам бид бас энэ тогтоол дээр юу гэж орж ирсэн бэ гэхлээр төсвийн жилд санхүүжүүлэх хөтөлбөрийн үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг жилийн Төсвийн тухай хуулийн хавсралтад тусгаад, тодорхой тусгаад, тэгээд үүнийгээ жилийн төсвийн гүйцэтгэл хэлэлцэх үед нь төсвийн ерөнхийлөн захирагчид нь өмнөх жилд хүрсэн үр дүнгээ ингээд хянуулдаг байя, энэ төсвийн гүйцэтгэлийн процесст энийг оруулъя гэдэг заалт нь дагасан тогтоолд оруулчихсан ийм нэг заалтууд байгаад байгаа юм. Тэгэхлээр энэ асуудлууд бол проблем гарч ирчхээд байгаа, бид шийдэх гээд үзэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

Г.Лувсанжамц: Асуудлыг шийдэлтэй нь цуг тодорхой, товчхон хариулсан Сангийн яаманд баярлалаа. 26 оноос үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлт, мөн хяналт үнэлгээ гэдэг тогтолцоог бүрэн дүүрэн хэрэгжүүлнэ гэсэн хариултыг хэллээ. Тэгээд ирэх жилийн төсвийг намар хэлэлцэнэ. Тэр үедээ та бүхэн маань энэ хэлсэн амлалтаа хүрээд, татвар төлөгчдийн мөнгийг үр ашигтайгаар зарцуулах тогтолцооны өөрчлөлтийг төсвийн төсөл дээрээ оруулж ирэхийг хүсэж байна.

Эцэст нь нэг уриалга хэлье. Бид төр түмэндээ тангараг өргөөд өнөөдөр нэг жил болж байна. Засгийн газар цаашид үр дүнд суурилсан төсөв, төлөвлөлт, хяналт үнэлгээнд анхаарах, харин Улсын Их Хурал үр дүнд суурилсан засаглалыг бэхжүүлэхэд анхаарч, ухаанаа уралдуулж, бодлогын мэтгэлцээн өрнүүлж, нам харгалзахгүйгээр хамтарч ажиллахыг бусад гишүүдээсээ уриалж байна.

Д.Амарбаясгалан: Уриалгыг дэмжиж байна. Манай Лувсанжамц гишүүний нөгөө ажлын хэсэг ажиллаж байгаа тийм ээ? Тийм, ажлын хэсгийн дүгнэлт гарвал Засагтай хамтарч ажиллах нөхцөлүүд бүрдэх байх гэж бодож байна. Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Баярмаа: Лувсанжамц гишүүнтэй ёстой санал бүрэн нийлж байна. Яг бараг хэлэх гэж байсан шахам үгийг хэлчихлээ. Тэгээд төсвийн орлогын бараг 95, 6 хувь нь татвар төлөгчдийн мөнгөөр бүрддэг. Нэг ёсондоо бид хүмүүсээс баахан мөнгө татаад, тэгээд тэрийгээ ер нь юунд зарцуулаад байгаа юм бэ гэдгийг өнөөдөр хэлэлцэж байгаа ийм үе явж байна. Тэгэхээр хүний юмаар хүүдгэнэсэн эсэхийг л нэг ёсондоо бид өнөөдөр иргэддээ эргэж тайлагнах ёстой. Гэтэл манай Улсын Их Хурлын гишүүд маань бас байхгүй байна. Энэ хамгийн төсөв хэлэлцэхээсээ илүү

гүйцэтгэл хэлэлцэх нь хамгийн чухал гэж үздэг гэж би түрүүчийн удаа ярьж байсан. Тэгэхээр маш харамсалтай байна.

Яагаад гэхээр энэ их мөнгийг 2021 онд 15,6 их наяд, 22 онд 18,1 их наяд, 23 онд 22,5 их наяд, тэгснээ 24 онд шууд 30,3 их наяд, 7 их наядаар нэмэгдчихсэн. Энэ яах вэ нөгөө сонгуулийн жил гээд бас сонгуулийн санал худалдан авалтад төрийн хүч, нөөцийг зарцуулж байгаа ийм хэлбэрийн нэг илэрхийлэл л дээ. Тэгснээ 25 онд 35,8 их наяд болгож ирснийг нь тэмцэж байж 33 болгосон. Ингээд сүүлийн 4 жил буюу Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн үед нийт 120 их наяд төгрөг зарцуулсан байна. Энэний бараг 95, 96 хувь нь татвар төлөгчдийн махаа идэж, ёстой хуйхаа маажиж байж төлсөн мөнгө. Тэгээд энэ их мөнгөний үр дүн яг юу болсон бэ? Салбар салбараар бид ер нь ярих ёстой юм биш үү? Уул уурхайн салбар юу болов, ямар амжилт, дэвшил гарав, хөдөө аж ахуйн салбар яав, боловсролын салбарт ийм их мөнгө зарсны үр дүнд ямар үр дүн гарав, юу болов, авлига, авлигатай тэмцэх энэ үе, энэ салбарт хэдэн төгрөг зарцуулсан юм, ямар үр дүн гарав гээд ингээд ёстой жинхэнэ шахаад, шахаад, шалгаад, шалгаад уг нь ярилцах ёстой санагдах юм. Тэгэхгүй бол энэ чинь бид татвар төлөгчдийн мөнгөөр зүгээр жаалж байгаа юм шиг л болж хувирч байна шүү дээ. Эргээд тайлагнал байхгүй. Тэгэхээр эндээ маш их ач холбогдол өгч бүр хэдэн өдрөөр хэлэлцэж, ер нь цаашид бид яг олон нийтээр бас хэлэлцүүлэх ёстой юм байна лээ. Олон нийтэд энийгээ тавиад, тодорхой хугацаа өгөөд хэлэлцүүлэхгүй бол нөгөө татвар төлөгчид нь ч гэсэн өгсөн мөнгөнийхөө араас явдаггүй, нөгөө зарцуулсан этгээдүүд нь ч гэсэн тайлагнадаггүй нь ингээд.

Эндээс би 2 асуулт асуучихъя. Энэ санхүүгийн нэгтгэсэн, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд жишээлбэл 23 онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 13,7 их наяд төгрөг зарцуулсан байна. Энэ мөнгөн гүйлгээний тайлан. Гэтэл 24 онд 34,3 их наяд, энэ чинь бараг 2,5 дахин их юм уу, асар их хэмжээгээр нэмэгдчихсэн байгаа байхгүй юу. Энэ яг ямар учиртай юм бэ? Яагаад 13.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Ж.Баярмаа: Ингээд 34,3 их наяд болчихов? Энийг маш сайн яг дэлгэрэнгүй тайлбарлаад өгөөч. Хэнээр, ямар ажил гүйцэтгүүлчихэв? Яагаад ийм их эрс 2 дахин нэмэгдчихэв?

Дээрээс нь дахиад татвар төлөгчдийн мөнгө л гэж яваад байгаа шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгийг ингээд үрэн таран хийдэг юм уу, яадаг юм ингээд авлага үүсчихсэн. Жишээлбэл энэ тайланд дахиад 6,4 их наядын авлага байсан байгаа юм 23 онд. Гэтэл энэ чинь зүй нь авлагаа барагдуулаад, энэ тоо чинь багасах ёстой атал бүүр нэмэгдчихсэн, 6,8 их наядын авлага. Энэ өр авлагынхаа араас явдаггүй юм уу? Энэ авлагаа барагдуулах ажлыг ер нь яаж хийв, ямар үр дүнд хүрэв? Яагаад хасагдах биш, авлага чинь улам нэмэгдээд байна вэ? Өмнө нь миний санаж байгаагаар 23 оны гүйцэтгэлийг хийхэд 73 тэрбум төгрөгийг хэрэггүй бараа, хугацаа нь дуусчихсан бараанд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн яамны Санжаадорж дарга дарга хариулт өгөх үү? 4 дүгээр индэр.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Баярмаа гишүүний асуултад хариулъя. Гишүүний тавьж байгаа

саналтай би 100 хувь санал нэг байгаа. Энэ агуулгаар бид 1 дүгээрт мөнгөн хөрөнгийг зөв, буруу зарцуулсан асуудал нь нэг асуудал байгаад байгаа юм. Тухайн зориулалтаас тухайн зориулалтад зөв гарсан уу, үгүй юу гэдэг асуудал. Гэтэл нөгөө талдаа ямар үр дүнд хүрсэн бэ гэдэг асуудал өөрөө хамаагүй энэнээсээ том асуудал. Тэгэхдээ энэ хоёрыг зэрэг бид ярьж байх ёстой болчхоод байгаа юм. Одоо бол юу гэдэг юм хүүхдийн мөнгөнд тэдэн төгрөг зарцуулсан гээд нийт дүнг л яриад байгаа боловч, энэ маань өөрөө өрхийн орлогод яаж нөлөөлсөн юм бэ, гэмт хэргийн зөрчил дээр яаж нөлөөлсөн юм бэ, хүүхдийн боловсролд яаж нөлөөлсөн юм бэ гэдэг үр дүнг нь давхар ярьж явах ёстой болчхоод байгаа юм. Гэтэл энэ маань өөрөө орж ирэхгүй болчхоод байгаа учраас бид зөвхөн мөнгөн хөрөнгө дээр эргэлдэж ярьчихаад байгаа ийм асуудал байгаа.

Тэгэхлээр энэ асуудлыг Засгийн газрын зүгээс бид Үндэсний аудитын газартайгаа хамтраад өөрчлөх гээд хичээж байгаа. Хэд хэдэн байгууллага дээр Үндэсний аудитын газраас болон манайхаас хамтарсан сургалтууд өнгөрсөн 2 жилийн хувьд хийсэн. Тэгээд 4 яаман дээр, 5 яаман дээр бид энэ аргыг хэрэглэх гээд үзэж байгаа. Гэхдээ тийм нааштай үр дүн хараахан одоогийн байдлаар үзүүлж чадаагүй байна. Ирэх жилийн төсөв дээр энийгээ хийгээд явна. Сая бид энэ төсвийн тодотголтой хамт Улсын Их Хурлаас Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төсөл өргөн барьсан байгаа. Тэр тогтоол дээр яг энэ үр дүнг нь гүйцэтгэлтэй нь хамт нэг part болгож, төсвийн ерөнхийлөн захирагчид өөрөө тайлбарладаг байх ийм агуулга орж ирсэн байгаа.

2 дугаар асуудал дээр болохлоороо аудитын хийсэн мөнгөн гүйлгээний тайлан бол өөрөө та ингээд дээд талыг нь харвал энэ нөгөө Засгийн газрын нэгдсэн тайлан учраас өөрөө энэ төсвийн ерөнхийлөн захирагч болгон хариулбал уг нь их зүгээр байгаад байгаа юм. Яг улсын төсөв дээрээс зарцуулж байгаа нь 2024 оны хувьд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж бол 1 их наяд батлагдсан байгаад байгаа. Тэрний өмнөх жилд 1,5 их наяд ингээд батлагдаад явж байсан. Тэгэхлээр тэр хэсэг нь төсөв дээрээс ингээд явчхаж байгаа юм. Бусад хэсэг нь өөрөөр хэлбэл төрийн өмчит компаниуд, уул уурхайн компаниуд гээд түрүүний таны хэлж байсан юу байсан учраас салбарууд нь өөрсдөө хариулах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

3 дахь асуудал бол өр авлагын хэмжээ жилээс жилд асар ихээр нэмэгдэж байгаа нь үнэн. Энэ асуудал дээр хуулиараа өр авлага аль алийг нь үүсгэж болохгүй гэхихсэн байгаа. Тухайн жилийн батлагдсан төсөвтөө тухайн жилийн тавьсан зорилтдоо л нийцүүлж, тухайн тэр төрийн байгууллага, төсвийн байгууллага ажиллах ёстой гэххээд байгаа боловч энэ нь өөрөө алдагдаад байгаа. Нэг талдаа энэ дээр санкцын асуудлыг бид Сангийн яамны зүгээс, Засгийн газрын зүгээс оруулж ирсэн байгаа. Нөгөө талдаа санкцаас гадна бид нэг зүйл бол асар ихээр дутагдаж байгаа нь энэ зааж зөвлөх энэ хэсэг бол дутагдаж байна гэж үзээд байгаа. Өөрөөр хэлбэл манайх Сангийн яаман дээр уг нь дотоод аудитын нэгж ажиллаж байгаа. Гэхдээ энийг бид илүү өргөн хүрээнд ажиллах, аудитын байгууллага бол зөвхөн хагас жил, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлан дээр ажилладаг бол наана нь эрсдэлээс сэргийлэх энэ ажил дээр нь хяналт тавих асуудлыг салбар яамнууд илүү хүчтэй хийж, ажиллаж байж энэ асуудлаас бид гарах юм байна. Зөвхөн санкцаар тавиад, санкцтай болоод орхихгүйгээр ингэж ажиллах боломжтой байна гэж харж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Ойлголоо. Энэ 13,7 их наяд, ямар ч төрийн өмчит компани хамрагдсан бай, хамрагдаагүй бай 13,7 их наяд байсан чинь нэгхэн жилийн дараа 2,5 дахин нэмэгдээд, 34,3 их наяд болсон байна гэдэг аймшигтай тоо шүү дээ. 34,3 их наядын 1,4 нь л зөвхөн төрийн захиргааны байгууллагууд яам, тамгын газар юм шиг гэж ойлголоо сая. Тэгэхээр цаана нь дахиад 33 их наядын мөнгөн гүйлгээ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид орчихсон яваад байгаа юм. Тэгэхээр энэ чинь төсөвтэйгөө тэнцүү хэмжээний ийм их наядын мөнгөн гүйлгээ төрийн өмчит компаниудаас хийгдээд байна гэсэн үг үү? Энэ ер нь төсөвтэй тэнцүү хэмжээний ийм их мөнгө ингээд явж байна гэдэг чинь ямар үзэгдэл юм бэ? Эрүүл үзэгдэл мөн юм уу, үгүй юм уу? Би ерөөсөө бүүр гайхаад байна. Яг төсөвтэй яг адилхан дүнтэй болчихоод байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Санжаадорж дарга 4 дүгээр индэр.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. 13,7-г нь яг ингээд хуваагаад задлаад харвал төсвийн байгууллагууд буюу Улсын Их Хурал дээрээс баталж байгаа байгууллагуудын хувьд 949,7 тэрбум төгрөг байна. Нөгөө 1 их наяд баталснаасаа гүйцэтгээрэй. Тэгээд масс том дүн нь юу байна гэхлээр татварын, төрийн өмчит үйлдвэрийн газрууд дээр 4.9, 4 их наяд 992 тэрбум төгрөг гэж нэг ангиллаар орж ирж байна. Дээр нь энэ нь бол татварын байгууллагад төлсөн гэдгээр орж ирж байна. 2 дахь нь бусад мөнгөн зарлага гэдгээр орж ирж байна, төрийн өмчит бас үйлдвэрийн газруудын. Энэ нь 7 их наяд 541,4 тэрбум төгрөг гээд ийм 2 том тоо орж ирж байна. Ингээд задаргаа нь гарч ирж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгөх, аудитаас өгөх үү, үгүй юу Магнайсүрэн дарга? Тэгвэл Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэ сая Эдийн засгийн байнгын хороон дээр эрчим хүчний асуудлаар бас нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл өргөн мэдүүлсэн байгаа. Тэгээд энэ асуудлыг өнөөдөр хэлэлцэх ёстой юу, дараагийн чуулган дээр хэлэлцэх боломжтой юу гэдгийг түр тодруулаадахъя 2 минутын дотор. Байнгын хорооны дарга хаана байна вэ? Санал хураалтыг маргааш явуулна. Ажлын хэсгийнхэнд талархал дэвшүүлье.

19.47 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА